

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЗҮЙ

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЗҮЙ



Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365
☎ +976-11-329361

✉ mongolia.secretary@savethechildren.org
🌐 www.savethechildren.mn
📘 Save the Children in Mongolia
🐦 Save the Children MN



НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЗҮЙ

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудад
зориулсан гарын авлага

Улаанбаатар
2019 он

Боловсруулсан: П. Цэдэндамба
Б. Эрдэнэцэцэг
Э. Оюунмаа
Редактор: Б. Батсүрэн
Б. Дарьханд
Эхийг бэлтгэсэн: Х. Балдандорж
Зургийг: Г. Ганбаяр

ISBN код:

© Хүүхдийг Ивээх Сангийн зөвшөөрөлгүйгээр хувилах, дахин хэвлэхийг хориглоно.

БИДНИЙ ЭРМЭЛЗЭЛ

Хүүхэд бүр эсэн мэнд байх, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг дэлхий ертөнцийг цогцлоохыг бид эрмэлзэнэ.

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүүхдэд чиглэсэн дэлхий нийтийн хандлагад эргэлт хийж, хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө бид хүчин зүтгэнэ.

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС



ХАРИУЦЛАГА

Бид хүүхдүүд, дэмжигч, хамтрагчдынхаа өмнө ил тод, хариуцлагатай, нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан, хэмжигдэхүйц үр дүнд хүрэх үүргийг хүлээнэ.



БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ

Бид шинэ санаа санаачлагад нээлттэй, өөрчлөлтөд бэлэн, эрсдэлд ухаалаг, зоримог байж, хүүхдүүдийн хамтаар тэдний төлөөх тогтвортой шийдлийг боловсруулна.



ТЭМҮҮЛЭЛ

Бид өөрсдөдөө болон хамтрагчдадаа өндөр шаардлага тавьж, өндөр зорилго дэвшүүлэн, хүүхдийн төлөөх үйл ажиллагааныхаа чанарыг ямагт сайжруулахад тэмүүлнэ.



ШУДАРГА БАЙДАЛ

Бид үнэнч шударга байдал, хувийн зан төлөвийн хамгийн өндөр хэм хэмжээг сахина. Бид хэзээ ч нэр төрөө үл сэвтээж, ямагт хүүхдийн язгуур эрх ашгийг эрхэмлэн ажиллана.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бид бие биенээ үнэлж хүндлэн, ялгаатай байдалдаа өсөн дэвжиж, нэгдмэл хүүхдүүдийн амьдралд өөрчлөлт бий болгохын тулд хамтрагчидтайгаа түншилж ажиллана.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	6
БҮЛЭГ I. “НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК” НЬ ОРОЛЦООНЫ ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ	7
Сэдэв 1. “Нийгэмшүүлэх цирк”-ийн үүсэл хөгжил	8
Сэдэв 2. “Нийгэмшүүлэх цирк”-ийн зорилтууд	11
Сэдэв 3. “Нийгэмшүүлэх цирк”-ийн үндсэн зарчмууд	15
Сэдэв 4. “Нийгэмшүүлэх цирк” Монгол Улсад	18
БҮЛЭГ II. НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШ, НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮҮРЭГ	20
Сэдэв 1. Дасгалжуулагч багшийн ур чадвар, үүрэг	21
Сэдэв 2. Нийгмийн ажилтны ур чадвар, үүрэг	26
Сэдэв 3. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтны хамтын ажиллагаа	28
Сэдэв 4. Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш болон нийгмийн ажилтны ёс зүй	37
Сэдэв 5. Сургалтын аюулгүй байдлыг хангах нь	41
БҮЛЭГ III. ЦИРКИЙН ҮНДСЭН ТӨРЛҮҮД, ДАСГАЛ ТЕХНИКИЙГ ЗААХ АРГАЗҮЙН ЗӨВЛӨМЖ	48
Сэдэв 1. Акробатын төрөл	49
Сэдэв 2. Гимнастикийн төрөл	70
Сэдэв 3. Жонглёрын төрөл	73
Сэдэв 4. Тэнцвэрийн төрөл	85
Сэдэв 5. Алиалал	88
Сэдэв 6. Энгийн материал ашиглан циркийн хэрэгсэл хийх аргачлал	90

БҮЛЭГ IV. “НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК” СУРГАЛТААР ХҮҮХДҮҮДЭД БЭРХШЭЭЛИЙГ СӨРӨН ТЭМЦЭХ ЧАНАРЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ	95
Сэдэв 1. Нийгэмшүүлэх цирк сургалтад оролцогч хүүхдүүдэд бэрхшээлийг даван туулах чанарыг хэрхэн эзэмшүүлэх вэ?	97
Сэдэв 2. Сэтгэлзүйн хамгаалалтын хүчин зүйл	100
Сэдэв 3. Бэрхшээлийг сөрөн тэмцэх аргууд	102
БҮЛЭГ V. ХҮНД НӨХЦӨЛ ДЭХ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАЙ АЖИЛЛАХ НЬ	110
Сэдэв 1. Хүүхдийн хөгжил	111
Сэдэв 2. Хүүхдийн насны үечлэл, хөгжлийн онцлог	113
Сэдэв 3. Хүчирхийлэл, үл хайхрах байдлын хүүхдэд үзүүлэх нөлөө	119
Сэдэв 4. Нийгэмшүүлэх цирк сургалтыг хүүхэд хамгааллын үйлчилгээний практикт хэрэглэх нь	121
БҮЛЭГ VI. “НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК СУРГАЛТЫГ” ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ	127
Сэдэв 1. Сургалтын аргазүйн зарчмууд	128
Сэдэв 2. Сургалтын бэлтгэл	129
Сэдэв 3. Сургалт зохион байгуулах үйл явц	139
Сэдэв 4. Нийгэмшүүлэх цирк сургалтыг заах аргазүйн зөвлөмж	144
Ном зүй	146

ӨМНӨХ ҮГ

2000 оноос Хүүхдийг Ивээх Сан, Канад улсын “Нарны цирк” корпорацын дэмжлэгтэйгээр “Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлж ирлээ. Уг хөтөлбөр нь хүнд нөхцөлд амьдарч буй хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, бие даасан байдлыг дэмжих, амьдрах ухаанд сурган, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх зорилготой хөтөлбөр юм.

Энэ хугацаанд Нарны циркээс зохион байгуулсан сургалтууд, хуримтлуулсан амжилт, туршлага дээр үндэслэн танд толилуулж буй энэхүү гарын авлагыг амьдралын аливаа сорилт бэрхшээл дундаас өөрийгөө олохоор тэмцэж буй хүүхэд залуусыг циркийн урлагаар дамжуулан дэмжин туслах, нийгэмшүүлэх зорилгоор тэдэнтэй ажилладаг дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудад зориулав. Энэхүү гарын авлага нь хувь хүний итгэл үнэмшилд тулгуурлан, бие хүний чадварыг хөгжүүлэх зорилгыг агуулсан бөгөөд сургалтыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах онолын мэдээллүүд, мөн түүнийг хэрэгжүүлэх аргазүйн тулгуур мэдээллүүдийг хослуулан багтааснаараа онцлогтой юм.

Олон улсын Хүүхдийг Ивээх Сан байгуулагдсаны 100 жил, Монгол Улсад үйл ажиллагаагаа 1994 оноос хэрэгжүүлж эхэлсний 25 жилийн ойг энэ онд тэмдэглэж буй мөчид энэхүү гарын авлага хэвлэгдэж байна. Хүүхдийг Ивээх Сан нь нийгэм, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт, онцгой байдлын үеэс урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад хүүхдийг хамгаалж, хүүхдийн эрхийг цогцоор нь хангахыг дэмжин ажиллаж ирсэн. Бид хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан, тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олох аргазүйг эрхэмлэн ажилладаг.

Эрхэм сурган хүмүүжүүлэгч та бүхэндээ 21-р зуунд бие даан тасралтгүй хөгжих, бусдын төлөө үйлчлэн амьдрах чадвар бүхий дэлхийн иргэн төлөвшүүлэх их үйлсэд амжилт хүсье.

*Б.Дарьханд,
Хүүхдийг Ивээх Сангийн хүүхэд хамгаалал,
хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн менежер*



© Хүүхдийг Ивээх Сан

БҮЛЭГ I.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК НИЙГМИЙН ОРОЛЦООНЫ ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

Цирк гэдэг үгийг сонсмогц бидэнд инээд хөөр, баяр баясал, ид шид, сахилга бат, аз туршилт, эр зориг, сандрал догдлол төсөөлөгддөг. Циркэд дургүй хүн үгүй, хүүхэд бол бүр ч байхгүй биз ээ.

СЭДЭВ 1.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Хүүхэд, залуусыг хүндлэн дээдлэх хэмээх ойлголтыг амьдралд бүрэн утгаар нь хэрэгжүүлэхэд олон нийтийн анхаарлыг хандуулах нь “Нийгэмшүүлэх цирк” сургалтын аргазүйн тулгын чулуу билээ. Энэхүү аргазүй нь хүүхэд залууст өөрийн нөөц бололцоог бүрэн дайчлан ажиллах боломжийг олгодог. Оролцоо, шударга ёс, тэгш байдал нь “Нийгэмшүүлэх цирк”-ийн үндсэн тулгуур юм.

Тиймээс энэхүү гайхамшигт урлагаар дамжуулан, хүүхэд залуусыг нийгэмшүүлэх зорилго бүхий онцгой хөтөлбөрийг анх 1995 онд Канадын Квебек хотод төвтэй олон улсын “Нарны цирк” корпорац, олон улсын хамтын ажиллагааны “Дэлхийн залуус” төрийн бус байгууллага хамтран санаачилжээ. Хөтөлбөр нь циркийн урлагт суурилан суралцагчдын өөрийн итгэл үнэмшил, бусадтай харилцах харилцаа, шинэ орчин нөхцөлд дасан зохицох, бэрхшээлийг даван туулах, хамтран ажиллах зэрэг чадваруудыг хөгжүүлэх замаар эцэг эхийн хайр халамж дутагдсан, зүй бус харьцаа, хүчирхийллийн хохирогч болсон, сургууль завсардсан, тусгай хэрэгцээтэй гэх зэргээр эрсдэлтэй, хүнд нөхцөлд амьдарч буй хүүхэд залуучуудад туслах үндсэн зорилготой юм.

Хүүхэд, залуус энэхүү сургалтад хамрагдсанаар циркийн арга техникт суралцах төдийгүй нийгмийн харилцааны эерэг дадал чадваруудыг эзэмшдэг. Түүнчлэн суралцагчдад бүлгээр ажиллахын давуу талыг мэдрэх, тэсвэр хатуужилтай байх, бусдыг сонсох, хүндлэх, өөртөө итгэх итгэлийг олох, бусдад итгэх итгэлийг нэмэгдүүлэх замаар нийгмийн амьдралд оролцох боломжийг нэмэгдүүлдэг.

Хүүхэд залуусын нийгэмшлийг дэмжих бусад аргуудаас ялгаатай нь оролцогч төвтэй бүлгийн сургалтыг дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хамтран удирдан чиглүүлдгээрээ онцлогтой.

1990 онд Бразил Улсад хараа хяналтгүй хүүхэд, залуусын хөгжлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлсэн “Хэрвээ энэ миний гудамж байсан бол ...” төслөөр “Нийгэмшүүлэх цирк” сургалтын аргазүйн эхлэл тавигджээ. Улмаар 1993 онд “Дэлхийн залуус” төрийн бус байгууллага, Канад, Бразил, Чили зэрэг улсуудын

Төрийн бус байгууллагуудтай хамтран “Хараа хяналтгүй хүүхэд, залуусын урлагийн холбоо”-г үүсгэн байгуулсан. 1995 онд “Нарны цирк”-ийн сургагч багш нараар удирдуулсан сургалтын баг Өмнөд, Хойд Америкийн хотуудад хоёр долоо хоногийн хугацаагаар циркийн сургалтыг зохион байгуулсан байна. Тэдний үйл ажиллагаа улам бүр хүрээгээ тэлж “Эдоуб” сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хараа хяналтгүй хүүхдүүдийн өдөр тутмын амьдрал, тэднийг циркийн сургалтад хэрхэн оролцож байгааг харуулсан “Цирк хотод ирэх үеэр” хэмээх баримтат киног бүтээн нийтийн хүртээл болгов.

Өмнөд Америкийн Ресиф, Сантьяго хотуудад зохион байгуулсан сургалтад оролцогч хүүхэд, залуус анх удаа “Хүүхдийн их наадам”-д оролцсон нь олон нийтийн анхаарлыг ихэд татсан байна. Их наадмын дараагаар түншлэгч байгууллагууд хараа хяналтгүй¹ хүүхдүүдэд зориулан зохион байгуулсан сургалтаа үнэлэн, цаашдын үйл ажиллагааны цар хүрээгээ тодорхойлох уулзалтыг *Монреаль* хотноо өргөн хүрээнд зохион байгуулжээ. 1996 онд “Хараа хяналтгүй хүүхдийн урлагийн холбоо” нь “Дэлхийн цирк” болон өргөжиж, нийгэмшүүлэх циркийн сургалтуудыг зохион байгуулж, хөтөлбөрийн чанар, үр нөлөөг тасралтгүй үнэлэн боловсронгуй болгосоор дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлж байна.

“Нийгэмшүүлэх цирк” сургалтын зорилго нь суралцагч хүүхэд, залуусыг зөвхөн циркийн урлагт сургах бус харин циркээр дамжуулан тэдний өөрийн үнэлэмж, бусдад итгэх итгэлийг нь дэмжин тэтгэж, нийгмийн амьдралд оролцох ур чадварыг дээшлүүлэхэд чиглэдэг. Түүнчлэн, тэднийг нийгмийн идэвхтэй иргэн байж, бүтээлч сэтгэлгээгээ илэрхийлэх, нөөц

“Нийгэмшүүлэх цирк” нь циркийн урлагт суурилсан хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих аргазүй бөгөөд хүүхэд залуучууд болон олон нийтэд эерэг өөрчлөлт гаргах асар их боломж юм.

чадамжаа нээхэд нь тусалснаар хувь хүний болон нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулахыг зорилгоо болгодог гэдгээрээ онцлог. Энэ нь Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасанчлан: “иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвар төлөвшүүлэхэд боловсролын зорилго оршино” хэмээн тодорхойлсонтой ч нийцэж байна.

¹ Хараа хяналтгүй хүүхэд гэдэг нь эцэг эх, халамжлан дэмжих хүнгүйгээр 2 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар гудамжинд явж байгаа хүүхдийг хэлнэ. О. Мягмар, М. Нямдорж, З. Ариунбилэг, Б. Сүх-Очир, “Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ ба нийгмийн ажил”, УБ 2002 он, 107 тал, 20 дугаар зууны эхэн үеэс хөгжингүй орнуудад дайн болон аж үйлдвэрийн хөгжилтэй холбоотойгоор харж хандах, асран хамгаалах хүнгүй хүүхдүүд олноор бий болсон. Энэ ойлголт нь 1980 оноос эхлэн дэлхийн ихэнх орнуудад үүссэн. Эдгээр хүүхдүүд нь тухайн орнуудын ядуурал, ажилгүйдэл, нийгмийн шударга бус байдал, үндэсний хямрал, нийгмийн үнэт баялаг сүйрэлд орсоны хамгийн наад захын жишээ бөгөөд ихэнх орнуудад эдийн засгийн сөрөг үр дагавар болдог. Хараа хяналтгүй хүүхдийн физиологийн хэрэгцээнээс эхлээд бүх түвшний хэрэгцээ хангагдаагүй, эрх нь зөрчигдсөн байдаг.

Нийгэмшүүлэх цирк хөтөлбөр нь дараах чиглэлээр суралцагчдынхаа хөгжлийг дэмждэг.

Хүснэгт 1

ЧИГЛЭЛ	ӨӨРЧЛӨЛТҮҮД
Бие бялдрын хувьд	<ul style="list-style-type: none">• Хурд, хүч нэмэгдэх, тэнцвэртэй болох• Уян хатан болох• Булчин шөрмөсний хөгжил жигд явагдах• Тэсвэр хатуужил суух• Алхаа, гишгээ цэгцрэх• Өөрийн бие эрхтэний боломж, хязгаарлагдмал байдлыг мэдрэх• Хөдөлгөөний эвсэл сайжрах• Хэл ярианы чадвар сайжрах зэрэг
Сэтгэлзүйн хувьд	<ul style="list-style-type: none">• Анхаарлаа төвлөрүүлэх чадвар сайжрах• Өөрийн сэтгэл хөдлөлөө хянан жолоодох• Айдас, бэрхшээлийг даван туулах сэтгэлийн хат суух• Бусдыг сонсох чадвар нэмэгдэх• Өөртөө болон бусдад итгэх итгэл нэмэгдэх• Хүсэл мөрөөдөл, зорилготой болох• Хувийн сахилга батыг чухалчлах• Бүтээлчээр сэтгэх чадварыг хөгжүүлэх зэрэг
Нийгэмшихүйн хувьд	<p>Бие хүний шинж чанаруудын төлөвшил, хүмүүс хоорондын харилцааны ур чадварууд. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none">• Бусдыг хүлээцтэй сонсох, багаар хамтран ажиллах• Зөрчил, маргааныг эв зүйгээр зохицуулах, эерэг шийдвэр гаргах• Өөрийгөө хамт олны нэг чухал хэсэг гэдгээ мэдрэх• Аливаад авах гээхийн ухаанаар хандах• Өөрийн үзэл бодлыг бусадтай хуваалцах• Өөрийн сул талаа илрүүлэн ур чадвар, авьяас билгээ хөгжүүлэх• Цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх• Хувийн сахилга баттай байх, нийгмийн хэм хэмжээ, дүрэм журмын дагуу биеэ авч явах• Хариуцлагаа ухамсарлах• Нийгмийн амьдралд оролцох чадвар, дадлыг хөгжүүлнэ.

Хөгжлийн эдгээр өөрчлөлтүүд нь харилцан бие биеэсээ хамааралтай бөгөөд салангид хөгжих боломжгүй юм.

СЭДЭВ 2.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ЗОРИЛТУУД

Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд тусална:

Эрсдэлтэй, хүнд нөхцөлд амьдарч буй хүүхэд залуучууд ихэвчлэн өөртөө итгэх итгэл сул байх нь түгээмэл. “Нийгэмшүүлэх цирк” сургалтын гол зорилтуудын нэг нь суралцагчдад өөрийн үнэлэмж, өөртөө итгэх итгэлийг бий болгон түүнийг нь аажмаар ахиулан хөгжүүлэхийг зорьдог. Суралцагч өөрийн үнэлэмж, давуу талаа мэдрэн ойлгосноор аливаа бэрхшээлийг даван туулах чадвар эзэмшинэ. Энэхүү зорилгод хүрэхэд дасгалжуулагч багш, нийгмийн ажилтны дэмжлэг, хамтын ажиллагаа маш чухал юм.

Бие даасан байдал, хувийн зохион байгуулалтыг хөгжүүлнэ:

Жонглёр, тэнцвэр, алиалал гэх мэт циркийн аль ч төрөл нь тухайн техникийг зөв хийж сурахад суралцагчаас удаан хугацааны уйгагүй давталтыг шаарддаг. Энэ нь суралцагчийг аажмаар тэсвэр, хатуужил тэвчээрт сургадаг. Дасгал техникийг давтан хийх бүрт алдаагаа засах, өмнөхөөсөө илүү сайн гүйцэтгэхийг эрмэлзэх нь тэдэнд өөрийгөө удирдах, идэвхжүүлэх, дотоод нөөцөө дайчлах боломжийг олгодог. Нөгөө талаас сахилга баттай байх, анхаарлаа төвлөрүүлэх, сэтгэлийн хөдөлгөөнөө хянан жолоодох, айдсаа даван туулах зэргээр сэтгэлзүйн болон ёс суртахууны үндсэн чанарууд төлөвшихөд нөлөөлдөг.



СЭТГЭГДЭЛ:

Циркийн тэнцвэрийн төрөл болох “катюшка”¹ дээр тэнцэж дөнгөж сурч байлаа. Хэрчим цилиндр дээрх хавтгай модон дээр анх удаа хоёр хөл дээрээ тэнцэн зогсох тэр үед маш хэцүү санагдаж байсан. Гэвч би өөртөө “Би унахгүй юм шүү” гэж дахин дахин хэлж хажуугаас сургагч багш хэрхэн тэнцэн зогсохыг зааж зоригжуулж байв. Олон удаа уйгагүй оролдож тэнцвэрээ олж сурсаны дараа үнэхээр би үүнийг хийчихлээ, би чадлаа гэж өөрөөрөө бахархах мэдрэмж өөрийн эрхгүй төрдөг юм билээ.

Ц. Цэцэгтуяа. Сүхбаатар дүүргийн Албан бус/насан туршийн боловсролын төвийн “Нийгэмшүүлэх цирк” сургалтын дасгалжуулагч багш

² Катюшка гэдэг нь циркийн тэнцвэрийн төрөлд өргөнөөр хэрэглэдэг богино хэрчим цилиндр дээр байрлуулсан тавцан дээр тэнцэн үзүүлбэр үзүүлэх зориулалт бүхий циркийн хэрэгсэл юм.

Бүлгийн хөгжлийг дэмжинэ:

Цирк нь суралцагч бүр харилцан бие биедээ туслах, хүн бүрийн оролцоотойгоор бүлгийн амжилт, үр дүн нь үнэлэгддэг, хамтын хөдөлмөрийн урлаг юм. Ийм учраас “Нийгэмшүүлэх цирк” нь суралцагчдадаа багаар ажиллахын давуу тал, хувь хүн бүрийн үүрэг, хариуцлага, харилцан хамаарлыг ойлгуулахад чухал ач холбогдолтой. Суралцагчид бүлэгт харьяалагдсанаар тодорхой дүрэм, журмыг баримтлах, бусдыг хүндлэх, сайн сонсогч байж, бие биеэ дэмжих нь тэдэнд өөрсдийгөө салангид хувь хүмүүс биш харилцан хамааралтай нэгдмэл нэг бүлэг гэсэн ойлголтыг аажмаар төлөвшүүлэхэд нөлөөлдөг.

Жишээ нь: Циркийн пирамид буюу хүн овоолго хийхэд түүнд оролцож буй хүн бүр хамтын нэг зорилго дэвшүүлэн, хэдэн хүн оролцсон ямар хэлбэрийн овоолго хийхээ урьдчилан ярьж ойлголцож, хэн нь хаана байрлаж ямар үүрэгтэй байхаа тохирч өөр өөрийн гүйцэтгэх үүргийг тодорхой ухамсарласан байх нь чухал. Овоолгыг нураалгүй, хэн нэгнийгээ унагаж гэмтээхгүйн тулд хоорондоо эв нэгдэлтэй байж, өөрийн хүлээсэн үүргээ ягштал баримтлан дор бүрнээ хариуцлагатай байж, бие биедээ харилцан итгэсэн тохиолдолд л бат бэх овоолго босно. Циркийн зөвхөн нэг төрөл болох хүн овоолго хийх дасгалыг олон дахин давтсаны дүнд хувь хүний болон бүлгийн хөгжлийг дэмжих маш чухал ур чадваруудыг хөгжүүлэх боломжтойг энэхүү жишээнээс харж болохоор байна.

Циркийн дасгал, техникүүд нь суралцагчаас тодорхой ур чадварыг шаардахын зэрэгцээ суралцагч бүрт би бусдынхаа төлөө юу хийж чадах вэ гэсэн ойлголтыг төлөвшүүлэхэд тусалдаг.

Нийгэмшлийг дэмжинэ:

Сургалтаар аливаа зөрчил, тулгамдсан асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, санал бодлоо солилцох харилцааны таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх нь юунаас ч илүү чухал. Энэ нөхцөлийг бүрдүүлснээр өөр өөрийн гэсэн сонирхол, хүсэл эрмэлзэлтэй хувь хүмүүсийг нэгтгэх, хамтран шийдвэр гаргах чадварууд төлөвшдөг. Энэхүү чадваруудыг төлөвшүүлэн хөгжүүлж, зөв удирдан чиглүүлснээр хүүхэд залуучууд нийгмийн ардчилалд хүн бүрийн бодит эерэг оролцоо чухал гэдгийг ойлгодог. “Нийгэмшүүлэх цирк” сургалт нь суралцагчдадаа нийгэмд өөрийн байр сууриа эзлэх, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцохыг нь илүүтэй дэмждэг.

Бие бялдрын хөгжлийг дэмжинэ:

Циркийн төрөл тус бүр нь оролцогчоос бие бялдрын хувьд хүч чадал, хурд, тэнцвэр, уян хатан байдал, тэсвэр тэвчээрийг шаарддаг. Иймд суралцагчдынхаа бие бялдрын хөгжлийг дэмжихэд анхаарч дасгал, техникүүдээ чиглүүлдэг. Хүүхэд, залууст эрүүл амьдрах дадал төлөвшүүлэх, архи тамхи болон мансууруулах бодисын хэрэглээний хор уршгийг таниулан ойлгуулах замаар эрүүл мэндийн болон эрүүл ахуйн зөв дадал олгох мэдээллийг ч сургалтаар дамжуулан өгөх боломжтой.

Харилцааны ур чадварыг хөгжүүлнэ:

“Нийгэмшүүлэх цирк” сургалтад оролцогч зарим хүүхэд залуучуудын хувьд дотоод сэтгэл мэдрэмжээ илэрхийлэн өөрийн санаа бодлыг хуваалцах, бусадтай эерэг харилцаа холбоо тогтоох нь амаргүй. Сургалтын явцад хүүхдүүд хоорондоо болон дасгалжуулагч багш, нийгмийн ажилтантай харилцан ярилцах, дохио зангаа, үйлдэл хөдөлгөөн хийх зэргээр хүн бүр ямарваа нэгэн байдлаар харилцдаг. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд ч хүүхэд бүрийн харилцааг дэмжих зорилгоор нийгэмшүүлэх дасгал, тоглоомуудыг сургалтын хөтөлбөрт тусган ажилладаг.

Жишээ нь: Сургалт нь оролцогч өөрийн мэдрэмж, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, хоорондоо санаа бодол, туршлагаа хуваалцан ярилцах, тоглох, ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлөн ярилцах зэргээр эерэг харилцааны орчин нөхцөлийг бүрдүүлэхийг зорьдог. Гэхдээ хэл яриа нь харилцааны цорын ганц хэлбэр биш бөгөөд зарим оролцогчдын хувьд үйлдэл хөдөлгөөн, биеийн хэлэмжээр дамжуулан өөрийн үзэл бодлыг илэрхийлэх нь тохиромжтой ч байх ч үе бий.



СЭТГЭГДЭЛ:

Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд Хамгаалал хөтөлбөрийн хүрээнд хараа хяналтгүй хүүхдүүдэд халамж, хамгааллын шууд үйлчилгээ үзүүлэх өдрийн үйлчилгээний төвийг ажиллуулж байсан. Төв олон төрлийн сургалтын үйл ажиллагааг хүүхдүүдэд зохион байгуулж байсны нэг нь “Нийгэмшүүлэх цирк” сургалт. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд төвөөр үйлчлүүлэгч хүүхдүүдийн эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд анхаарч эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрийг цирк сургалттай уялдуулан хэрэгжүүлсэн нь ихээхэн үр дүнтэй байлаа.

Э. Оюунмаа. Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгаалал хөтөлбөрийн төслийн ажилтан.

Бүтээлч сэтгэлгээг дэмжин хөгжүүлнэ:

Циркийн уран бүтээл нь уламжлалт хэлбэрүүддээ тулгуурлан улам бүр баяжин хөгжиж байдаг. Сургалт нь оролцогчдодоо сургалтын явцад хэвшмэл байдалд баригдалгүйгээр шинээр сэтгэх, зохион бүтээх, үүнийгээ бусадтайгаа хуваалцан хамтран ажиллах замаар бүтээлч сэтгэлгээгээ аль болох бүрэн дүүрэн ашиглах боломжийг олгодог.

Нийгэмшүүлэх цирк сургалтын дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд сургалтын явцад суралцагчдын төсөөлөхүй болон харилцааны чадварыг хөгжүүлэх дараах энгийн аргыг өргөнөөр ашигладаг. Энэ нь суралцагчдыг тойргоор суулган циркийн дурын нэг хэрэгслийг ашиглан хүн бүр түүгээр юуг төлөөлүүлэн дүрслэн үзүүлж болохыг төсөөлүүлдэг. Дараа нь төсөөллөө үйлдлээр үзүүлэн бусдаараа таалгаж харилцан ярилцдаг.

Мөн циркийн техникүүдийг янз бүрийн хувилбараар хийх, ганцаарчлан болон бусадтайгаа хамтран ямар үзүүлбэрийг хийж болох талаар хэлэлцэх, түүнийгээ туршиж үзэх боломжийг олгон дэмжих зэрэг тоймгүй олон боломжууд циркт бий.

Эрсдэлийн менежментийг зөв удирдахад нь тусална:

Циркчдийн зарим үзүүлбэр нь аюултай, эрсдэлтэй хэдий ч тэд тэр бүр аюул осолд өртөөд байдаггүй. Учир нь циркийн уран бүтээлчид өдөр бүр бэлтгэл сургуулилтаа системтэйгээр хийж, сахилга батыгчанд мөрдөн, эрсдэлээ тооцон аюулгүй байдлаа ханган ажилладаг. Циркийн бүхий л төрөл нь харилцан хамаарал бүхий хамтын ажиллагаа байдаг. Иймд суралцагчдыг өөртөө болон бусдад санаа тавин халамжлах, эрсдэлтэй үзүүлбэр хийхдээ багаараа ярилцан шийдвэр гаргах зэргээр болзошгүй эрсдэлийг даван туулах чадавхыг дэмжин хөгжүүлдэг.

Нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжинэ:

Нийгэмшүүлэх цирк нь суралцагчдынхаа нийгмийн амьдралд эрчимтэй оролцох боломжийг олжнээхэд тусалдаг. Энэ нь дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан, гэр бүлийн гишүүд зэрэг хамтран ажиллагсдын хариуцлагатай хамтын ажиллагаанд тулгуурлана.

Ийнхүү “Нийгэмшүүлэх цирк” сургалтын зорилтуудаар дамжуулан суралцагчид дээрх ур чадваруудыг эзэмшсэнээр:

1. Бие хүн талаас:

Эрүүл чийрэг бие бялдартай, хэнтэй ч эвтэй харилцдаг, өөртөө итгэлтэй, өмнөө тавьсан зорилготой түүндээ хүрэхийн төлөө хичээдэг, тэмүүлдэг, төлөвлөдөг бие хүнийг төлөвшүүлэх;

2. Гэр бүлийн талаас:

Гэр бүлийн гишүүд нь харилцан бие биедээ итгэсэн, хүндэтгэсэн, гэр бүлийн ариун нандин холбоог эрхэмлэсэн, гэр бүлийн үнэ цэнийг ойлгож мэдэрсэн, үр хүүхдээ зөв өсгөн хүмүүжүүлэх арга барил, ухаантай, амьдралын аливаа асуудлыг эергээр харах алсын хараатай иргэн төлөвшүүлэх;

3. Нийгмийн талаас:

Дээрх хувь хүний болон бие хүний тодорхой чадваруудыг эзэмшсэн суралцагчид нь бие биеэ ялгаварлан гадуурхахгүй, хүний эрхийг дээдэлсэн эрүүл, ардчилсан, аюулгүй нийгмийг бүтээн цогцлоох хүч нөөц болох юм.

СЭДЭВ 3.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД³

“Нийгэмшүүлэх цирк” сургалт нь нийгмийн оролцооны арга хэрэгсэл болохын хувьд таван үндсэн зарчмуудад тулгуурлан өөрийн зорилго зорилтуудаа хэрэгжүүлдэг.

1. Аюулгүй хөгжилтэй орчин бүрдүүлэх зарчим

“Нийгэмшүүлэх цирк” нь суралцагчдад чөлөөтэй харилцах, суралцах, бүтээлч байдлаа хөгжүүлэх боломж бүхий тайван, аюулгүй орчныг бүрдүүлэхийг зорьдог. Энэ нь хүүхэд, залуус өөр хоорондоо зугаацан хөгжилдөх, циркийн эрсдэлтэй техникүүдийг туршиж үзэх, өөрт төрсөн мэдрэмжээ илэрхийлэх боломжийг бүрдүүлсэн орчин байх ёстой. Сургалтын орчин нь сургалт эхлэхээс дуусах бүхий л хугацаанд суралцагчдын сэтгэлзүйн болон материаллаг орчны талаасаа аюулгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Бие биеэ ялгаварлан гадуурхах, заналхийлэх, сэтгэл санааны болон бие махбодын хүчирхийлэл, аливаа

³ Лафортун.М, 2001, Циркийн дасгалжуулагч, түншүүдэд зориулсан гарын авлага

дарамт, шахалт, айлган сүрдүүлэлтээс ангид байхад дасгалжуулагч, нийгмийн ажилтнууд анхаарна. Сургалтын аюулгүй орчин бүрдүүлснээр суралцагчид аюулгүй гэдгээ мэдэрч тайван байгаа тохиолдолд тэдний суралцах үйл явц илүү эрчимтэй, идэвхтэй өрнөх болно.

2. Олон нийттэй харилцах зарчим

Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд залуучуудын хувьд ихэвчлэн гэр бүлийн зүгээс тэдэнд тавих анхаарал халамж сул, сургууль хамт олныхоо дунд зожиг ганцаардмал, нийтэч биш, олон нийтийн үйл ажиллагаанд төдийлөн оролцдоггүй, гадуурхагдсан байдалтай байх нь их.

“Нийгэмшүүлэх цирк” сургалт нь суралцагчид, тэдний гэр бүлийн гишүүд, насанд хүрэгчдийг сургалтдаа хамтад нь оролцуулах, үзүүлэх тоглолтуудаараа дамжуулан эзэмшсэн ур чадвараа олон нийтэд харуулах боломжийг олгодог. Ингэснээр гэр бүлийн гишүүд, насанд хүрэгчдээс хүүхдийн давуу тал, ур чадварыг олж харах, тэднээр бахархах боломжийг олгон насанд хүрэгчдийн зүгээс хүүхдүүдэд тавих халамж анхаарлыг нэмэгдүүлэх давуу талтай. Нөгөө талаар хүнд нөхцөл дэх хүүхэд залуусын талаарх нийгмийн сөрөг хандлагыг эергээр өөрчлөх, тэднийг ойлгон дэмжих боломжийг олгодог юм.

3. Өөрийгөө илэрхийлэх боломж олгох, бүтээлч байдлыг дэмжих зарчим

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд суралцагчдынхаа бүтээлчээр сэтгэх, бусдад өөрийн бодол санааг илэрхийлэх орон зай нөхцөл боломжийг бүрдүүлж байх шаардлагатай. Хүний үзэл бодол гэдэг нь хийсвэр зүйл биш. Хэрвээ бид өөр хоорондоо харилцахгүй, өөрийн юу бодож, ямар мэдрэмжтэй байгааг илэрхийлэх боломж олдохгүй бол ямар байх бол?

Америкийн гүн ухаантан, сэтгэл зүйч Уильям Жеймс “Миний амьдарч буй эрин цагийн хамгийн аугаа их нээлт бол хувь хүн үзэл бодол, сэтгэл санаагаа өөрчлөх замаар амьдралыг ч өөрчилж болдог гэдэг үнэнийг олж мэдсэн явдал юм” гэж тодорхойлсон байдаг⁴.

4. Хамтын ажиллагааны зарчим

Дасгалжуулагч болон нийгмийн ажилтны өөрсдийн мэдлэг, ур чадвар, хандлага нэгтгэн нэг зорилгын төлөө баг болон хамтран ажиллахын тулд хамгийн түрүүнд тэдэнд өөрсдийгөө танин мэдэх шаардлага тулгардаг. Тэд баярлах, гуних, гомдох, цөхрөх, уйтгарлах, гуних, ядрах зэрэг сэтгэлийн хөдөлгөөнтэй жирийн нэгэн хүн. Харин бусдад ийм мэдрэмжүүд төрдөг үү? тэд

4 Б. Лхагвадулам, С. Отгонтуяа “Хүн байхын учир” УБ, 2009.

үүнийг хэрхэн зохицуулдаг бол? гэх зэргээр бусдыг өөрийнхөө оронд тавьж бодож мэдрэх нь бусдыг ойлгон хамтран ажиллахын, үндэс болдог.

Дасгалжуулагч, нийгмийн ажилтнууд нь өөрсдийгөө танин мэдэж, би хэнтэй хамтрах билээ?, Юуны төлөө ажиллах вэ?, суралцагчдын онцлог юу билээ?, Тэдэнд бид юуг өгч чадах вэ?, Бид сургалтыг эхлүүлэхэд бэлэн үү? гэх зэргээр сургалт эхлэхээс дуусталх бүхий л үе шатуудад урьдчилан бэлтгэж өөрийгөө болон хамтрагчаа ойлгон бие биеэ харилцан дэмжин ажилласнаар амжилтад хүрнэ. Ийнхүү нэгэн ойлголт, зорилготой байснаар оролцогч бүрийг харилцан дэмжих, бэрхшээлийг даван туулах чадвар эзэмшүүлэх, харилцан суралцах, туршлага хуримтлуулах, бүтээлчээр ажиллах орон зайг бүрдүүлж зорилгодоо хамтран хүрэх боломжийг олгоно.

5. Оролцогч төвтэй арга барилын зарчим

“Нийгэмшүүлэх цирк” нь суралцагч бүрийг хөгжүүлэх, бүлгийн хөгжлийг дэмжих, бие бялдар, сэтгэлзүйн, харилцааны зэрэг бүхий л талын оролцоонд суурилсан сургалтын процессыг дэмждэг. Сургалтын үйл явцын гол цөм нь суралцагчид. Сургалтад тогтмол оролцохыг тэдэнд хүчээр албадан тулгах ёсгүй бөгөөд оролцох эсэхээ тэд сонгох эрхтэй. Сайн дурын энэхүү оролцоо нь “Нийгэмшүүлэх цирк”-ийн үндсэн зарчмуудын нэг юм. Түүнчлэн сургалтаар зааж эзэмшүүлэхээр төлөвлөсөн зүйлс нь тэдэнд хэр тохиромжтой байгаа, аргазүй нь нийцэж байгаа эсэх, тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлууд байна уу? гэх мэтээр тэднийг сонсон харилцах нээлттэй, үр дүнтэй харилцааны орон зайг бүрдүүлэх нь зүйтэй. Сургалтын явцад цаг хугацаа өнгөрөх тусам тухайн хүн улам сайн суралцах, аливаа техникийг улам илүү чадварлаг гүйцэтгэх, бусадтай баг болон ажиллах, тэднээс суралцах замаар бүлгийн хөгжлийг дэмжих, тэнцвэртэй байдлыг хангана.

Хүүхэд залуусын нийгэмшлийг дэмжих бусад аргуудаас “Нийгэмшүүлэх цирк” нь оролцогч төвтэй бүлгийн сургалтыг дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хамтран удирдан чиглүүлдгээрээ онцлог ялгаатай.

СЭДЭВ 4.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК ХӨТӨЛБӨР МОНГОЛ УЛСАД

1993 онд Хүүхдийг Ивээх Сангийн бүсийн салбараас Дэлхийн банкны захиалгаар хийж гүйцэтгэсэн “Монголын эмзэг бүлгийн хүмүүсийн нөхцөл байдлын үнэлгээ” болон 1994 онд хийсэн бусад судалгаа, үнэлгээ, баримтад үндэслэн Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр нь:

1. Эмзэг бүлгийн хүүхдүүдэд онцгойлон анхаарах
2. Ядуурлыг бууруулахад туслах
3. Хүүхэд төвтэй үйлчилгээг хөгжүүлэх
4. Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих чиглэлээр стратегийн тэргүүлэх зорилтуудаа тодорхойлсон байдаг.



“Нийгэмшүүлэх цирк” сургалтад оролцогч хүүхдүүд. 2000 он Хүүхдийг Ивээх Сан

Эдгээрээс Хүүхэд төвтэй үйлчилгээг хөгжүүлэх стратегийнхаа хүрээнд боловсрол болон нийгмийн тусламжийн үйлчилгээнүүдийн чанарыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд амьдарч буй (хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч) хүүхдүүдийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд хүүхдийн эрхийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, үйлчилгээнд хүүхэд төвтэй аргазүйг нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн⁵. Иймээс хүүхдийн хувь хүний болон нийгмийн харилцааны ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, өөртөө итгэлтэй болох, үзэл бодлоо илэрхийлж сурахад нь онцгой ач холбогдол бүхий “Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийг 2000 онд Монголын Хүүхдийн Эрхийн Төв, Улсын цирк, Хүүхдийг Ивээх Сан хамтран хараа хяналтгүй, хүнд нөхцөлд амьдардаг хүүхэд, залуусыг нийгэмшүүлэх зорилгоор Канадын Олон Улсын “Нарны цирк” корпорацын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлжээ.

“Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх боловсон хүчнийг бэлтгэхээр Хүүхдийг Ивээх Сан “Нарны цирк”-тэй хамтран 2001-2013 онуудад “Нийгэмшүүлэх цирк” сургалтыг зохион байгуулах дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудыг бэлтгэх, чадавхжуулах олон улсын сургалтыг Монголд дөрвөн удаа зохион байгуулжээ. Сургалтад асрамж, халамжийн төвийн ажилтнууд, хүүхдэд халамж, хамгаалал, боловсролын чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус 30 гаруй байгууллагын 70 орчим ажилтныг уг аргазүйгээр сурган бэлтгэсэн байна. 2000 оноос хэрэгжүүлсэн уг хөтөлбөрт 9000 гаруй хүүхэд, залуус хамрагджээ. Түүнчлэн хүүхдэд хамгааллын болон боловсролын үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагууд уг аргазүйгээр ажилтнуудынхаа ур чадвар, аргазүй, туршлагыг баяжуулан хөгжүүлэхэд анхаарч байна.

5 Хүүхдийг Ивээх Сан, “Хүүхдийн төлөө 20 жил, 20 дэвшилт санаачилга” Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь үйл ажиллагааны товч түүх (1994-2014), УБ, 2014.

БҮЛЭГ II.

“НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК”-ИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШ, НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮҮРЭГ



СЭДЭВ 1.

ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШИЙН УР ЧАДВАР, ҮҮРЭГ



СЭТГЭГДЭЛ:

Бид хамтран ажиллагчаа өөрийн нэгэн үргэлжлэл гэж харж, хүлээн зөвшөөрөхгүйгээр тэдэнтэй хамтдаа өсөн дэвжиж чадахгүй... Сургагч багшийн хувьд надад гадаад, дотоодын олон сургагч багштай хамтран ажиллаж, тэднээс суралцах аятай боломж олдож байсан. Бид өөрсдийн хийсэн ажиглалт, санал бодлоо хоорондоо солилцсоноор төсөөлөл, үзэл бодолд ахиц дэвшил бий болж, биднийг улам өсөн дэвжихэд нөлөөлдөг.¹

Лино де Жиованни, Нийгэмшүүлэх циркийн Сургалтын менежер Нарны цирк, Монреаль хот.

“Нийгэмшүүлэх цирк”-ийн гол арга барил нь циркийн урлагаар дамжуулан суралцагчдад өөрийгөө таних боломж олгодгоороо бусад сургалтаас ялгаатай. Өөрөөр хэлбэл суралцах явцдаа өөрийгөө шинээр таних, суралцах чадвартай гэдгээ ойлгох, ирээдүйгээ сайн сайхнаар төсөөлөх чадамжийг олгодог. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хамтдаа нэгэн зорилгын төлөө баг болж ажилласнаар суралцагчийн болон бүлгийн хөгжлийг дэмжих, сургалтыг аюулгүй, найдвартай зохион байгуулах, сургалтын үр дүнг нэмэгдүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Хэдийгээр

дасгалжуулагч болон нийгмийн ажилтны ажил үүрэг ялгаатай ч хамтран ажилласнаар сорилт бэрхшээлийг даван туулж амжилтад хүрнэ.

ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШ

“Нийгэмшүүлэх цирк”-ийн дасгалжуулагч багш нь өөрийн мэдлэг туршлагыг бусдад заан сургах ур чадвартай, хүнлэг, хүүхэд, залуучууд, тэдний бүлэгтэй ажиллах туршлагатай, суралцагчдын онцлог, хэрэгцээнд тулгуурлан циркийн төрөл техникүүдийг эзэмшихэд нь туслах нийгмийн уран бүтээлч хүн юм.

Тэрээр сургалтад оролцогчдын бодит оролцоог ханган, циркийн урлагийн төрөл, техникүүдийг зааж тэдний бие бялдрын хөгжил, нийгэмшлийг дэмжих үүрэгтэй. Энэ утгаараа тэдний зан байдал, аливаад хандах хандлага

¹ Cirque du Soleil, Нийгэмшүүлэх циркийн суурь сургалтад оролцогчдод зориулсан гарын авлага. УБ 2012,

нь суралцагчдын хувьд бодит байдлаар үлгэр жишээ болдог учраас бусадтай харилцах харилцаа, биеэ авч явах байдал зэрэг нь түүний заах сургалтын агуулгатай адил онцгой ач холбогдолтой байдаг.

Дасгалжуулагч багшийн үүрэг:

“Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага нь дасгалжуулагч багшийн үйл ажиллагааны хүрээ, хариуцлага, эрх үүргийг нарийн тодорхойлж өгнө. Энэ нь тухайн байгууллага болон дасгалжуулагч багш бусад ажилтнуудад ойлгомжтой тодорхой байх ёстой. Үүрэг, хариуцлага нь тодорхой, хүлээлт нь бодитой байхын хирээр зорилго, зорилтууддаа хүрэхэд хялбар байдаг.

Дасгалжуулагч багш нь “Нийгэмшүүлэх цирк” сургалтыг зохион байгуулах нийгмийн ажилтантай хамтран ажиллах, сургалтыг хэрэгжүүлж байгаа болон бусад хамтран ажиллагч байгууллагуудын өмнө дараах үүргийг хүлээнэ. Эдгээр нь:

- Циркийн сургалтыг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Сургалтыг суралцагчдын сонирхол, хэрэгцээ, ур чадварт нийцүүлэн зохион байгуулах;
- Сургалтын үйл ажиллагаанд оролцох суралцагчдын сонирхлыг татах, тэднийг сургалтад тэгш татан оролцуулах; (дасгалжуулагч багш нь суралцагчдын ямар нэгэн зүйлийг томчуудтай хамтран хийх, тэдэнтэй бодит харилцаа үүсгэх боломжийг олгодог)
- Бүлгийн онцлог, ялгаатай байдлаас шалтгаалан сургалтын туршид мэдрэмжтэй хандаж суралцагч бүрт хүрч хамтран ажиллах;
- Сургалтын өмнө болон дунд хугацаанд мөн төгсгөлд суралцагчдад гарч буй эерэг өөрчлөлтийг хэмжихэд нийгмийн ажилтантай хамтран ажиллах;
- Сургалтын төлөвлөгөөний дагуу ажиллах, цаг баримтлах, шаардлагатай бүхий л харилцаа холбоог тогтоох, сургалтын тасралтгүй байдлыг хангана;
- Суралцагчдын чадвар, нөөц боломж, хүсэл сонирхол, биеийн онцлогт тохирсон хөдөлгөөн циркийн техникт сургах;
- Нийгэмшүүлэх циркийн сургалтын аргазүйг түгээн дэлгэрүүлж сурталчлахад идэвх санаачилгатай хамтран ажиллах;
- Сургалтын явцад оролцогчдын эрхийг хүндэтгэн тэдний оролцоог хангах,
- Суралцагчдад циркийн хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй харьцах, ашиглах, хэрхэн цэвэрлэх, арчлах, хадгалах талаар зааж сургах нь дасгалжуулагч багшийн үүрэг юм

Дасгалжуулагч багшид тавигдах ур чадвар

Ур чадвар, ажлын туршлага, нөхцөл байдалд мэдрэмжтэй хандах оролцогчдын эрхийг хүндэтгэх, тэгш оролцоог хангах зэрэг нь дасгалжуулагч багшид байх хамгийн чухал чадварууд юм.

Дасгалжуулагч багшийн ур чадваруудыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2

УР ЧАДВАР	ТАЙЛБАР
Анхаарлаа бүрэн хандуулах	Үг яриа, үйлдлээрээ тухайн суралцагчийг бүрэн анхаарч байна гэдгээ харуулна. Зарим тохиолдолд биеийн хөдөлгөөн, хэлэмж нь хэлэх үгээс илүү чухал байдаг. Биеийн хөдөлгөөн, хэлэмж нь ямар нэгэн зүйлийг илэрхийлдэг. Энэ нь заримдаа хэлсэн үгээ баталгаажуулж, эсвэл хэлсэн зүйлээсээ зөрөх тохиолдол ч бий. Тухайн хүний талаар юу бодож байгааг дасгалжуулагч багшийн биеийн хөдөлгөөн үнэнээр нь харуулдаг.
Нээлттэй асуулт тавих	Суралцагчдыг нээлттэй, чөлөөтэй ярих боломж олгоход хэрэглэх ур чадвар. Нээлттэй асуултуудын зарим жишээ: <ul style="list-style-type: none"> - “Энэ дасгалыг хийхэд чамд ямар санагдаж байна?” - “Та бүхэн надад талаар ярьж өгөөч?” гэх мэт
Тодруулах асуулт тавих	Ямар нэгэн зүйлийг тайлбарлаж тодруулах зориулалт бүхий асуултууд: <ul style="list-style-type: none"> - “Энэ талаар дэлгэрэнгүй ярьж болох уу?” - Суралцагчийн хэлсэн үг: “... болсон явдалд би маш их бухимдсан.” Тодруулах асуулт: “Яг юунд нь бухимдсан бэ?” гэх мэт
Хураангуйлах	Хүний хэлсэн санааг базаж хураангуйлах ур чадварыг хэлнэ. Сайтар базаж хэлсэн зүйл товч, оновчтой байх бөгөөд үүнд тодорхой баримт сэтгэл хөдлөлийн аль аль нь багтана. Тухайн хүний туршлагыг сайтар анхаарсаны үндсэн дээр базан хэлэх бөгөөд түүний санаа бодол, мэдрэмжийг өөрийн үгээр оновчтой илэрхийлэх арга хэрэгсэл юм.
Нэгтгэн дүгнэх	Суралцагчдын ярьсан зүйлийн гол санааг нэгтгэн дүгнэх. Нэгтгэн дүгнэснээр ярьсан зүйлийн зарим хэсгийг бус бүхэлд нь сайн ойлгосон болохыг харуулдаг. Энэ нь тухайн хүний ярьсан зүйл, зан үйл, мэдрэмжийг багтаана. Сайтар нэгтгэн дүгнэх нь сургалтын туршид юу ярьж хэлэлцсэнийг оролцогчдод сэргээн сануулаад зогсохгүй анзаараагүй өнгөрсөн зүйлээ мэдэх боломжийг олгодог.

<p>Асуудлыг эергээр шийдвэрлэх</p>	<p>Суралцагчид, хамтран ажиллагч нарын өмнө тулгараад байгаа том, жижиг, энгийн эсвэл төвөгтэй, амархан эсвэл хэцүү аливаа асуудлуудыг эергээр шийдэхэд дэмжин туслах дараах алхмуудыг баримтална. Асуудлыг шийдвэрлэх 4 үндсэн алхам.</p> <ol style="list-style-type: none"> 1. Асуудлуудыг тодорхойл; 2. Хувилбаруудыг бий болго; 3. Хувилбаруудыг үнэлэн сонго; 4. Шийдлийг хэрэгжүүл;
<p>Нөхцөл байдалд мэдрэмжтэй хандах</p>	<p>Энэ нь бодит байдлыг үнэлэх, хүндэтгэх, бэрхшээлийг даван туулахад нь суралцагчдад урам өгч дэмжих чадвар юм. Энэхүү мэдрэмжтэй байдал нь үл ойлголцох, хайхрамжгүй хандах, зүй бус зан авир гаргахаас зайлсхийх боломжийг олгодог.</p>
<p>Жендерийн мэдрэмжтэй, уян хатан байх</p>	<p>Эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд өөр өөр хэрэгцээ, тулгамдсан асуудлуудтай, олон янзын бэрхшээлтэй тулгардаг. Мөн янз бүрийн хүсэл эрмэлзэлтэй гэдгийг ойлгон хүлээн зөвшөөрөх явдал юм. Мөн жендерийн мэдрэмжтэй байх гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдэд яг адилхан хандах гэсэн үг биш харин нөхцөл байдал, боломж бололцоог нь адил тэгш болгоход анхааран сургалтыг зохион байгуулах явдал.</p>
<p>Бусдыг мэдэрч ойлгох</p>	<p>Энэ нь аливаа нэг нөхцөл байдал өөр хүний хувьд ямар байхыг ойлгож, мэдрэх чадвар юм. Энэ чадварт өөрийн гаргаж буй шийдвэр, үйлдлийн үр дагавар бусдад хэрхэн нөлөөлөхийг харгалзан үзэж, бусдад тохиолдсон таагүй зүйл болон бэрхшээлтэй асуудлыг төсөөлөн ойлгож, бусдын сэтгэл хөдлөлд анхаарал тавин өөрийгөө тэдний оронд тавьж үзэх чадвар юм.</p>
<p>Алдаагаа хүлээн зөвшөөрөх чадвар</p>	<p>Хүн бүхэн алдаа гаргадаг ч гаргасан алдаагаа хэрхэн хүлээн зөвшөөрч, хэрхэн зохицуулж байна вэ гэдгийг бидний эргэн тойрны хүмүүс анхааралтай ажиглаж байдаг. Хэрвээ өөрийн алдааг хүлээн зөвшөөрч түүнийг засах ямар нэгэн үйлдэл хийхгүй бол тэдний зүгээс тантай харилцах харилцаа, танд итгэх итгэлд сөргөөр нөлөөлдөг. Иймд өөрийн гаргасан алдаанд хэн нэгнийг буруутгах, бусдад тохохыг хэзээ ч битгий оролдоорой. Хэрвээ том жижиг ямар нэгэн алдаа гаргасан бол түүнийг хүлээн зөвшөөр. Алдаагаа хүлээн зөвшөөрөх нь хамтран ажиллагч, суралцагчдын хүндэтгэлийг хүлээн танд итгэх итгэлийг бэхжүүлдэг.</p>

Түүнчлэн хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилт, хүүхдийн нас, насны хөгжлийн талаар зохих мэдлэгтэй байх шаардлагатай. Дасгалжуулагч багш нь циркийн бүхий л төрлүүдийг төдийгүй бусад шаардлагатай техникүүдийг заах чадвартай байна. Хамгийн чухал нь суралцагчдынхаа хэрэгцээнд нийцүүлэн циркийн урлагийг хэрхэн заах талаар бүтээлчээр сэтгэн эрэл хайгуул хийх чадвартай байх ёстой.

Дасгалжуулагч багшийн хандлага

“Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байгууллага, оролцогчид, олон нийтийн гүүр болсон дасгалжуулагч багш нь сургалтын энэхүү шинэ арга барил, үйл ажиллагаа, арга хэрэгслийг нэвтрүүлэхдээ эхнээсээ л хүндэтгэлтэй, уян хатан байдлыг харуулж, аажим аажмаар харилцан зөвшилцөл, дэмжлэг бүхий орчин бүрдүүлэн ажиллах шаардлагатай. Дасгалжуулагч багш нээлттэй, уян хатан, хүндэтгэлтэй харилцаатай байх нь юунаас ч чухал. Аливаад хандах хүний хандлага нь тухайн үйл хэргээсээ үргэлж давж гардаг. Нийгэмшүүлэх цирк хөтөлбөр дууссаны дараа түүний заасан циркийн ур чадварыг суралцагчид болон олон нийт сураад үлддэг ч түүний харилцаж байсан хандлага нь түүнээс ч удаан хугацаанд хүний сэтгэлд хоногшин үлдэж үр нөлөөгөө үзүүлж байдаг.

СЭДЭВ 2.

НИЙГМИЙН АЖИЛТНЫ УР ЧАДВАР, ҮҮРЭГ

“Нийгэмшүүлэх цирк”-ийн нийгмийн ажилтан нь суралцагчдад тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлаар нь ганцаарчлан ярилцаж зөвлөх чадвар туршлагатай, сургалтын явцад дасгалжуулагч, нийгмийн ажилтан, суралцагчдын хооронд итгэлцэл бий болгох, циркийн сургалтаар сурсан чадваруудаа амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэхэд нь суралцагчдад зөвлөн дэмжих үүрэгтэй мэргэжилтэн юм.

Нийгэмшүүлэх цирк сургалтаар нийгмийн ажилтан болон оролцогчдын хооронд итгэлцэл бий болгох нь сургалтыг үр дүнд хүргэх томоохон суурь болдог.

Нийгмийн ажилтны үүрэг:

Нийгмийн ажилтан нь “Нийгэмшүүлэх цирк”-ийн суралцагчид дасгалжуулагч багш, орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Тэрээр тухайн орон нутгийн байгууллага, ажиллагсад, суралцагчдын амьдардаг орчинд нь орж ажилласнаар тэдэнд “Нийгэмшүүлэх цирк” сургалтыг сонирхон оролцох боломжийг олгох, харилцан итгэлцсэн итгэлцлийн хүчтэй харилцаа холбоог бий болгоход тусалж чадна. Нийгмийн ажилтан нь:

- Сургалтын бэлтгэл ажлыг хангах; (суралцагчдыг сургалтад элсүүлэх, сургалт явуулах байр олох, сургалтыг зохион байгуулах зэрэг)
- Суралцагчидтай харилцах явцдаа итгэлцлийг хөгжүүлэх; (харилцан итгэлцсэн урт хугацааны харилцаа тогтоохын тулд оролцогчдын хэрэгцээг хүндэтгэх, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, тэднийг чин сэтгэлээсээ сонсон бүтээлч байдлыг дэмжин хөгжүүлэх, итгэл хүлээлгэхэд анхаарал хандуулах ёстой. Тиймээс сургалтын бүхий л үе шатуудад оролцогч бүртэй тогтмол уулзан ярилцаж байнгын харилцаа холбоог ханган бэхжүүлэх нь чухал)
- Суралцагчдын чадавх, хэрэгцээнээс шалтгаалан сургалтын агуулга, хурдыг тохируулан боловсруулахад дасгалжуулагч багштай хамтран ажиллах;
- Суралцагчдад дүрэм журмыг ойлгож хүндэтгэх талаар ойлгуулах; (энэ

нь харилцан бие биеэ хүндэтгэх, шударга байх, аюулгүй байдлаа хангах зэргээр итгэл үнэмшлийн үндэс суурийг бүрдүүлэн хөгжүүлэхэд нэн чухал)

- Суралцагч хүүхдүүдийн хамгааллын чиглэлээр тодорхой үүрэг хүлээн бусад талуудтай хамтран ажиллана; (энэ үүргийн талаар гуравдугаар хэсгээс дэлгэрүүлэн танилцаарай)

Нийгэмшүүлэх циркийн нийгмийн ажилтны ур чадвар

Суралцагч бүрийг “Нийгэмшүүлэх цирк” сургалтаар эзэмшсэн ур чадваруудаа амьдралд хэрэгжүүлэхэд нь туслах үүрэг бүхий нийгмийн ажилтнаас дараах ур чадварыг шаардана.

- Суралцагчдын хүсэл, сонирхол, хэрэгцээг танин мэдэх, хамт олны дэмжлэг болон бүлгийн оролцогч хоорондын тэнцвэрийг бий болгох;
- Дасгалжуулагч багш бусад мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллаж тэднийг хүндэтгэж, уян хатан, нээлттэй харилцах;
- Аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлж оролцогч талуудад мэдээлэл өгөх, ухуулга сурталчилгаа хийх, нөлөөллийн үйл ажиллагааг манлайлан зохион байгуулах;
- Хувь хүн болон хамт олны өмнө тулгарсан аливаа асуудал бэрхшээлийг хамтын замаар шийдэх, зөв шийдлийг олоход суралцагчдыг чиглүүлэх;
- Зорилтот бүлэгт мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд байгууллага мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах,
- Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх;
- Сургалтыг төлөвлөх, бүлгийг удирдах, зохион байгуулах,

Гэхдээ нэг хүнд дээрх бүх чадварууд хосолсон байх нь боломжгүй бөгөөд дасгалжуулагчтай хамтран ажилласан тохиолдолд энэ нь боломжгүй зүйл биш юм.

СЭДЭВ 3.

ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШ, НИЙГМИЙН АЖИЛТНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Өөр өөр туршлагатай, өөрийн гэсэн ажиллах арга барилтай ажилтнууд хэрхэн баг болж нэгдэх вэ? Үүний тулд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар мэдлэг туршлага, сургалтын явцад гүйцэтгэх үүрэг, аливаа зүйлд хандах хандлага, харилцааны онцлог, сургалтын арга барилын талаар үзэл бодлоо хуваалцан хоорондоо чин сэтгэлээсээ ярилцан ойлголцох нь бэрхшээлийг даван туулж хамтран ажиллахад илүү хялбар болно.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан баг болж зорилгодоо хүрэхийн тулд дараах хүчин зүйлүүдэд анхаарал хандуулахыг зөвлөж байна.

- 1. Сургалтад оролцогчдын тоог хязгаарлах.** Суралцагчдын тоо нь 20, 25-аас ихгүй байхаар сургалтыг зохион байгуулна. Суралцагчдын тоо үүнээс их байх нь тэднийг бүрэн хянах, сургалтын явцад суралцагч нэг бүртэй харилцах, анхаарах, сургалтын таатай орчин үүсгэхэд бэрхшээл учирч болзошгүй.
- 2. Суралцагчдыг дэмжин урамшуулах.** Сургалтын үйл явцад суралцагч бүрийг урамшуулан дэмжих нь тэдэнд өөртөө болон бусдад итгэл, найдвар өгөх хамгийн том хөшүүрэг болдог. Урамшууллын аргыг хэрэглэхдээ зорилтот бүлгийн оролцогч нарт хүлээлт үүсгэхгүй ямар нэгэн зүйл амлахгүй байхыг анхаарах хэрэгтэй.
- 3. Багаар ажиллах.** Сургалтын аль ч үед гарсан зөрчлийг дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан эв зүйгээр шийдвэрлэж, найрсаг уур амьсгал бүрдүүлэн ажиллахад анхаарна. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоорондын болон оролцогчид хооронд гэх мэтээр аль ч түвшинд гарсан зөрчлийг үр дүнтэйгээр шийдвэрлэх нь бие биеэ ойлгох багийн гишүүдийн эв нэгдлийг бэхжүүлэхэд дөхөмтэй.
- 4. Суралцагчдын ялгаатай байдлыг ойлгон, зөвшөөрөх.** Зарим суралцагч циркийн дасгал техникийг хялбархан хийж байхад нөгөө нэгд нь энэ нь боломжгүй зүйл байж болно. Суралцагч хувь хүн бүр өөр өөрийн онцлогтой, хөгжлийн түвшин, үзэл бодол ялгаатай гэдгийг хүлээн зөвшөөрч бусдадаа ойлгуулаарай.


Сургалтын явцад суралцагчдын өөртөө итгэх итгэл, харилцаанд гарсан өчүүхэн жижиг амжилтууд нь тэд өөрийн давуу тал, ахиц дэвшлийг ухааран ойлгох боломжийг нэмэгдүүлдэг. Дасгалжуулагч багш нийгмийн ажилтан нь суралцагчдыг дараах чиглэлээр дэмжин ажиллана.

1. Суралцагчдын бие даасан байдлыг хөгжүүлэхэд нь урам зориг өгч дэмжих

Циркийн дасгал техникүүдийг зөв хийхийн тулд хувь хүнээс олон зуун удаагийн уйгагүй давталт, хичээл зүтгэл, цаг хугацаа, зориг тэвчээрийг шаарддаг. Цаг хугацааны явцад оролцогчид шантрах, өөртөө итгэлгүй болох, уурлах, залхуурах зэрэг үйлдлийг гаргах тохиолдол цөөнгүй. Энэ үед оролцогчдыг ажиглан тэдэнд өөрийгөө хянах, жолоодоход нь туслах энгийн аргуудыг (дэмжих үг хэллэг, урам зориг өгөх, чадварыг нь үнэлэх гэх мэт) хэрэглэн сэтгэлийн дэм өгөх шаардлагатай.

2. Бие биеэсээ харилцан хамааралтай байх мэдрэмжийг дэмжин хөгжүүлэх

Циркийн урлаг нь бие биеэсээ харилцан хамаарал бүхий багаар ажилладаг эв нэгдлийн урлаг. “Нийгэмшүүлэх цирк” сургалтын явцад оролцогчид дасгалжуулагч багштай, оролцогчид хоорондоо, оролцогчид нийгмийн ажилтантай гэх мэтээр харилцдаг.



Оролцогчдын хувьд тодорхой бүлэгт харьяалагдан өөрсдийгөө бүлгийн гишүүн гэж тооцон эвсэг хамт олонч бүлгийг бүрдүүлэхийн тулд өөрсдөөс нь тодорхой дүрэм журам, бие биедээ итгэх, харилцааны эв дүй, эв нэгдлийг шаардаж байдаг.

Жишээ нь: Нийгмийн ажилтан сургалтын эхнээс суралцагчдад бүлгийн баримтлах дүрмийг өөрсдөөр нь хэлэлцүүлэн батлуулж, сургалтын туршид хэрхэн мөрдүүлэх талаар ярилцан бүгд ижил ойлголттой болсон байхад анхаарна. Суралцагчдын хувьд дүрмээ өөрсдөө гарган

хэлэлцэж батлах нь түүнийг өөрсдөө үл зөрчин амжилттай хэрэгжүүлэх боломжтой болдог.

Хүн бүр өөр өөрийн үзэл бодол, мэдрэмжтэй, хүн бүхэнд өөрийгөө бусдад хүлээн зөвшөөрүүлэх хэрэгцээ байдаг. Бүлэг хамт олны амжилт нь тухайн хүний хичээл зүтгэлээс ихэд хамааралтай гэдгийг хэрхэн ойлгуулах вэ? гэсэн асуудал дасгалжуулагч багш, нийгмийн ажилтны өмнө зүй ёсоор тавигдаг. Үүнийг амжилттай шийдэхэд тус болох аргуудыг санал болгоё:

- Харилцан ярилцах, харилцааны төрөл бүрийн арга техник хэрэглэх;
- Нийгэмшүүлэх тоглоом, дасгал ажиллах;
- Циркийн дасгал, техник хийх, хэрэгсэлтэй ажиллах үеийн алдаа, оноог ярилцах;
- Сургалтын төгсгөлд хийдэг дүгнэлт ярилцлагыг тогтмол хийх нь хүн бүрийн оролцоог тэгш хангах нөхцөлийг бүрдүүлдэг;
- Ганцаарчилсан болон бага бүлгийн ярилцлага хийх зэрэг олон аргуудын аль тохиромжтойг ашиглаж болох юм.

3. Суралцагчдын биеийн өсөлт хөгжлийг дэмжих

Нийгэмшүүлэх цирк сургалт нь оролцогчдын бие махбодын хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл болдог. Циркийн дасгал техникийг төгс хийхэд оролцогчдод маш өндөр шаардлага тавигддаг бөгөөд бие махбодын хувьд хүчтэй, тэнцвэртэй, уян хатан, сэтгэлзүйн хувьд өөрийн үйл хөдөлгөөн болон сэтгэлийн хөдөлгөөнийг хянан зохицуулах чадвартай байхыг шаарддаг.

Аливаа дасгал техникийг дасгалжуулагчийн удирдлага дор зөв хийж ур чадвараа дээшлүүлэхэд олон удаагийн давталт, суралцагчийн өөрийн идэвх, чармайлт шаардлагатай. Ингэснээр өөрийн биеийн хүч чадал, уян хатан байдал, тэсвэр, тэвчээр, тэнцвэрийг хөгжүүлэх боломжтой. Ийнхүү суралцагчдын бие махбодын өсөлт хөгжлийг дэмжихдээ сургалтын эхэнд батлагдсан үзүүлэлт бүхий сорилуудаар үнэлгээг хийж сургалтын явцад болон төгсгөлд дахин харьцуулан үнэлнэ. Сорилын үнэлгээ болон суралцагчдын өөрсдийн саналд тулгуурлан дасгал техникийн хүндийн зэргийг тохируулан сургалтыг зохион байгуулна.

4. Харилцааны ур чадварыг дэмжин хөгжүүлэх

Циркийн дасгал, техникийг хийх явцад суралцагчид болон дасгалжуулагч багш хоорондоо үг яриа, үйл хөдлөлөөр харилцан бие биеэ ойлгох, нэгэн командаар ажиллах хэрэгцээ байнга тулгардаг. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан суралцагчдын биеийн хэлэмж, нүүр царайны хувирал, дохио зангаа, үйлдэл хөдөлгөөнөөр хэрхэн өөрийн дотоод мэдрэмжээ илэрхийлж, бусадтай харилцаж байгааг анхааралтай

ажиглана. Нийгэмшүүлэх цирк сургалтын зорилтот бүлгийнхний хувьд ихэнхдээ өөрийн бодол мэдрэмжийг илэрхийлэх, бусадтай эерэг харилцаа холбоо тогтоох чадвар сул байдаг.

Суралцагчдын харилцааны ур чадварыг хөгжүүлэхдээ:

- сургалтын явцад хийсэн дасгал, тоглоомын талаарх өөрт төрсөн сэтгэгдлийг харилцан ярилцах,
- циркийн хэрэгслүүдийг ашиглан ямар нэгэн зүйлийг төлөөлүүлэн төсөөлж түүнийгээ үйлдлээр бусдадаа үзүүлж таалцах,
- ганцаарчлан болон бүлгээр дүрийн тоглолтууд хийх,
- бодол, мэдрэмжээ харилцан ярилцах,
- сэдэвчилсэн зохион бичлэг хийх, тодорхой сэдвээр эссэ бичих, шүлэг зохион бие биедээ унших,
- тэмдэглэл хөтлөх зэргээр төрөл бүрийн арга техникүүдийг ашиглах боломжтой.

5. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан өөрийн үнэлгээг хийж өөрсдийгөө хөгжүүлэх

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд нь сургалтыг багаар хамтран зохион байгуулахдаа бид өөрсдөө энэ сургалтыг зохион байгуулахдаа бэлэн байна уу? бид зохих ёсоор бэлтгэгдсэн үү? гэдэг асуултыг байнга тавьж өөрийн үнэлгээг хамтран хийж байх шаардлагатай. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд ийнхүү өөрийн үнэлгээ, болон сургалтыг зохион байгуулахад хэр зэрэг бэлэн байгаагаа үнэлэх нь сургалтыг амжилттай зохион байгуулж хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Доорх шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан “Нийгэмшүүлэх цирк” сургалтыг зохион байгуулахад хэр зэрэг бэлэн байгаа, цаашид хамгийн сайн үр дүнд хүрэхэд юуг сайжруулах шаардлагатай байгаа чиглэлүүдээ тодорхойлоход дараах хүснэгтийг ашиглаарай. Шалгуур үзүүлэлт тус бүрийг үнэлэх гурван хэмжүүрийг (хангалтгүй, сайжруулах шаардлагатай, хангалттай) тогтоож өгсөн. Шалгуур үзүүлэлт бүрийг нухацтай эргэцүүлэн одоогийн нөхцөл байдал чухам аль баганад яагаад тохирч байгааг тодорхойлон бичиж үнэлээрэй. Эхний хоёр баганад гарч буй үнэлгээг хэрхэн сайжруулахаа хамтдаа ярилцан “хангалттай” үнэлгээний багана руу шилжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаарай.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын өөрийн үнэлгээний хуудас.

Хүснэгт 3 (Загвар)

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ХАНГАЛТГҮЙ	САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ	ХАНГАЛТТАЙ
Багшийн хувьд бидэнд юу хэрэгтэй вэ?			
Сургалт суралцагчдын хэрэгцээ, сонирхол, чадвар, хөгжилд тохирч байна уу?			
Бүлэг болон бүлгийн гишүүдийн сэтгэлзүйн болон бие махбодын хөгжлийн талаарх мэдлэг ойлголт			
Бие махбод, сэтгэл санааны хувьд аюулгүй орчин бүрдүүлэх, ийм орчин бүрдүүлэхэд зайлшгүй анхаарах зүйлийн талаарх мэдлэг			
Хүүхдийн оролцооны талаарх ойлголт мэдлэг			
Суралцагчдад гарч буй өөрчлөлт хөгжлийг үнэлэх үнэлгээний талаарх мэдлэг ойлголт			
Сургалтын өмнөх бэлтгэл ажлыг хангах чиглэлээр			
Хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх байгууллагуудтай урьдчилан ярилцаж харилцан ярилцаж зөвшилцсөн эсэх?			
Сургалтад орох хүүхдүүдийг хэрхэн урих, мэдээлэл хүргэх аргаа боловсруулсан уу?			
Сургалтад хамрагдах хүүхдүүдийн талаар хангалттай мэдээлэлтэй юу?			
Сургалтын хүрэх үр дүн, зорилгоо тодорхойлсон уу?			
Сургалтын төлөвлөгөө, цагийн хуваариа боловсруулсан уу?			
Сургалт зохион байгуулах танхимын зай талбай ямар байна?			
Техник хэрэгслийн нөөц хүртээмж ямар байна?			

Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой байна уу?			
Бүлгийн хөгжлийг дэмжих чиглэлээр			
Хүүхэд бүрийг сургалтад тэгш оролцуулж чадаж байна уу?			
Хамтдаа суралцах, тоглох хөгжилтэй орчин үүсгэх талаар ?			
Байж болох зөрчлийн талаар мэдэх, түүнээс сэргийлэх талаар			
Хувь суралцагчийн хэрэгцээнд хандахын зэрэгцээгээр бүлгийн хөгжлийг анхаарах талаар			
Суралцагчдын ахиц амжилтын талаар тэдэнд мэдээлэх эргэх холбоотой байх талаар			
Харилцаа			
Үгэн болон үгэн бус харилцаа үүсгэх, видео үзүүлэх, хөгжим сонсгох зэргээр харилцааны олон төрлийг хэрэглэх талаар төлөвлөсөн үү?			
Суралцагч бүртэй харилцах харилцааны чадварын талаар			
Эцэг эх, асран хамгаалагч, байгууллагын бусад ажилтнуудад ажлаа ямар хэлбэрээр тайлагнахаа төлөвлөн тохирсон уу?			
Заах аргазүйн хувьд			
Сургалтын ялгаатай аргуудыг хэрэглэдэг үү?			
Энгийнээс төвөгтэй, хөнгөнөөс хүнд рүү ахих зарчмыг барьж байна уу?			
Суралцагчдад зааврыг тодорхой өгөх талаарх чадвар ямар байна?			
Заавар өгөхийн тулд бүлгийн гишүүдийг бэлэн болтол хүлээж чадаж байна уу?			

Бүтээлч байдлыг ойлгох, хэрэгжүүлэх			
Уран бүтээлч хандлага – бүтээлч байдлыг дэмжих, идэвхжүүлэх талаарх таны чадвар			
Тоглолтын номер зангидах чадвар			
Циркийн үзүүлбэр, шоу тоглолт хийх талаарх чадвар			
Сургалтын үеийн аюулгүй байдлыг хангах			
Сургалтын үеэр баримтлах дүрмийг хэлэлцэн батлахад бүгдийг оролцуулах талаар?			
Энэ дүрмээ хэрхэн хэрэгжүүлж баримталж байгаад хяналт тавих талаар?			
Харилцан итгэлцэл бүхий сэтгэл санааны болон бие махбодын аюулгүй орчин бүрдүүлэх талаарх таны ойлголт, туршлага?			
Техник хэрэгслүүдийг аюулгүй ашиглах мэдээлэл заавар өгөх талаар?			
Техник хэрэгслүүдийн аюулгүй байдлыг тогтмол шалгах талаар			
Техник хэрэгслүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийх талаар?			

ХАМТРАН АЖИЛЛАХЫН ДАВУУ БОЛОН ДАВУУ БУС ТАЛ

Дасгалжуулагч болон нийгмийн ажилтны хамтын ажиллагаа нь “Нийгэмшүүлэх цирк”- ийн үндсэн зарчим, арга барил нь юм. Хэдийгээр хамтын ажиллагаа нь үр дүн, өөрчлөлтөд хүргэх асар их нөөц боломж боловч тодорхой сорилт бэрхшээлийг дагуулж байдаг. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хамтран ажиллахдаа дараах давуу болон сул талуудыг анхаарах нь зүйтэй.

Хүснэгт 4

ДАВУУ ТАЛ	ДАВУУ БУС ТАЛ
<p>Нийгэмшүүлэх цирк хөтөлбөрийг хэрэгжүүлэгчталуудтай ижил зорилготой, адилхан үүрэг хариуцлагатай тул бие биеэ ойлголцоход дөхөмтэй.</p>	<p>Бодит амьдрал дээр ажилтнууд бие биедээ хэт найдах явдал гарах нь бага хэдий ч хэрвээ ийм зүйл тохиолдвол ажил цалгардуулах эрсдэлтэй. Иймд ажилтнууд бие биеийнхээ гүйцэтгэх үүргийн талаар сайтар ойлголттой байх төдийгүй харилцан бие биедээ шаардлага тавих түүнийг хүлээн авах харилцааны эрүүл орчин бүрдүүлэх нь зүйтэй.</p>
<p>Сургалтын хөтөлбөрийг суралцагчдын хэрэгцээ, чадварт тохируулан боловсруулж сургалтын хурдтай уялдуулан ажиллана.</p>	<p>Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоорондоо санал зөрөлдөн өөр өөрийн үзэл бодолд бат зогсох явдал тохиолддог. Энэ нь оролцогчдод тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож багш, оролцогчдын хооронд үүссэн итгэлцлийг алдагдуулахад нөлөөлдөг. Иймд сургалтаас өмнө заавал хоорондоо уулзан сургалтын төлөвлөгөө, үйл явцын талаар ярилцан ойлголтоо нэгтгэх нь чухал.</p>
<p>Өөр өөрийн давуу болон давуу бус талаа бие биедээ танилцуулснаар бие биеийнхээ сул талыг нөхөн харилцан эрх тэгш байхад нөлөөлнө. Энэ нь суралцагчдад итгэлцлийг бий болгож ижил түвшинд харилцах боломжийг олгодог.</p>	
<p>Ажлын ачаалал багасна.</p>	
<p>Бүлгийн дунд үүссэн аливаа асуудал, хувь суралцагч бүрт гарч буй аливаа өөрчлөлтийг ажиглах, харилцан бие биеэсээ суралцах боломжтой.</p>	
<p>Сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй зохион байгуулж оролцогч бүрт хүрч ажиллах боломжтой</p>	
<p>Аливаа болзошгүй эрсдэлийг тооцоолон урьдчилан сэргийлж аюулгүй байдлыг хангана.</p>	

Сургалтын явцад нийгмийн ажилтан доорх байдлаар оролцох нь сургалтад оролцогчдыг идэвхгүй болгох, сургалтын хэвийн үйл ажиллагаа алдагдах зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Сургалтын үйл явцад нийгмийн ажилтан идэвхгүй оролцдог зарим жишээг танилцуулж байна.

Нийгмийн ажилтан – оролцогч

Циркийн урлаг нь нийгмийн ажилтныг сургалтад идэвхтэй оролцож, сахилга баттай, ухамсартай байхыг шаарддаг. Тэнцвэртэй оролцоог хангахгүйгээр циркийн тодорхой техникийг сурахаар өөртөө илүү их цаг, хүч, анхаарлаа хандуулбал суралцагчдыг ажиглах, тэдэнд туслах үүргээ үл тоомсорлох байдалд хүрч ажилд нь сөргөөр нөлөөлдөг. Энэ тохиолдолд суралцагчид түүнийг нийгмийн ажилтан гэдэг байр сууринаас биш сургалтын оролцогч гэдэг байр сууринаас хандан түүний чиглүүлэгчийн байр суурийг сулруулах магадлалтай.

Нийгмийн ажилтан – үзэгч

Сургалтын явцад нийгмийн ажилтан суралцагч болон бүлгийн динамикийг ойлгон сургалтаа төлөвлөн хэрэгжүүлдэг. Гэтэл сургалтыг хөндлөнгөөс ажиглан сургалтын явцад саад учруулан, зарим суралцагчдыг бүлгээс тусад нь дуудан уулзах явдал байдаг. Энэ нь бүлгийн зүгээс тухайн суралцагчдад үл итгэх, эргэлзэх зэрэг сөрөг хандлагыг бий болгох эрсдэлтэй.

Нийгмийн ажилтан – дарга

Нийгмийн ажилтан сургалтын үйл ажиллагаанд саад учруулан хөндлөнгөөс оролцон суралцагчидтай дүрэмдэх, шууд захиран тушаах байдлаар харилцах явдал гардаг. Түүнчлэн суралцагчдын хувийн асуудлын талаар бусад суралцагчдын дунд ярилцах, дасгалжуулагч багштай ижил тэнцүү байр сууринаас харилцахгүй даргархах зэрэг асуудлыг гаргадаг. Харилцааны эдгээр эв дүйгүй, тэгш бус байдал нь нийгмийн ажилтан чиглүүлэгчийн байр суурийг ганхуулж суралцагчид чиглүүлэгчдийн хооронд зөрчил, үл итгэлцэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлдэг.

СЭДЭВ 4.

“НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК”- ИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШ БОЛОН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ

Ёс зүйн дүрэм

Ёс зүйн тухай ойлголт нь өргөн хүрээтэй бөгөөд тодорхой нөхцөл байдалд ямар нэгэн үйлдлийг өөрийгөө болон бусдыг хүндэлсэн байдлаар хэрхэн зөв хийхийг зааж зөвлөдөг ёс суртахууны зарчмуудын цогц юм.

Сургалтыг зохион байгуулах дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан болон бусад ажилтнуудын хоорондын харилцаа, аливаа зүйлд хандах хандлага, хувийн сахилга бат зэрэг нь хүүхэд залуусын хувьд ямагт үлгэр жишээ болж байдаг. Харилцаанд оролцогч эдгээр талууд нь сургалтаар олгох мэдлэг, чадварын нэгэн адил чухал зүйл нь **“ёс зүй”** гэдгийг дасгалжуулагчид, нийгмийн ажилтнууд мэдэж байх ёстой. “Нийгэмшүүлэх цирк”-ийн ёс зүйн дүрэм нь дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудыг биеэ хэрхэн зөв авч явах тухай нийтлэг заавар, зан үйлийн дүрэм, нэгдсэн удирдамж бөгөөд дараах түлхүүр зарчмуудад үндэслэсэн байдаг.²

Үүнд:

1. Ур чадвар
2. Нийгмийн хариуцлага
3. Шударга чанар
4. Хувийн үүрэг хариуцлага
5. Соёл уламжлалд хүндэтгэлтэй хандах
6. Аюулгүй байдал
7. Багаар ажиллах
8. Ажил эрхлэлтийн харилцаа

Эдгээр зарчим тус бүрийг үйл ажиллагаандаа хэрхэн хэрэглэхийг тайлбарлаж, тайлбарыг удирдан чиглүүлэх хэм хэмжээний тодорхойлолтыг доор үзүүлэв.

² Cirque du soleil, Community worker’s guide, when circus Lessons become life lessons, 2011,

1. Ур чадвар

Дасгалжуулагч нь өөрийн мэргэшсэн буюу зааж чадах циркийн дасгал, техникүүдийг хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний дагуу аюулгүй орчинд зааж сургана. Түүнчлэн багш нар өөрийн мэдлэг ур чадвараа байнга хөгжүүлж байх шаардлагатай. Үүнд:

- 1.1 “Нийгэмшүүлэх цирк”-ийн дасгалжуулагчийн үүрэг гүйцэтгэхэд шаардагдах үндсэн сургалтад заавал хамрагдан өөрийн үүрэг хариуцлагаа ухамсарлан ойлгосон байх;
- 1.2 Дасгалжуулагчид сургалтын явцад суралцагчдынхаа мэдлэг, чадварыг хүндэтгэх;
- 1.3 Өөрсдийн болон суралцагчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх, эрсдэл учруулахуйц тохиромжгүй орчин нөхцөлд ажиллахаас татгалзах;
- 1.4 Суралцагчдын нас, бие бялдар, сэтгэлзүйн онцлог, чадвар, туршлага, чадавхад тохируулан сургалтын агуулгыг төлөвлөн хэрэгжүүлэх;
- 1.5 Суралцагчдыг алхам алхмаар системтэй сургах;
- 1.6 Суралцагчдад циркийн сургалтыг амьдралын эерэг туршлага болгон хувиргахад анхаарч сургалтаа чиглүүлэх зэрэг ур чадваруудыг эзэмшсэн байх шаардлагатай.

2. Шударга чанар

Дасгалжуулагч нь багшлах, дасгалжуулах ажлын явцдаа үнэнч шударга байж, бусдыг хүндэтгэх байдлаар шударга ёсыг хангах үүрэгтэй. Өөрийн ур чадвар, туршлага эсвэл эрх мэдлээ хуурамчаар харуулах, хувийн ашиг сонирхлын үүднээс өөрийгөө буруу ташаа илэрхийлэх ёсгүй. Үүнд:

- 2.1 Өөрийн итгэл үнэмшил, үнэ цэнэ, нэр төр, хэрэгцээ зэрэг нь багш нарын ажил үүрэгт нөлөөлөл үзүүлэхүйц бүхий л асуудлуудын талаар мэдлэгтэй байх;
- 2.2 Хамтран ажиллагч бусад хүмүүст өөрийн гүйцэтгэх ажил үүргийг тодорхой тайлбарлана. Тэдэнд хамааралтай, тэдгээр үүрэгт тавигдах шаардлагыг биелүүлэхдээ итгэл, үнэмшилтэй байх;
- 2.3 Суралцагчдын зүгээс гаргах зарим үйлдэлтэй санал зөрөлдөж болохыг ойлгох;
- 2.4 Ажил үүргээ гүйцэтгэх бүхий л хугацаанд бусдаас сэтгэл санаа болон эдийн засгийн ашиг хонжоо олох, тэднээс шан харамж, бэлэг сэлт хүлээн авахыг цээрлэх ёстой;
- 2.5 Суралцагчдынхаа өмнө ямарваа нэгэн зүй бус буруу үйлдэл хийхийг хүлцэн тэвчих зэрэг чанаруудыг өөртөө төлөвшүүлэх шаардлагатай.

3. Хувийн үүрэг, хариуцлага

Дасгалжуулагчид нь сургалтаа суралцагчдынхаа онцлог, хэрэгцээнд дээд зэргээр нийцүүлэн зохион байгуулах үүрэгтэй. Үүнд:

- 3.1 Суралцагчдынхаа хэрэгцээнд нийцүүлэн тэдний ур чадварыг дээшлүүлэх тодорхой арга барил эзэмшсэн байх шаардлагатай бөгөөд хийж гүйцэтгэж буй үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх чадвартай байх;
 - 3.2 Сургалтын үеэр баримтлах дүрэм журмыг зөрчих аливаа үйлдлээс урьдчилан сэргийлж суралцагчдад байнга мэдээлэл зөвлөгөө өгч байх;
 - 3.3 Урьдчилан боловсруулсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, материал хэрэгслээ бэлтгэн хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулах үүрэгтэй.
 - 3.4 Өөрийн үзэл бодол, хандлагыг оролцогч нарт тулгахгүй байх
- Хүүхдийн эрх хамгаалал, хүнд нөхцөл дэх оролцогчийн талаар мэдлэгтэй байх

4. Соёл, уламжлалд хүндэтгэлтэй хандах

Суралцагчдын язгуур эрх, нэр хүнд, соёлын асуудалд хүндэтгэлтэйгээр хандана. Тэд хувийн нууцтай байх, нууцыг хадгалах, шийдвэр гаргах зэрэг хувийн эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх үүрэгтэй. Үүнд:

- 4.1 Хүний язгуур эрх, нэр төр, соёл уламжлалыг хүндэтгэх. Энэ нь хүн бүрийн хувийн нууцыг хадгалан бие даасан байдлыг хүндэтгэх;
- 4.2 Хувийн ашиг сонирхол болон бусдын ашиг сонирхлын төлөө суралцагчдын хувийн мэдээлэл, нууцыг хадгалах;
- 4.3 Суралцагчдынхаа хувийн амьдралд санаа тавьж шийдвэр гаргахад нь туслан дэмжих.

5. Нийгмийн хариуцлага

Дасгалжуулагч нь циркийн сургалт явуулах үедээ хамтран ажиллагч, олон нийтийн өмнө нээлттэй, хариуцлагатай байх үүрэг хүлээнэ. Үүнд:

- 5.1 Сургалтыг зохион байгуулахдаа орон нутаг, олон нийтэд нээлттэй, ил тод, аливаад хариуцлагатай байх
- 5.2 Сургалт, үйл ажиллагаанууд нь суралцагчдад бие даасан, хэн нэгнээс хараат бус байдлыг мэдрэх нөхцөлийг хангасан байх
- 5.3 Хүний эрхийг дээдлэн, шударга ёс, хувь хүний бие даасан байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх явдлыг дэмжих . Суралцагчдын бие биедээ болон хамт олондоо харилцан дэмжлэг туслалцаа үзүүлж, хөгжүүлэхэд анхаарна.
- 5.4 Дасгалжуулагчид ямар ч нөхцөлд суралцагчдынхаа эрх мэдэл, байр суурийг ашиглан өөртөө эсвэл хэн нэгэнд ашиг олох зорилгоор хууль бусаар олсон зүйлийг худалдах, худалдан авах үйлдлийг хэзээ ч гаргах ёсгүй гэдгийг анхаарах

6. Аюулгүй байдал

Дасгалжуулагчид нь сургалтын үеийн аюулгүй байдлыг бүрэн хариуцна. Аюулгүй байдал гэдэгт сургалт зохион байгуулах байр, танхимын буюу орчны, тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг ашиглах үеийн, эрсдэлтэй дасгал, техник хийх явцын суралцагчдын сэтгэл санааны зэрэг сургалтыг амжилттай зохион байгуулахад шаардлагатай бүхий л талыг анхаарна. Үүнд:

- 6.1 Суралцагчдын суралцах орчин аюулгүй эсэхийг баталгаажуулан хянах;
- 6.2 Болзошгүй аливаа эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалахын тулд ямар хариу арга хэмжээ авах, юу хийх ёстойг суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан ойлгуулах;
- 6.3 Хөгжилтэй, шударга байдал, хамтын ажиллагааг дэмжсэн сургалтын эерэг орчин бүрдүүлэх ёстой;

7. Багаар ажиллах

Дасгалжуулагч нь бусад байгууллага, ажилтнуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагааг нь дэмжих үүрэгтэй. Үүнд:

- 7.1 Шударга, итгэлцэл бүхий сургалтын орчин бүрдүүлэн ажиллах, сургалтын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох ёстой;
- 7.2 Сургалтын хэвийн үйл ажиллагаа ба суралцагчдын хөгжлийн асуудал нь ямар ч тохиолдолд эн тэргүүнд тавигдах ёстойг ямагт санаж байх,
- 7.3 Суралцагчдыг баг болж хамтран ажиллах, бие биеэ ойлгох, харилцан туслах явдлыг дэмжих,
- 7.4 Сургалт, үйл ажиллагаанд сайн дурын туслалцаа үзүүлэхийг хүссэн бусад байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллах,
- 7.5 Хамт олны санал зөрөлдөөнийг эергээр шийдвэрлэхийг хичээх. Ноцтой зөрчлийг холбогдох байгууллага, хүмүүст уламжлах замаар хамт олны дунд гарсан аливаа маргааныг эе зүйгээр, ухаалгаар шийдвэрлэх ёстой;
- 7.6 Дасгалжуулагч багш нийгмийн ажилтны ёс зүйн дүрмийг чанд баримтлан, нийтэч, нээлттэй шударга, мэдрэмжтэй хандан багийн уур амьсгалыг эвдэхгүй, бусдад саад учруулахгүйгээр хамтран ажиллах

8. Ажил эрхлэлтийн харилцаа

Дасгалжуулагч нь байгууллагатай хийсэн хөдөлмөрийн гэрээ, нөхцөлийг хүндэтгэх, өөрийн үйл ажиллагааны талаар тэдэнд тайлагнах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 8.1 Тухайн байгууллагын холбогдох ажилтныг сургалтын хэвийн үйл ажиллагаанд хувь нэмэр болохуйц аливаа мэдээллээр хангах ёстой;

СЭДЭВ 5.

СУРГАЛТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

Циркийн дасгал хийх, техник хэрэгслүүдтэй ажиллах явцад дагалдан гарах эрсдэлийн тухай мэдлэг нь аажим хуримтлагдсаар циркийн сургалтад аюулгүй байдлын тухай ойлголт болон хувирчээ. Дасгалжуулагч, нийгмийн ажилтнууд суралцагчдад энэ талаар тайлбарлан таниулах нь туйлын чухал. Сургалтыг эхлэхээс дуусталх бүхий л үе шатанд “Бид ямарваа нэгэн эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч чадсан уу?” гэдэг асуултыг байнга тавьж аюулгүй байдлыг хангаж байх үүрэгтэй.

Дасгалжуулагч, нийгмийн ажилтан нь “Нийгэмшүүлэх цирк” сургалтыг зохион байгуулахдаа хүний эрхийг дээдэлсэн оролцоог хангасан, аюулгүй орчин бүрдүүлэн ажиллана. Үүнд:

- Сургалтыг эхлэхээс өмнө тухайн байгууллагын аврах гарц хаана байрладаг, хаагуур яаж хүрч очдог, сургалтын танхимд анхны тусламжийн хэрэгслүүд болон гал унтраагуур байгаа эсэх, яаралтай үед тусламж дуудах байгууллагуудын утасны жагсаалтуудыг байршуулсан эсэх талаар мэдээллийг авч эдгээрийг биечлэн шалгана. Цаашилбал тухайн объектод хүний биед гэмтэл учруулахуйц зүйл байгаа эсэхийг нягтлаад хэрвээ байвал түүнийг сургалтын тахимаас холдуулан аюулгүй байдлыг хангана.
- Сургалт зохион байгуулах байр танхимын багтаамж нь суралцагчдад хангалттай зайтай, агаар чөлөөтэй солилцох боломжтой, танхимын температур хэт халуун биш, хүйтэн биш байх, хангалттай гэрэлтүүлэгтэй, байгалийн гэрэл тусах боломжтой, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө нь тусдаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан эсэх, хаалга нь оролцогч нарт нээлттэй эсэхийг тодруулан тайлбарласан байхад анхаарна.
- Сургалтыг гадаа талбайд зохион байгуулах үед хангалттай хэмжээний зай талбай байна уу? түүний эргэн тойронд аюул, эрсдэл учруулахуйц зүйл байна уу? гэх мэтээр байгууламжийн аюулгүй байдлыг түргэн хугацаанд үнэлнэ.
- Сургалт бүрийн өмнө аюулгүй байдлын хяналтын хуудсыг ашиглан үнэлгээг хийж хэвших нь эрсдэлийг бууруулж аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл болно гэдгийг санаарай.

- Нийгэмшүүлэх цирк сургалтын талаар олон нийтээд танилцуулах үйл ажиллагаа зохион байгуулах гэж байгаа бол оролцогч нараас зөвшөөрлийг нь авах, зөвшөөрлийн хуудсыг оролцогчоос болон гэр бүлээс нь бөглүүлэн авсан байх
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр оролцогчийн талаар мэдээллийг өгөх хэм хэмжээг баримтлан аюулгүй байдлыг хангахад чиглэн ажиллах

Сургалтыг зохин байгуулах явцдаа дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд эрсдэлийн үнэлгээг тогтмол хугацаанд хийнэ. Ингэснээр учирч болзошгүй ямарваа нэгэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх эсвэл түүнийг бууруулах арга замыг тодорхойлох боломжийг олгодог. Энэхүү үнэлгээ хийх жишээг хавсралтаар үзүүлэв.

Хавсралт 2

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖИШЭЭ

Заавар: Доор үзүүлсэн загварын дагуу асуулт тус бүрт түүний ард буй “Тийм”, “Үгүй”, “Зарим” гэсэн гурван хариултын аль тохироход нь “✓” тэмдэг тавих ба шаардлагатай бол тайлбар бичнэ. Гурван хариултаас тохирохыг сонгохдоо тухайн асуултын дагуу нөхцөл байдал ямар буйг ажиглах, харах, ярилцах, бичиг баримтыг судалж шинжлэх зэрэг аргыг хэрэглэнэ.

Санамж: Тухайн эд зүйл аюултай байгаа эсэхийг үнэлэхийн тулд харах, ажиглахдаа болгоомжтой байх нь зүйтэй. Жишээ нь цахилгааны утас шалбарч ил гарсныг илрүүлсэн бол гараараа барихгүй байх гэх мэт.

Хүснэгт 3

№	Эрсдэл	Тийм	Үгүй	Зарим	Тайлбар
Сургалт зохион байгуулах газрын дотоод орчин					
1	Тухайн байгууллагын гол болон бусад хаалга гадагшаа онгойдог уу?				
2	Сургалтын танхимын хаалганууд гадагшаа онгойдог уу?				
3	Танхимын цонхнууд төмөр хаалтгүй юу?				
4	Гадна орчин хангалттай гэрэлтүүлэгтэй юу?				
5	Гол хаалганы ойролцоо хагарах шилэн эдлэл зэргийг байрлуулаагүй, талбай нь аюулгүй, чөлөөтэй байна уу?				

6	Том, хүнд тавилгыг хананд бэхэлж хөдөлгөөнгүй, аюулгүй болгосон уу?				
7	Аврах гарц, хаалганууд чөлөөтэй, гарахад саадгүй байна уу?				
8	Аврах гарцыг заасан тэмдэг, тэмдэглэгээг хангалттай тоогоор, тохирох өндөрт, ойлгомжтойгоор байрлуулсан уу?				
9	Гал түймрийн үед хэрэглэх багаж хэрэгсэл бүрэн, зохих газраа байна уу?				
10	Гал унтраагуур хангалттай тоогоор байна уу?				
11	Гал унтраагуур аюулгүй, зөв байрласан байна уу?				
12	Гал унтраагуур хэвийн ажиллаж байна уу?				
13	Дулаан, сантехникийн шугам аюулгүй байна уу?				
14	Цахилгааны утас шалбараагүй, ил гараагүй байна уу?				
15	Залгуур эвдэрч унжаагүй, утас нь ил гараагүй байна уу?				
16	Амархан шатдаг материал, хэрэгсэл цахилгаан хэрэгслээс хол байна уу?				
17	Цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг байнга шалгадаг уу?				
18	Танхимын цонх дулаалгатай юу?				
19	Коридор, үүдний талбай нь хүн халтирч унахааргүй юу?				
20	Сургалтын талбай халтиргаа гулгаагүй, хуурай байна уу?				
21	сургалтын техник хэрэгслийг зөв хурааж байрлуулсан байна уу?				
22	Циркийн тоног төхөөрөмжүүдийн аюулгүй байдлыг урьдчилан шалгасан уу?				
23					
Сургалт зохион байгуулах газрын гадаад орчин					
1	Тухайн байгууллагын орчинд ойрхон авто зам байдаг уу?				
2	Явган хүний гарцын гэрэл, тэмдэглэгээтэй юу?				
3	Зам дээр авто машины хурд саагчтай юу?				

4	Огцом эргэлттэй зам байна уу?				
5	Явган хүний замтай юу?				
6	Зам гэрэлтүүлэгтэй юу?				
7	Гүнзгий гуу жалга байна уу?				
8	Байгууламжийн ойр орчинд таглаагүй бохирын нүх, шугам байна уу?				
9	Эрэгтэй, эмэгтэй хүнд тус тусад нь зориулсан бие засах газартай юу?				

Эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж гарсан эрсдэлүүдийг хэрхэн бууруулах, ямар арга хэмжээ авах талаар хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байгууллагатай хамтран ажиллаарай.

Нөгөө талаас доорх хэсгүүдэд анхаарлаа хандуулан аюулгүй байдлыг хангана. Үүнд:

1. Тоног, төхөөрөмж, техник хэрэгслүүдийн аюулгүй байдал
2. Сургалтын үеийн аюулгүй байдал
3. Сэтгэлзүйн аюулгүй байдал

Тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийн аюулгүй байдал:

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан модон хөл дээр явах гэж байгаа хүүхэд өвдөгний хамгаалалт зүүсэн үү? Шал нь халтиргаатай байна уу?, Акробатын дасгалын үеэр матрасыг хаана хэрхэн байрлуулсан байна? Хананд ойрхон байрлуулснаас хана мөргөх эрсдэл байна уу? Хүүхдүүд дасгал хийх үедээ хоорондын зайгаа хангалттай аваагүйгээс бие биетэйгээ мөргөлдөх аюул байна уу? гэхчлэн алхам тутмаа шалгах нь зүйтэй. Үүний тулд

- Багш нар оролцогчдын эрүүл мэнд, бие махбодын аюулгүй байдлыг бүрэн хариуцаж сургалтад хэрэглэж буй тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хянан засвар үйлчилгээг тогтмол хугацаанд хийж хэвших,
- Сургалтад хэрэглэж буй тоног төхөөрөмжийг хэрэглэж, ашиглаж буй давтамж, хугацаа зэргээс шалтгаалан хяналт шалгалт хийх,
- Тэр бүр сургалтад хэрэглээд байдаггүй тоног төхөөрөмжийг хэрэглэхээс өмнө түүний бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалгах,
- Өдөр бүр хэрэглэгддэг хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг сургалт бүрийн өмнө нягт нямбай шалгах,
- Дасгалжуулагч багш нар зарим тоног төхөөрөмжийн чанар, бүрэн бүтэн байдлын талаар хангалттай ойлголтгүй бол түүнийг мэргэжлийн хүнээр шалгуулах. Ийм боломжгүй бол тухайн тоног төхөөрөмжийг ашиглах шаардлагагүй.

Сургалтын үеийн аюулгүй байдал:

“Нийгэмшүүлэх цирк”- ийн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд нь өөр өөрийн гэсэн онцлог ялгаа бүхий оролцогчидтой ажилладаг. Тухайлбал: өөр өөр насны, эрэгтэй, эмэгтэй хүйсийн, янз бүрийн ааш араншинтай, эрүүл мэнд, биеийн өсөлт хөгжлийн хувьд харилцан адилгүй, хүмүүжил, төлөвшил нь өөр өөр, чадвар, туршлага, бие даасан байдал нь ялгаатай, бүлгээр ажиллах чадвар нь өөр өөр түвшинд байгаа гэх зэрэг олон хүчин зүйл нь төлөвлөсөн сургалтыг хэрхэн хэрэгжүүлэх, аюулгүй байдлын түвшнийг тодорхойлоход нөлөөлж байдаг.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд доор дурдсан зүйлст анхаарал хандуулан ажилласнаар суралцагчдад аливаа эрсдэлийг урьдчилан тооцоолох, гарах сөрөг үр дагаврын талаар ойлголттой болох, эрсдэлийг даван туулах арга ухаанд сургана. Жишээлбэл:

- Сургалтын үргэлжлэх хугацаа, хурд нь суралцагчдын нас, хүйс, эрүүл мэнд, биеийн хөгжил, чадварт тохирч байна уу?,
- Суралцагчид өөрийн биед эвтэй, дасгал хөдөлгөөн хийхэд өөрт нь саад болохооргүй хувцас өмссөн эсэхийг анхааралтай ажиглаарай. Жишээ нь: сургалтын үеэр зарим оролцогч бариу өмд өмсөх, жинсэн өмдтэй оролцох явдал байдаг. Энэ нь биеийн чөлөөтэй хөдөлгөөнд саад учруулах, дасгалын явцад өмд нь урагдах зэргээр эвгүй байдалд орох явдал байдаг. Ийм байдлаас шалтгаалан цаашид сургалтад орох дургүй болох, эвгүй байдалд орсноос шалтгаалан бусдаас ичих, өөртөө итгэх итгэл буурах магадлалтай.
- Жижиг гэлтгүй асуудлуудыг ч анзааралгүй орхигдуулж хэрхэвч болохгүй. Жишээ нь хүүхдүүд амандаа бохь, чихэр гэх мэт элдэв зүйлийг хийсэн байх нь бий. Энэ нь дасгалын явцад хахах, залгих зэргээр биедээ гэмтэл учруулах магадлалтай. Түүнчлэн оролцогч нь чихэндээ ээмэгтэй эсэх, гарт бугуйвч цаг гэх мэт эд зүйлийг сургалт эхлэхээс өмнө тусгайлан бэлдсэн хайрцагт хийж сургах.
- Суралцагчид сургалтын явцад учирч болох эрсдэлийг тодорхойлон түүнийг хэрхэн бууруулах арга замыг чиглүүлэгчтэй хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.
- Багш нар сургалтын эхэн үеэс л циркийн сургалтын аюулгүй байдлыг хангахын ач холбогдлыг суралцагчдад сайтар тайлбарлан ойлгуулснаар өөрийн аюулгүй байдалд улам бүр хариуцлагатай хандах зан төлөвт тэднийг сургана.
- Дасгал, техникийн заавар, аюулгүй ажиллагааг баримтлаагүйгээс гэмтэх, зарим тохиолдолд суралцагчдын санамсар болгоомжгүй үйлдлээс хэн нэгнийг гэмтээх, бэртэх тохиолдол гарч болзошгүй.

Ийм үед дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан гэмтэж бэртсэн суралцагчид, хамтран ажиллагсдад эмнэлгийн мэргэжлийн тусламж ирэх хүртэл анхны тусламжийг зөв үзүүлэх мэдлэг аргазүйг зайлшгүй эзэмших шаардлагатай. Анхны тусламжийг цаг алдалгүй зөв үзүүлснээр амь насыг авраад зогсохгүй эдгэрэлтийг түргэсгэн, цаашид учрах хүндрэлээс урьдчилан сэргийлэх боломжтой.

Дасгал, техникт суралцах үеийн аюулгүй байдал: Дасгалжуулагч багш суралцагчдын хийж буй дасгал хөдөлгөөнийг анхааралтай ажиглан бие халаалт хийсэн эсэхийг анхаарахын зэрэгцээ тэнцвэрийн болон үсрэлт, харайлтын төрлүүдийг сонирхон хичээллэж байгаа суралцагчдыг тухайн дасгалыг хийж суртал нь аюулгүй байдлыг ханган хамтран ажиллах шаардлагатай. Бие халаалтын дасгал хийх нь сургалтын хамгийн чухалд тооцогддог үе шат юм. Түүнчлэн дасгал техникийн хүндийн зэрэг нь тухайн суралцагчийн ур чадварыг тодорхойлж байдаг. Хэрвээ суралцагчийн ур чадварт эргэлзэж байгаа бол тухайн дасгалыг аюулгүй нөхцөлд хэд хэдэн удаа хийлгэж үнэхээр чадаж байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.

Сэтгэлзүйн аюулгүй байдал:

Суралцагч бүр сургалтын орчныг хамгийн аюулгүй, найдвартай орчин гэж бүрэн итгэж хүлээж авдаг тул дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнаас сургалтын өвөрмөц аюулгүй найдвартай орчин бүрдүүлэхийг шаардаж байдаг.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд суралцагчдын бие махбодын болон орчны аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ тэдний сэтгэлзүйн аюулгүй байдлыг хангахад анхаарна. Суралцагч бүрийн эрүүл мэнд, зан төлөвийн болон бусад мэдээлэл, тэдний эцэг эх, гэр бүлийн гишүүдтэй холбоо барих утасны жагсаалтыг холбогдох ажилтнуудаас авна. Ингэхдээ бусдын хувийн мэдээллийг сайтар нууцлах, нууцыг задруулахгүй байх ёсзүйг чанд баримтална.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр сургалтыг эхлүүлэхдээ суралцагчид сэтгэлзүйн хувьд сургалтад бэлэн байгаа эсэхийг гяргай ажиглана. Жишээ нь хэн нэгэн суралцагч биеийн болон сэтгэлийн зовуурь шаналгаатай байна уу? гэх мэт,

“Нийгэмшүүлэх цирк” сургалт нь суралцагчид хоорондоо буюу дасгалжуулагч багш суралцагчдын хооронд тэгш байдал, шударга зарчим, тэгш оролцоог хангасан, харилцан бие биеэ хүндэтгэсэн орчин нөхцөлд явагдах учиртай. Тухайлбал суралцагчид ямар нэгэн байдлаар сэтгэл санааны дарамтад өртөхгүй, бие биеэ хүндэтгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр харилцах,

суралцагчидтай холбоотой нууцыг бусдад задруулахгүй байх нөхцөлийг юуны түрүүнд бүрдүүлнэ.

Сургалтыг зохион байгуулж буй байгууллага бүр:

- Хүүхэд хамгааллын бодлоготой, түүнийг хэрэгжүүлдэг байх;
- Сэтгэл хөдлөлийн сайн сайхан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- Бүлгийн хөгжил, асуудлуудыг анхааран ажилладаг байх;
- Үйл ажиллагааг тайлагнах явц нь ойлгомжтой, тодорхой байх шаардлагатай.

Дасгалжуулагч багш болон нийгмийн ажилтны аюулгүй байдал

Суралцагчдын аюулгүй байдлыг хангахаас гадна багш нар өөрсдийн аюулгүй байдлыг хангахад анхаарна. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудад суралцагчдын дундах хэрүүл маргаан, зодоон, бохир хувцас, халдварт өвчин, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай суралцагчдын зан байдал, мансууруулах бодисын хэрэглээ гэх мэтээр олон эрсдэлт хүчин зүйлс тулгарч тэдгээрийг зохицуулах шаардлага гардаг. Сэтгэл хөдлөлийн аюулгүй байдлыг хөндөх, хувийн болон мэргэжлийн ёс зүйн асуудлуудыг үүсгэхгүйн тулд оролцогч талуудтай хувийн харилцаа холбоо тогтоохоос зайлсхийх нь чухал юм.

Зарим хүнд нөхцөл дэх хүүхэд залуучуудын эрүүл мэнд асуудалтай байх нь бий. Ялангуяа бэлгийн замын халдварт өвчин, сүрьеэ гэх мэт халдварт өвчөөр өвчилсөн байх нь бий. Нийгмийн ажилтны зүгээс эрүүл мэнд, эрүүл ахуй, хувийн ариун цэврийн талаар мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах, ганцаарчилсан зөвлөгөөг өгөх нь циркийн багш, ажилтнууд, суралцагчдад эрүүл мэнддээ анхаарал тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, аюулгүй байдлаа хангахад чухал нөлөө үзүүлдэг.

БҮЛЭГ III.

ЦИРКИЙН ҮНДСЭН ТӨРЛҮҮД, ДАСГАЛ ТЕХНИКИЙН ЗААХ АРГАЗҮЙН ЗӨВЛӨМЖ

Циркийн урлаг нь акробат, гимнастик, жонглёр, тэнцвэр, алиалал гэсэн үндсэн төрлүүдтэй. “Нийгэмшүүлэх цирк” сургалтад хүүхдийн нас, биеийн онцлог, чадварт тохируулан циркийн төрлийг сонгон заах нь чухал.

Циркийн төрөл тус бүр өөрийн онцлогтой төдийгүй дасгал техникийн аюулгүйн ажиллагааны зааварчилгаатай.



СЭДЭВ 1.

АКРОБАТЫН ТӨРӨЛ

Акробат нь “өлмий дээрээ явагч”, “авирагч” гэсэн утгатай грек үг юм. Хүн өөрийн болон бусдын гар, хөл, толгой, бие дээр эсвэл ямар нэг эд зүйл дээр тэнцэж зогсох элементийг акробат гэж нэрлэх ба акробат хийх үед хүний биеийн бүх булчин ажиллана. Циркийн энэ төрөл нь хүнээс авхаалж самбаа, багийн ажиллагаа, мэдрэмж зэрэг олон чадварыг шаарддаг. Акробат нь хүнд өөрийн бие махбодыг мэдрэх, өөртөө болон бусдад итгэх, бэрхшээлийг даван туулах, бие махбодын хөдөлгөөний хязгаарлагдмал байдлаа ойлгох боломжийг олгодог.

Акробат нь үсрэлттэй, банзтай, агаарын, морь болон бусад техник хэрэгсэлтэй хийх акробат, овоолго буюу пирамид зэрэг олон төрөлтэй. Акробатын төрөлд хамаарах пирамид буюу овоолгыг нийгэмшүүлэх цирк сургалтад түгээмэл хэрэглэдэг.

Овоолго буюу пирамид

Овоолгыг хийхдээ хэд хэдэн хүн нэгэн баг болж хамтран бие биеэ дэмжин төрөл бүрийн тодорхой хэлбэр дүрс үүсгэх үйлдэл гүйцэтгэнэ.

Овоолгын хэлбэр, оролцож буй оролцогчдын тооноос шалтгаалан олон төрөл хэлбэрийг санаачлан хийх боломжтой. Үндсэн бүтэц нь суурийн хэсэг, сууриас дээш үелэн үүсэх дээд хэсгүүд, суурийн хэсгээс хоёр тийш салбарласан хэсгүүдээс бүрдэнэ. Суралцагчдын чадвар, төсөөлөл, сэтгэмжид тулгуурлан аюулгүй байдлыг сайтар хангасан нөхцөлд илүү ур чадвар шаардсан хэлбэр, дүрс бүтээх боломжтой.

Овоолгын суурь болон бусад хэсгүүд аль аль нь хөдөлгөөн багатай тэнцвэртэй байж, бие биеэ дэмжин, тогтвортой байснаар бат бэх овоолгыг үүсгэх нөхцөлийг бүрдүүлнэ. Акробатын энэ төрөл нь суралцагчаас сахилга бат, тэсвэр хатуужил, тэнцвэртэй байдал, цаг хугацааг их шаарддаг.

Овоолгыг хийснээр суралцагчдын бие бялдар сэтгэлзүй, нийгэмшихүйн хөгжилд дараах эерэг нөлөөллийг үзүүлдэг байна. Үүнд:

Хүснэгт 6

Бие бялдрын хувьд	Сэтгэлзүйн хувьд	Нийгэмшихүйн хувьд
<ul style="list-style-type: none"> - Тэнцвэрээ олж сурах, тэнцвэрээ хадгалах, - Хүч чадал нэмэгдэх, - Биеийн уян хатан байдал сайжрах, - Хөдөлгөөн зохицуулалт сайжрах 	<ul style="list-style-type: none"> - Асуудал шийдэх чадвартай болох, - Анхаарал төвлөрөлт сайжрах, - Туршилт хийх сэдэл, сонирхолтой болох, - Өөртөө болон бусдад итгэх итгэл нэмэгдэх, - Бүтээлчээр сэтгэх чадвар сайжрах 	<ul style="list-style-type: none"> - Бүлгээр хамтран ажиллах чадвар нэмэгдэх, - Бусдыг манлайлах чадвар сайжрах, - Бие биедээ харилцан туслах сэтгэлгээтэй болох

Овоолгын олон төрөл хэлбэрийг хийж хамтран ажилласнаар суралцагчдын хоорондын харилцаа сайжрах, багаар ажиллаж сурахад ач холбогдолтой. Харин дасгалжуулагч багш, нийгмийн ажилтны зүгээс суралцагч бүрийн бие бялдрын онцлог, оюун ухааны бодит чадамжыг хүндэтгэн үзэх нь чухал юм.

Овоолго хийх техникийг заах аргазүйн зарчим

Овоолгыг хэрхэн хийх техникийг хүүхдүүдэд заахдаа сурганы олон төрлийн арга барилыг хэрэглэх нь үр дүнтэй. Жишээ нь: Аргачлалыг суралцагчдад энгийн ойлгомжтой үгээр тайлбарлах, зураг, дүрс үзүүлэх, зурж тайлбарлах, видео бичлэг, кино үзүүлэх, дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд тухайн бүлгийн идэвхтэй сайн сурсан, чадваржсан хүүхдүүдтэй баг болж хамтран ямар дарааллаар хэрхэн хийхийг биетээр туршин үзүүлэх зэрэг аргууд байж болно.

Сургалтын явцад дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд суралцагчдын:

- Сонирхлыг өдөөн сэдэлжүүлэх,
- Урамшуулан дэмжих,
- Ялгаатай байдлыг ойлгон, хүндэтгэн харилцах үндсэн зарчмуудыг мөрдөнө.

Овоолго хийх үеийн аюулгүй байдлыг хангах

Суралцагчдыг эрсдэлээс урьдчилан сэргийлж аюулгүй байдлыг хангахдаа:

1. Хүүхдүүд биедээ тохирсон чөлөөтэй, эвтэйхэн хувцас өмссөн эсэхийг өдөр бүр шалган, зөвлөх,
2. Сургалт бүрийн эхэнд аюулгүй ажиллагааны дүрэм, зааварчилгааг өгөх,
3. Зөвхөн тухайн дасгал техникт шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийг үлдээн талбайг чөлөөлнө. Ингэхдээ ашиглагдах тоног

- төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг урьдчилан сайтар шалгах,
4. Эхлэн суралцагчдын хувьд дасгал техникийг хийх үед овоолго нурж хүүхдүүд унах явдал гардаг. Иймд 3 см-ээс нимгэнгүй матрасс зөөлөвч дээр овоолгыг хийж эхэлнэ. Аажмаар дасгал техникт суралцан, аюулгүйн техникийг бүрэн эзэмшсэний дараа зөөлөвчийг нимгэрүүлэн хивс, хивсэнцэр ашиглаж болно,
 5. Оролцох хүүхдүүдийн дунд эрүүл мэндийн болон сэтгэлийн зовуурь, шаналгаатай хүүхэд байгаа эсэхийг урьдчилан сайтар ажиглан, ярилцаж мэдэх,
 6. Бие халаах дасгалыг заавал хийх,
 7. Хэдэн оролцогчтой ямар хэлбэрийн овоолго хийх зааврыг хүүхдүүдэд энгийн үгээр ойлгомжтойгоор тайлбарлана. Овоолгын энгийн хялбар хэлбэрээс аажмаар хүнд, төвөгтэй хэлбэрт шилжүүлэн гүйцэтгэнэ,
 8. Оролцогчдын биеийн хэмжээ, жин, бие бялдрын бодит боломж зэргийг тооцоолон сонголтыг хийхэд анхаарна.

ОВООЛГО ХИЙХ ҮНДСЭН ТЕХНИК

Циркийн төрлөөр амжилттай сургах үндсэн нөхцөл нь техникийг зөв эзэмших заавар, зааварчилгааг зөв чиглүүлэх явдал юм.

Овоолгын үндсэн техникүүдийг танилцуулъя: Үүнд:

1. Гараас барих техник

Гар барих техник нь овоолгыг хийх явцад өөрийн болон хамтрагчийнхаа тэнцвэрийг хадгалах, овоолгын үе үүсгэн дээш татах гэх мэтээр бие биедээ дэмжлэг үзүүлэхэд олонтоо хэрэглэнэ. Дасгалжуулагч багш гарын барилтын үндсэн техникийг заахдаа суралцагч бүрт ойлгомжтой харагдахуйцаар биеэр хийж үзүүлэх, зургаар зурж тайлбарлах зэргээр ойлгуулах хэрэгтэй. Дараа нь бүх оролцогчдыг хосоор бүрэн зөв хийж чадах болтол олон удаа давтан хийлгэнэ.

- а) Гараа зөрүүлэн атгалцах. Хоёр хүн хоорондоо мэндчилж байгаа юм шиг гарын алгаараа зөрүүлэн атгасан байдалтайгаар гараа барилцана.



Зураг 1

2. Гарын хуруунуудыг зөрүүлэн чангалан атгалцах. Энэ барилт нь оролцогчийг байраа эзлэхэд их дэм үзүүлдэг.



Зураг 2

3. Бугуй бугуйнаасаа атгалцах. Энэ барилт нь тэнцвэрийг хадгалах, оролцогчид хоорондоо таталцан тэнцэх зэрэгт ашиглагддаг.



Зураг 3

4. Гарын тохой бугалгаас барих. Энэ техник нь суралцагчид хоорондоо урвуу байрлалд байр эзлэх тохиолдолд ихэвчлэн хэрэглэгддэг. Суралцагч овоолгын үе үүсгэн хэн нэгнийг дээрээ гаргах тохиолдолд бие биеийнхээ гарын тохой, бугалга буюу гурван толгойт булчингийн хүчийг ашиглан зөөвөрлөнө.



Зураг 4

5. Дөрвөлжин суурь үүсгэн барих. Хоёр хүн хоорондоо гараа бугуйгаараа зөрүүлж холбон дөрвөлжин суурь үүсгэн барих техник нь суралцагчдыг овоолгын орой хэсэг рүү авиран гарахад нь дэмжих үед хэрэглэдэг.



Зураг 5

6. Гар дээр зогсох. Үе үүсгэхээр дээд талд гарах суралцагчийг авирах, тэнцүүлэх, тэнцвэрийг хадгалахад нь хэрэглэнэ. Доод талд суурийг үүсгэж буй суралцагчийн гарын алганы төгсгөлийн зузаан хэсэг дээр дээд талын хүн хөлийн өсгийн хэсгээр гишгэн тэнцвэрээ олно.




Зураг 6

7. Бүс ашиглах техник. Овоолгын хэлбэрээс шалтгаалан дээшээ үе үүсгэх хүний бүсэлхий хэсгээс бэхэлсэн бүснээс барин тэнцвэрээ хадгална.




Зураг 7

8. Бие биеэсээ эсрэгцэн таталцаж тэнцэх. Энэ тохиолдолд таталцан тэнцэж буй суралцагчдын гар тохойгоороо шулуун, хөл өвдгөөрөө тэнийсэн, хөлийн өлмийг хооронд нь тулган нийлүүлсэн байдалтай байна. Овоолгын хэлбэрээс шалтгаалан зарим тохиолдолд доош хагас суугаа байдлаар, хамтрагчид өгзгөөрөө хойш өнцөг гаргах гэх мэтээр тэнцвэрээ олох боломжтой. Энэхүү техникийн хэрэглээг доорх зургаас үзнэ үү?



Зураг 8

9. Бие бие дээрээ давхарлан үе үүсгэх. Энэ техникийг хийхийн тулд овоолгын суурийн хүн нэг өвдгөө нугалсхийн доош хагас сууна. Дээд талын оролцогч түүний өвдөг дээр тулгуур хийн гишгэж улмаар дээш авиран мөрөн дээр нь хоёр хөлөөрөө тулан тэнцвэрээ олж цэх зогсоно. Энэ үед суурийн хүн түүний хоёр хөлийн шилбээс барин хөл дээрээ хүндийн жинг өгөн дээш босож цэх зогсон тэнцвэрээ олно. Энэ мэтчилэн дээш хэдэн ч үе үүсгэн давхарлах боломжтой.




Зураг 9

10. Овоолгын суурь бүрдүүлэх. Ямар ч тохиолдолд овоолгын суурь бат бэх, тогтвортой байх шаардлагатай. Суурийн хүн газарт дөрвөн хөллөн (зурагт үзүүлсэнчлэн) байрлалаа эзлэх бөгөөд гар тохойгоороо шулуун, хөлөө өвдгөөрөө нугалан, хөлийн шилбийг газарт наалдуулж өгнө. Мөр, нуруу хонго тэгш газарт перпендикуляр байрлалтай байна.




Зөв техник



Буруу техник


Зураг 10

Овоолгын хэлбэрээс хамааран зарим тохиолдолд суурийн хүн зогсоо байрлалаас урагш хагас тонгойн хөлдөө мөрний хэмжээтэй зай авч хөлөө чангалан, хоёр гараар өвдгөө тулж тэнцэн зогсоно. Энэ техник нь суурийн хүн тэнцвэрээ удаан хугацаанд хадгалахад тустай байдаг.



Зураг 11

Суурийн хүн болон түүний мөрөн дээр зогсон дээш үе үүсгэх хүний аль аль нь нуруу тэгш, толгойгоо урагшаа эгц харсан байрлал эзлэхээ хоорондоо ойлголцсон байх нь нэн чухал. Техникийг зөв гүйцэтгэснээр хүндийн жингээ хадгалан овоолго тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлдэг.




Зөв техник

Буруу техник

Зураг 12

Суурийн хүн 10-р зургийн байрлалыг эзэлнэ. Түүний дээр үе үүсгэн зогсох хүн суурийн хүний ахар сүүл, хонгоны зузаан хэсэг дээр гишгэн зогсож тэнцвэрээ олно. Хэрвээ суурийн хүн болон түүнээс дээш үе үүсгэн зогсох хүмүүсийн аль аль нь нуруугаа хотойлгох, толгойгоо бөхийлгөх зэргээр үндсэн техникийг буруу гүйцэтгэвэл суурийн хүний биед хүчтэй өвдөлтийг үүсгэж овоолго тогтворгүй болж нурах аюултай.



Зураг 13

Овоолгын үндсэн техникийг гүйцэтгэхдээ анхаарах зүйл:


1. Овоолгын дээр үе үүсгэн зогсох оролцогчид суурийн хүнийг гэмтээхгүйн тулд анхаарал болгоомжтойгоор түүний хаана яаж гишгэх, хаанаас хэрхэн барих талаар бүрэн, зөв ойлголттой байх шаардлагатай. Иймд дасгалжуулагч багш оролцогчдыг заавар, зөвлөгөөг сайн ойлгосон эсэхийг бүрэн шалгасны дараа дасгалыг эхлүүлнэ.
10. Хоёр болон түүнээс дээш үетэй овоолго хийхдээ дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан оролцогчдыг унаж гэмтэхээс урьдчилан сэргийлж хажууд нь заавал хамгаалж зогсоно.
11. Овоолгыг хийж дууссаны дараа оролцогчид ахлагчийн командаар хамгийн дээд талын оролцогчоос эхлэн доош дэс дараагаараа цуварч бууна.
12. Овоолгын суурийн хэсэгт биерхүү, өндөр, жин ихтэй оролцогчдыг, дунд эгнээнд дундаж жин, өндөртэй, овоолгын оройн хэсэгт жижиг биетэй оролцогчдыг зогсоох гэсэн дарааллаар хийнэ.
13. Овоолгын суурь болсон хүүхдүүд эхэлж байраа зөв эзлэн овоолгыг

гүйцэтгэхэд бэлэн болсноо бусдадаа команд өгч мэдэгдэнэ. Командын дагуу бусад оролцогчид дарааллаа зөв эзлэн зогсож дасгалыг гүйцэтгэнэ.


Овоолго хийхэд гардаг нийтлэг алдаа:

1. Оролцогчид байрлалаа буруу эзлэх,
2. Дарааллын дагуу байрлалаа эзлэлгүй, яарч гарах,
3. Командыг сонсохгүй байх,
4. Оролцогчдын биеийн хэмжээ, өндөр, жинг үл харгалзан тэнцвэргүй зохион байгуулалт хийх,
5. Ямар хэлбэртэй хэдэн үеэс бүтсэн овоолго хийх гэж байгаа талаарх мэдээллийг оролцогчдод хангалттай зөв тайлбарлаагүй байх зэргээс үүдэн гүйцэтгэлийн үед оролцогчид бие бие дээрээ дарж унан гэмтэх эрсэлтэй.

Орчны аюулгүй байдлыг сайтар ханган, овоолго хийх зөв техникийг бүгд эзэмшсэний дараа дасгалыг дараах зургуудад үзүүлсэн байдлаар зохиомжлон хийх боломжтой.



Зураг 14



Зураг 15

Энэхүү гарын авлагаараа шат, индэр, тулгууртай сандал, солонго хэлбэрийн овоолгуудыг хийх техникийг танилцуулъя.


ШАТ ХЭЛБЭРИЙН ОВОЛГО

Энэхүү овоолгыг 3 хүний оролцоотойгоор хийнэ.

Бие халаалт: Бие халаах дасгал, хөдөлгөөнийг сургалт бүрийн эхэнд болон төгсгөлд заавал хийнэ. Энэ нь хүний биеийг тухайн дасгал хөдөлгөөнийг хийхэд бэлтгэх төдийгүй зөв хийж гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн дасгалыг хийх явцад бэртэж гэмтэх аливаа эрсдэлийг бууруулах ач холбогдолтой. Бие халаалтын явцад булчингууд тайван үеийнхээс илүү их эрчимтэй хөдөлгөөнүүдийг хийх боломжтой болдог. Хүний биеийн физиологийн үйл ажиллагааг тайван байдлаас дасгал хийхэд зохицон шилжих нөхцөлийг бүрдүүлнэ. Дасгал хийх явцад идэвхтэй ажиллаж байгаа булчингуудын цусан хангамж ердийн үеийнхээс хэд дахин нэмэгддэг. Мөн бие халаалтын явцад үе хоорондын холбоос эдүүдийн тослог шингэний ялгаралтыг нэмэгдүүлэн,

үе мөчийг уян налархай болгож, хөдөлгөөний ачааллыг даах чадварыг нэмэгдүүлнэ. Бие халаалтын дасгалыг хийхдээ 10-15 минутын хугацаанд хөнгөн дасгалаас аажмаар эрчимтэй дасгал хийж эргээд хөнгөн хэлбэрийн дасгал хөдөлгөөнөөр төгсгөнө. Бие халаах дасгалыг дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан урьдчилан ярилцаж бэлтгэнэ.

Бэлтгэх байдал:



Зураг 16

Овоолгыг хийх оролцогчид анхааралтай байж бэлтгэх байдалд байраа эзэлнэ. Оролцогчдын хэн нь овоолгын суурь болох, хэн нь хоёр дахь хүн болох, хэн нь орой буюу гурав дахь хүн болохоо урьдчилан ярилцаж шийдсэн байна. Суурийн хүн газарт дөрвөн хөллөн гартаа мөрний хэмжээтэй зайтай тохой шулуун, гарын сарвуунуудыг тэнийлгэн, алгаараа газарт бүрэн тулсан байрлал эзэлнэ. Хоёр хөлийн хооронд бага зэргийн зайтай, өвдгөө нугалан өлмийг хойш жийж газарт наалдуулна. Нурууг хотойлгох эсвэл бөгтийлгөхгүйгээр тэгшлэн биеэ чангална (цаашид энэ байрлалыг газарт дөрвөн хөллөх гэж нэрлэнэ)

Үндсэн техник

- Хамгийн түрүүнд суурийн хүн газарт дөрвөн хөллөн тогтвортойгоор байрлалаа эзэлнэ.
- Овоолгыг үүсгэх хоёр дахь хүн суурийн хүнээс ялимгүй зайтай зогсоно.

Тэрээр хөлдөө мөрний хэмжээтэй зай аван урагш бөхийн хоёр гарын алгаар суурийн хүний хоёр далны орчим тулж зогсоно. Энэ үед биеийнхээ жинг хоёр хөлд төвлөрүүлнэ.

- Овоолгын оройг үүсгэх хүн суурийн хүний хажууд зэрэгцэн зогсож бэлтгэх байдалд байрлалаа эзэлнэ. Энэ үед биеийн байрлал нь суурийн хүнтэй зэрэгцээ, овоолгын хоёр дахь хүнтэй өөд өөдөөсөө харсан байрлалд байна. Дараа нь өөдөөсөө харан зогсох овоолгын хоёр дахь хүний хоёр мөрөн дээр хоёр гараараа зэрэг дарж, нэг хөлөөрөө суурийн хүний ууцан хэсэг дээр гишгэн тулж биеэ дээш татан гарч зогсоно. Ингэхдээ цээжин биеэрээ бага зэрэг урагш бөхийж хоёр дахь хүний мөрний далны дээд хэсэгт хоёр гарын алгаараа бүрэн дарж тулна. Энэ үед хоёр гар тохойгоор шулуун булчинг чангалах бөгөөд хоёр хөл шулуун, булчинг чангална. Үндсэн байрлалыг эзлэн тогтвортой, бат зогссоны дараа өрөөсөн хөлөө хойшоо эсвэл дээшээ савах хөдөлгөөнийг зохиомжлон хийж болно. Энэхүү дараалал, техникийн дагуу шат хэлбэрийн овоолгыг үүсгэнэ.


Шат хэлбэрийн овоолгыг хийхэд гардаг нийтлэг алдаа

1. Овоолгод оролцож буй оролцогчид тогтворгүй, хөдөлгөөнтэй байх,
2. Овоолгын хэн нэгэн эсвэл бүгд үндсэн байрлалаа буруу эзлэх,
3. Суурийн хүн байрлалаа бүрэн эзлээгүй байхад дээд талын хүн яарч гарах,
4. Оролцогчид дасгалжуулагч багшийн командыг сонсохгүй байх,
5. Оролцогчдын биеийн жин болон биеийн хэмжээг үл харгалзан тэнцвэргүй зохион байгуулалт хийх зэргээс үүдэн бие бие дээрээ дарж унан гэмтэх эрсэлтэй.

Овоолгыг техникийн дагуу зөв хийх зөвлөмж

1. Овоолгыг зөв хийх дараалал, техникийг тайлбарлан ойлгуулах,
2. Суурийн хүн хөлдөө бага зэргийн зай авч хүндийн жинг хөлдөө шилжүүлнэ,
3. Сууриас дээш үе үүсгэхдээ техникийг зөв гүйцэтгэх,
4. Овоолгын хоёр дахь үеийн хүн өлмий өсгийний байрлалаа зөв авсан эсэхийг дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хянах,

Гурван хүнээр овоолго үүсгэх хувилбаруудыг Зураг 17-оос харна уу?
10-17 насны хүүхдүүдийн хувьд дараах энгийн хэлбэрүүдийг хийж туршин хүндрүүлсэн хэлбэрт аажмаар шилжүүлнэ:



Зураг 17

ИНДЭР ХЭЛБЭРИЙН ОВООЛГО


Энэ овоолгыг дөрвөн хүний оролцоотойгоор хийнэ.

Бие халаах дасгал: 10-15 минут

Бэлтгэх байдал:

Овоолгын энэ хэлбэр нь гурван давхар үеэс бүрдэх бөгөөд суурийн хэсэгт хоёр хүн, хоёр дахь үед нэг хүн, оройн хэсэгт нэг хүн нийт дөрвөн хүн оролцоно.

Оролцогчдын хэн нь ямар үүрэгтэй хаана ямар байрлал эзлэхээ урьдчилан сайтар ярилцан шийдсэн байна. Бүгд анхааралтай байж бэлтгэх байдалд байраа эзэлнэ.



Зураг 18

Үндсэн техник

1. Суурийн хоёр хүн газарт дөрвөн хөллөх үндсэн техникээр хоёр тийш зөрж байрлана. Ингэхдээ хөлийн өлмий нөгөө хүний өвдөгнөөс урагш илүү гарахааргүйгээр хөлийн шилбэ давхардсан байдалтай байна.

2. Овоолгын хоёр дахь үеийг үүсгэж буй нэг хүн суурийн хоёр хүн дээр гарч дөрвөн хөллөх байрлал эзэлнэ. (баруун эсвэл зүүн тийш харахаа урьдчилан ярилцаж шийднэ) Энэ үед хоёр өвдгөө суурийн нэг хүний аарцаг нурууны төгсгөл хонгоны дээд хэсэгт тулан хөлийн шилбэ өлмийг жийж өгнө. Зөв байрлал эзэлсэн бол энэ үед хөлийн өлмийн хэсэг суурийн хүний далны дээд хэсэгт хүрсэн байна. Хоёр гар суурийн хоёр дахь хүний нурууны төгсгөл, хонгоны дээд хэсэгт алгаараа бүрэн дарна. Гарын тохой эгц шулуун, булчингаа чангалан нуруу тэгш, толгой урагш харсан байрлал авна. Хажуугаас нь харвал суурийн аль нэг хүнтэй толгой нэг зүгт харсан байна.
3. Оройн хэсгийн хүн үе үүсгэх үндсэн техникийн дагуу байрлалаа эзэлнэ. Тэрээр овоолгын хоёр дахь үений хүний хөлийн ачааллыг авсан суурийн хүний нурууны далны дээд хэсэгт нэг хөлөөр гишгэж, хоёр гараараа овоолгын үе үүсгэж буй хүний бүсэлхий орчмоос ялимгүй татасхийн биеэ дээш өргөн суурийн хүний нуруун дээр гарч зогсоно. Овоолгын оройг үүсгэхийн тулд нэг хөлөө овоолгын хоёр дахь үенд суурь болсон хүний аарцаг, нурууны төгсгөл хэсэг хонгоны орчим тавьж, гараараа түүний мөрнөөс нь ялимгүй татан хүч авч нуруун дээр нь авиран гарна. Ингээд дээш босож зогсохдоо нэг хөл аарцаг нурууны төгсгөл хонгоны орчим хөлийн улаар бүтэн гишгэнэ. Нөгөө хөл суурийн хүний мөрний доод, далны дээд хэсэгт улаараа бүтэн гишгэж хоёр гарыг ташаандаа авч хажуу тийш харан тэнцэн зогсоно. (Зураг 18-аас харна уу)

Индэр хэлбэрийн овоолгыг хийхэд гардаг нийтлэг алдаа

1. Суурийн хүмүүс техникийг дарааллын дагуу хийхгүй байх,
2. Суурийн хүний дээр зогсож байгаа хүмүүс байрлалаа буруу эзлэх,
3. Овоолгын бүх хүн эсвэл хэн нэг нь тогтворгүй хөдөлгөөнтэй байх,

Индэр хэлбэрийн овоолгыг техникийн дагуу зөв хийх зөвлөмж

1. Суурийн хүмүүс нуруугаа тэгшлэх,
2. Овоолгын бүх оролцогч хүндийн жингээ тэнцүүлэх, биеэ тэнцвэртэй байлгахад нь дасгалжуулагч багш ойр байж зөвлөн дэмжинэ,

ТУЛГУУРТАЙ САНДАЛ ХЭЛБЭРИЙН ОВООЛГО

Энэ овоолгыг таван хүний оролцоотойгоор хийнэ.

Бие халаах дасгал: 10-15 минут

Бэлтгэх байдал

Овоолго нь 3 үеэс бүрдэх бөгөөд суурийн хэсэгт хоёр хүн, хоёр дахь үенд хоёр хүн, оройн хэсэгт нэг хүн орно.



Зураг 19

Үндсэн техник

- Суурийн хоёр хүн өөд өөдөөсөө харан хөлийн улаар газар бүрэн гишгэж өвдгөө нугалан өгзгөөр тулж, гарын сарвуунуудыг тэнийлгэн алгаараа бүрэн газарт тулна. Тохой шулуун байна.
- Толгой цэх өөд өөдөөсөө харна. Бусад гурван оролцогч суурийг бүрдүүлэх хоёр хүний хажууд бэлтгэх байдалтай зогсоно.
- Суурийн хоёр хүний өвдгөн дээр овоолгын хоёр дахь үеийн хоёр хүн өөд өөдөөсөө харан сууна. Тэдний өвдөг хоорондоо тулж нийлсэн байх бөгөөд хөл нь суурийн хүний хөлийн гадна талд газарт улаараа бүтэн гишгэсэн байна.
- Овоолгын оройг үүсгэх хүн овоолгын хоёр дахь үеийг бүрдүүлж байгаа

хоёр оролцогчийн мөрөн дээр гараа тавьж нэг хөлөөрөө нэгнийх нь гуя дээр улаараа гишгэхэд бэлтгэнэ. Дараа нь хоёр гараараа тэдний мөрөн дээр дарж хөлөө салган хоёр оролцогчийн гуян дээр улаараа бүрэн гишгэн тулж зогсоно. Хоёр гарыг ташаандаа авч толгой эгц зогсоно. Энэ үед овоолгын хоёр дахь үеийн хүмүүс нэг гараараа оройн хүний хөлийн өвдөгний үеэр гаднаас дотор тал руу, нөгөө гараараа шилбэний доод шагайн хэсгийн дотор талаас барьж тогтвортой байдал, тэнцвэрийг хангаж өгнө. (Зураг 19 харна уу)

Овоолгыг хийхэд гардаг нийтлэг алдаа

1. Оролцогчид техникийг буруу гүйцэтгэх,
2. Бие биеэ сонсохгүй байх,

Овоолгыг техникийн дагуу зөв хийх зөвлөмж

1. Суурийн хоёр хүн газарт гараараа тулан суухдаа хөлөө хооронд нь бага зэрэг салгах нь илүү бат бэх байх үндсэн нөхцөл болно,
2. Овоолгын хоёр дахь үеийн оролцогчид биеийн жингээ түргэн хугацаанд өгзөг, гуя руу шилжүүлэх,
3. Суурийн оролцогчид өөртөө итгэлтэй бат суух нь оройн хэсгийн оролцогч тэдэн дээр холбирахгүйгээр гарч зогсох итгэлийг бий болгоно.


СОЛОНГО ХЭЛБЭРИЙН ОВООЛГО

Овоолгод зургаан хүн оролцоно.

Бие халаах дасгал: 10-15 минут

Бэлтгэх байдал:

Овоолго хоёр үеэс бүрдэх бөгөөд суурийн таван хүн зэрэгцэн зогсож бие биеийнхээ гарын бугуйнаас атган нумарсан байдалтайгаар тэнцэн зогсоно. Орой болж байгаа нэг хүн суурийн гол төвийн хүний мөрөн дээр зогсох байдлаар бэлтгэх байдлыг авна



Зураг 20

Үндсэн техник:

- Оролцогч зургаан хүн бүгд бэлтгэх байдалд зогсоно. Суурийн таван оролцогчийн голын гурав нь зогсоо байдалтай, хоёр захын хүн газарт хажуугаараа хэвтэнэ.
- Суурийн төв болж байгаа голын хүн эхлээд өвдгөөрөө доош хагас суун сүмо байрлалд бэлтгэх байдал авч хоёр гараа дээш өргөн овоолгын орой болох оролцогчийг дээш өргөн мөрөн дээрээ гаргахад бэлтгэнэ. Ингэхдээ биеийнхээ жинг хоёр хөл, нуруунд төвлөрүүлнэ.
- Овоолгын орой болох оролцогч суурийн төвийн хүний ард зогсон хоёр гараа дээш өргөн суурийн хүний гараас барьж баруун хөлөөрөө суурийн хүний баруун хөлийн гуян дээр гишгэн түлхэлт авч биеэ өргөн зүүн хөлөөрөө суурийн хүний зүүн мөрөн дээр нь гишгэн босож тэнцэнэ. Энэ үед суурийн хүн хоёр гараараа түүний хоёр хөлийн шилбэний шагайн хэсгийн гадна талаас дотогш чиглэлтэйгээр барьж тэнцвэрээ олоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Овоолгын оройн хүнийг тэнцвэрээ олсны дараа суурийн төвийн хүний хоёр талд зогсох хоёр хүн гараараа түүний бугуйнаас чанга бат барин хоёр хөлийг улаар нь нийлүүлэн суурийн төвийн хүний хөл рүү хөдөлгөөнгүй тулж өгнө. Биеэрээ гадагш хажуу тийш хазайн гараа захын хоёр хүнд өгнө.
- Овоолгын хамгийн захын хоёр хүн газарт хажуугаараа хэвтэх

байрлалтай байна. Нэг гараараа хажуугаараа зогсох хоёр хүний гараас бат барин хоёр хөлийг хооронд нь хавсарч нийлүүлэн хазайсан хоёр хүний хөл рүү жийж нөгөө гараа тэнийлгэнэ. Ийнхүү солонго хэлбэрийн овоолго үүснэ. (Зураг 20 харна уу?)

Овоолгыг хийхэд гардаг нийтлэг алдаа:


1. Оролцогчид анхааралгүй байх,
2. Суурийн хүн оройн хүнийг тэнцвэрээ олоход нь туслахгүй байх,
3. Ямар хэлбэрийн овоолго хийхээ урьдчилан ярьж тохироогүй байх,
4. Бие биедээ итгэхгүй байх,





Овоолгыг техникийн дагуу зөв хийх зөвлөмж

1. Оройн хүн хөлөө хөдөлгөөнгүй байлгаж тэнцвэртэй зогсох нь суурийн хүнд тэнцвэрээ хадгалан бат зогсоход нь маш их дэмжлэг болно.
2. Суурийн төвийн хүн өөрийн хүндийн жигнээ зөв хуваарилан хөдөлгөөнгүй бат зогсох нь түүнээс хоёр тийш салбарлан тэнцэх бусад хүмүүст тэнцвэртэй байх итгэл үзүүлнэ.

Хүүхдүүдээр овоолгыг хийлгэхдээ бие халаалтын үндсэн дасгал, техникүүдийг хийж гүйцэтгэж сурсны дараа хийлгэх нь зохимжтой төдийгүй сургалтад хамрагдаж буй хүүхдүүдийг бие биеэ таньж ойлгож мэдэрсэн, нэг командаар ажиллаж сурсны дараа хийхэд илүү хялбар болно.

Циркийн овоолгын энгийн төрлүүдийг хэрхэн хийхийг дараах жишээ зургуудаар харууллаа.





Зураг 21

СЭДЭВ 2.

ГИМНАСТИКИЙН ТӨРӨЛ

Гимнастик гэдэг нь дасгал хийх гэсэн Грек үгнээс гаралтай. Циркийн гимнастик нь зориулалтын хэрэгсэл, арга техник ашиглан хүний биеийн гоо сайхныг үйл хөдлөлөөр дамжуулан уран сайхны аргаар харуулахад чиглэгддэг. Энэхүү төрөл нь хэрэгсэл, арга техникээсээ хамааран 20 гаруй дэд төрөлд хуваагддаг. Энэ хэсэгт гимнастикийн өнхрөлтийн техникийг танилцуулъя.

1. Өнхрөлт

Өнхрөлт нь циркийн үсрэлтийн төрлийн анхны хэлбэр бөгөөд дасгал, техник нь оролцогчдод орон зайг мэдрэх, баримжаа олох, хурд, хүчийг хөгжүүлэх, багаар ажиллах, өөртөө итгэх итгэлийг бий болгоно.

Үндсэн техникүүд.

а) Далан дээрээ зогсох: Оролцогч нуруугаараа дээшээ харж хэвтэнэ. Хөлөө өлмийгөөр нь нийлүүлэн жийж, эгц дээш хүчлэн өргөнө. Энэ үед хоёр гараар нурууны доороос тулан тэнцвэрээ олоход дэмжлэг үзүүлнэ.

б) Гурван цэгийн зогсолт: Оролцогч доош явган сууна. Хоёр гараа урагшаа хооронд нь мөрний хэмжээнээс илүү зайтайгаар газарт тавьж алгаараа бүрэн дарна. Дараа нь урагш тонгойж толгойгоороо газар тулна. Энэ үед толгойн байрлал хоёр гараас урагшаа гурвалжин буюу гурван цэг үүсгэсэн маягтай байна. Аажмаар хоёр гар, толгой дээрээ биеийн жинг шилжүүлэн нуруугаар ялимгүй савах хөдөлгөөн хийж хоёр хөлөө өвдгөөр нь нугалан хэвлийдээ наалдуулах байрлалд авчирна. Энэ байрлалд тэнцвэрээ олсны дараа аажмаар өлмийгөө нийлүүлэн хөлөө эгц дээш өргөн жийнэ. Хүзүү, нурууны булчинг чангалснаар хоёр гар, толгой дээрээ зогсон тэнцвэрээ хадгалан удаан тогтох боломжтой болно.

Аюулгүй байдлыг хангах үүднээс бага насны оролцогчдод энэ техникийг заадаггүй.



Зураг 22


Гурван цэгийн зогсолтыг хийхэд гардаг нийтлэг алдаа

- Оролцогчид биеэ дээш өргөж чадахгүй байх
- Буцаж унах
- Тогтворгүй байх

Техникийн дагуу зөв хийх зөвлөмж


- Биеийн хүндийн жинг зөв тооцоолон гар, нурууны хэсэгт төвлөрүүлэх
- Хөлийг нугалан цээжин тус газар авчрах
- Тохойгоор тулж тэнцсэний дараа аажмаар хүндийн жинг гарын алга, толгойд шилжүүлэн тэнцэх

с) Урагшаа хойшоо өнхрөлт: Оролцогч доош явган сууж урагшаа бага зэрэг тонгойн гараа тэнийлгэн алгаараа газар тулна. Толгойгоороо газарт тулан урагш тонгойж биеэ дээш өргөн хүзүү, сэрвээгээрээ газар тавьж өнхрөхөд бэлтгэнэ. Дараа нь хөлөөрөө хүчлэн жийж биеийг ялимгүй савах хөдөлгөөнөөр урагшаа өнхрөхөд дэмжинэ. Дал мөр, хүзүү сэрвээ, нуруу газарт хүрэхэд хоёр хөлөө өвдгөөр нугална. Урагш эргэх явцдаа хоёр гараараа хөлийн шагайн гадна талаас барьж биеэ татан босно.



Зураг 23

Хойшоо өнхрөхдөө буруу харан зогсож доош явган сууна. Хойшоо нуруугаараа газар хэвтэж, хоёр хөлөө ялимгүй саван дээш бие рүүгээ татан авчирмагц толгойгоо давуулан биеийн хүндийн жинг хөлдөө шилжүүлэн хоёр гараараа газар тулан хүчлэн өнхрөх хөдөлгөөн хийнэ. Босохдоо гараараа хөлийн шагайн хэсгийн гадна талаас нь татаж босно.




Зураг 24

d) Хоёр гар дээрээ тулж эргэх: Урагшаа харж зогсоно. Хоёр гараа дээш өргөж, нэг хөлөө урагш саван хүч аван урагш газар тавина. Энэ үед их биеэрээ тонгойж хоёр гараараа урагш газарт тулан хөлөө ээлжээр дээш нь шидэж хүчээ аван (1; 2; 3; 4 гэсэн тоонд багтаан) эсрэг тал руугаа хоёр хөл дээрээ босож зогсоно.

10-17 насныхан дээрх техникээс гадна хоёр хоёроороо зөрж өнхрөх хувилбараар хийж болно. Заавар:

1. Эхний хүүхэд нуруугаараа дээшээ харж хэвтээд хоёр хөлөө өвдгөөрөө нугалан хэвлийдээ авчирна. Хоёр дахь хүүхэд газарт хэвтсэн хүүхдийн толгойн талд мөрний харалдаа зогсож тонгойн түүний хөлийн шилбэнээс барина. Газар хэвтэж буй хүүхэд мөн л зогсож буй хүүхдийн хөлийн шилбэнээс барьсан байна.
2. Зогсож буй хүүхэд доош суун нуруугаараа хойш хэвтмэгцээ нөгөө хүүхдийнхээ хөлийн шагайнаас татан хүч авах үедээ хөлөө дээш өргөж өгнө.

3. Газарт хэвтсэн хүүхэд зогсоо хүүхдийг доош суун хойшоо өнхрөх үед нь хөлийн шагайнаас нь татан хүчээ авч биеэ газраас хөндийрүүлэн хөлөө газарт тавьж өгнө.
4. Ийнхүү хоёр хүүхэд бие биен дээгүүрээ зөрж өнхөрнө.



Зураг 25

Анхаарах зүйл: Зарим хүүхэд хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, бие махбодын хувьд зовууртай байдаг тул дасгал сургуулилтын явцад оролцогчдыг сайтар ажиглах шаардлагатай. Дасгалжуулагч багш ийм зовуур шаналгаатай байгаа хүүхдийг илрүүлэн нийгмийн ажилтанд мэдээлэн анхны ярилцлага хийж асуудлыг тодруулах бөгөөд кейс үйлчилгээ үзүүлэхэд ажлаа чиглүүлнэ. Түүнчлэн хүүхдүүд замаасаа гарах, бие биеэ гэмтээх эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлнэ.

СЭДЭВ 3.

ЖОНГЛЁРЫН ТӨРӨЛ

Энэ нь овсгоотой, хөдөлгөөнтэй, бусдыг баясгагч гэсэн утгатай Франц үг. Хурдан шалмаг хөдөлгөөн, анхаарал, хатуужил, уйгагүй хөдөлмөр шаардсан циркийн үндсэн төрөл. Жонглёрдох гэдэг нь тодорхой хэмнэлд циркийн тусгай хэрэгслүүдийг шидэж тоглох үйлдэл юм. Жонглёрыг алчуур, бөмбөг, муна буюу булавь, цагираг буюу кольц, бүрх малгай гэх мэтчилэн гарт барьж болох тэнцүү жинтэй юугаар ч хийж болно. Ганцаарчилсан болон хамтлагийн, морьтой, дээстэй гэх мэт зургаан дэд төрөлд хуваагддаг.

БӨМБӨГӨӨР ЖОНГЛЁРДОХ

“Нийгэмшүүлэх цирк” сургалтад энэ техникийг өргөнөөр заадаг. Жонглёрын техникийг зөв эзэмшихийн тулд хүүхдүүдэд эхлээд нэг бөмбөгөөр жонглёрдох техникийг зөв заах хэрэгтэй.

Ашиглах техник хэрэгсэл: Агаарын жонглёрын стандарт нэг ширхэг бөмбөг, эсвэл тэнцүү жинтэй хөнгөн бөмбөг, эд зүйл

Бие халаах дасгал: 10-15 минут

Бэлтгэх байдал: Оролцогч хөлдөө мөрний хэмжээтэй зай авч, хоёр гараа тохойгоор нугалан цэх зогсоно.

Үндсэн техник:

Оролцогч зөвхөн нэг гартаа нэг бөмбөг барина. Бөмбөг бариагүй гараа урагш мөрний чигтээ шулуун байрлалд авчран алгаа дээш харуулан тэнийлгэнэ. Бөмбөг барьсан гараа нөгөө гарын доогуур оруулан бугуйн хөдөлгөөний тусламжтайгаар бөмбөгөө тэнийлгэсэн гарын алган дээр буухуйцаар толгойноосоо ялимгүй өндөрт байхаар тооцоолон эгц дээш алгуур шиднэ. Бөмбөг доош гарын түвшинд бууж ирмэгц шулуун тэнийлгэсэн гараар барьж авна. Энэ дасгалыг хоёр гараараа ээлжлэн хийнэ.

Оролцогчдын сонирхлыг өдөөх, идэвхжүүлэх, гарыг зүгшрүүлэх үүднээс дараах хувилбаруудыг санал болгон хийлгэх нь тохиромжтой.

- a) Бөмбөгөө дээш шидээд доош буух хооронд алгаа олон удаа ташин бөмбөгөө барьж авна.
- b) Нэг хөлөө дээш өргөн тахимаа нугалж тахим доогуур гараа оруулан бөмбөгөө дээш шидэн барьж авна. Хоёр хөлөөрөө ээлжлэн хийнэ.
- c) Бөмбөгтэй гараа нурууны араар оруулан бөмбөгөө мөрөн дээгүүрээ давуулан дээш шидэж нөгөө гараараа биеийн урд талаас бөмбөгөө барьж авна. Үүнийг хоёр тал руугаа ээлжлэн хийнэ.
- d) Бөмбөгөө дээш нь шидээд биеэрээ доороо бүтэн эргэж (360°) бөмбөгөө барьж авна.
- e) Баруун зүүн гарын алган дээр нэг нэг бөмбөг тавиад дээш нь ижил түвшинд нэг, хоёр гэсэн дарааллаар солбиж шидээд буцааж алган дээрээ барих байдлаар жонглёрдоно.

Хоёр бөмбөгөөр жонглёрдох техник


Ашиглагдах техник хэрэгсэл: Жонглёрын стандарт хоёр ширхэг бөмбөг, эсвэл тэнцүү жинтэй хөнгөн бөмбөг, эд зүйл

Бие халаах дасгал: 10-15 минут

Бэлтгэх байдал: Оролцогч хөлдөө мөрний хэмжээтэй зай авч цэх зогсоно. Хоёр гартаа нэг нэг бөмбөг атган гар урагшаа тохойгоор 45 хэм өргөсөн байдалтай байна.

Үндсэн техник:


- a) Баруун гарт байгаа бөмбөгийг зүүн мөр тийш дээш нь, зүүн гарт буй бөмбөгийг баруун мөр тийш дээш нь шидээд бөмбөг бууж ирэхэд ээлжлэн барьж авна. Аль нэг гарт байгаа бөмбөгийг эхлэн шидэж дараагаар нь үлдсэн гарт байгаа бөмбөгийг шидэх зарчмаар цувруулан шиднэ.
- b) Баруун, зүүн гарт байгаа бөмбөгөө тус тусад нь дээш нь гадагш нь тойрог маягаар шидэн бөмбөг бууж ирэхэд нь баруун зүүн гараар тус тусад нь авч дахин шидэх зарчмаар тасралтгүй үргэлжлүүлнэ.
- c) Баруун гарт буй бөмбөгөө зүүн мөрний тушаа дээш нь шидээд, зүүн гарын бөмбөгөө баруун гартаа шулуун шугаман байдлаар шилжүүлэн шиднэ. Зүүн мөрний тушаа дээрээс ирэх бөмбөгөө зүүн гараараа тосон авч дахин үргэлжлүүлж хурдтайгаар тойрог үүсгэх маягаар жонглёрдоно.
- d) Нэг гартаа хоёр бөмбөг барина. Бөмбөгөө нэг нэгээр гадагш нь тойрог маягаар ээлжлэн шидэж шидсэн гараараа барьж аван жонглёрдоно. Энэ үед нэг гараа оролцуулахгүй чөлөөтэй байлгана.
- e) Хосоороо буюу багаар жонглёрдох. Хоёр оролцогч өөд өөдөөсөө харан хөлдөө мөрний хэмжээтэй зай аван цэх зогсоно. Оролцогчид тус бүр хоёр бөмбөгтэй байна. Оролцогчид зүүн гар дахь бөмбөгөө эсрэг зогсож байгаа оролцогчийнхоо баруун гар руу, баруун гар дахь бөмбөгөө зүүн гар руу нь бөмбөгөө доороос дээг хөөргөж шидэж харилцана.



Зураг 26. Гурван бөмбөг барих зөв техник

Техник дараалал:

- Бөмбөгийг дээш шидэхдээ тохойгоороо бага зэрэг савлуулан бугуйн хөдөлгөөний тусламжтайгаар дээш хөөргөж шидэж өгнө.
- Бөмбөгний өндөр толгойноос ялимгүй дээр байхаар тооцоолон шидэлтийг хийнэ.
- Хоёр ба түүнээс олон бөмбөгөөр жонглёрдохдоо эхний бөмбөгийг шидсэний дараа хоёр дахь бөмбөгийг шидэх байдлаар дараалуулна. Зэрэг шидэж болохгүй.




Зураг 27. Бөмбөгөөр жонглёр хийх техник дараалал

АЛЧУУРААР ЖОНГЛЁРДОХ

Алчуураар жонглёрдох техник дараалал нь бөмбөгөөр жонглёрдох техниктэй ижил байна.

Гол нь алчуурыг агаараас доош бууж ирэхийг нь хүлээх шаардлагатай. Яаран агаараас шүүрч авч болохгүй. Алчуур нь бөмбөг болон бусад хэрэгслийг бодвол илүү хөнгөн учир оролцогчоос алчуурыг дээш нь хөөргөж шидэх үед бугуйн хүчтэй хөдөлгөөнийг шаарддаг.



Зураг 28. Алчуураар жонглёрдох барилт болон шидэлтийн техник дараалал


Жонглёрдоход анхаарах зүйл:

- Бөмбөг, булавь, цагиргаар жонглёрдох үндсэн техник нь адил,
- Булавын иш нь урт учир техникийг буруу хийвэл толгой, нүүр рүү цохих,
- Кольц буюу цагираг хатуу эдээр хийгдсэн учраас техникээ буруу хийвэл гар, нүүр, толгойгоо цохиж гэмтээхээс болгоомжлох,
- Хосоор болон багаар жонглёрдохдоо командыг сайн сонсож зэрэг ажиллах,
- Жонглёр хийх орон зай, талбайг зөв тооцоолох,
- Бага насны хүүхдүүдийн гарын жижиг нарийн булчингууд төдийлөн сайн хөгжөөгүй байдаг тул булавь, кольцоор жонглёр хийлгэх нь тохиромжгүй.

- Жонглёрын хэрэгслээс хамааран хүндийн жин нь ялгаатай тул дээрээс доош буух хугацаа нь харилцан адилгүй байдгийг санаарай. Жишээ нь алчуураар жонглёрдох тохиолдолд хөнгөн материалаар хийгдсэн тул дээрээс буух хурд, хугацаа нь удаан байна. Харин бөмбөг болон булавь зэрэг нь алчуураас хүнд жинтэй тул дээрээс буух хурд болон хугацаа нь илүү хурдан байдаг.

ДАМРААР ЖОНГЛЁРДОХ

Дамар нь утсаар холбогдсон хоёр ширхэг иш, нэг ширхэг дамраас бүрдэнэ. Жонглёрын энэ төрөл нь хүнээс хурд, анхаарал, овсгоо самбаа, сэргэлэн цовоо байдал зэргийг шаарддаг.



Зураг 29. Дамраар жонглёрдох үндсэн барилт

а) Дамраар жонглёрдох үндсэн техник

Бие халаах дасгал: 10-15 минут


Бэлтгэх байдал: Хөлдөө мөрний хэмжээнээс бага зай авч анхаарлаа төвлөрүүлэн зогсоно.

Үндсэн техник:

Хоёр гараараа дамрын ишний арын хэсгээс барьж биеэрээ урагшаа бага зэрэг тонгойно. Дамрыг утасныхаа дээр голын нарийн хэсэгт байхаар газарт баруун

хөлийн харалдаа тавина. Баруун гар дахь ишээрээ дамрын их бие рүү зүүн тийш зөөлөн цохиж өнхрүүлж өгнө. Дамар зүүн хөлийн харалдаа ирмэгц хоёр гарын ишээ дээш нь зэрэг татаж, хоёр гарын бугуйгаар дээш доош бага зэрэг хөдөлгөн утсыг эрчлэн дамраа эргэлдэх хөдөлгөөнд оруулан дээш нь өргөнө. Баруун гар дахь ишийг зөөлөн зөөлнөөр дээш доош татах маягаар дамрыг эрчтэйгээр эргэлдэх хөдөлгөөнийг дэмжинэ. Ингэхдээ зүүн гараа хөдөлгөхгүй нэг байрлалд байлгана. Хоёр гар тохойгоороо хагас нугалсан, сугаа хавчсан маягтай, бие болон гарын булчинг чангалахгүй. Дамар хэдий чинээ эрчтэй байна, дараагийн үзүүлбэрийг үргэлжлүүлэн хийхэд хялбар болно. Дамрын хазайлтыг засаж тэнцвэрийг хадгалахын тулд баруун гарт барьсан ишээ урагш, хойш татан хазайлтыг тэгшилнэ. Дамрыг сайн эрчлүүлж сурсны дараа дараах хэлбэрүүдээр хийж болно. Үүнд:

b) Дамраа утсан дээрээ шидээд тосож авах техник



Зураг 30. Дамрыг утсан дээр дээш үсэргэн хөөргөх техник

- Дамрыг эрчтэй хөдөлгөөнд оруулна.
- Дамар тогтвортойгоор эрчлэгдсэний дараа хоёр гарт байгаа ишийг гадагш тэлэн утсыг хурдан хугацаанд тэнийлгэнэ.
- Тэнийсэн утсан дээр эрчилсэн хөдөлгөөнд байгаа дамрыг дээш шидэхийн тулд хоёр гар дахь ишийг бугуйн хөдөлгөөнөөр дэмжин дээш нэгэн зэрэг хөдөлгөнө. Энэ үед дамар дээш үсэрнэ.
- Дээш үсэрсэн дамрыг доош бууж ирэхэд үед ишийг дэлгэн утсыг тэнийлгэж утсан дээрээ хүлээж авна.
- Дээш эрчтэй эргэж буй дамрыг шулуун утсан дээр хэдэн ч удаа хүлээн авч хөөргөж болно.
- Дамар утсан дээр бууж ирмэгц ишийг аажмаар хөдөлгөн дамрыг эрчилнэ.

Дамраар жонглёрдох үед гардаг нийтлэг алдаа


- Оролцогчид ишийг хэтэрхий хурдан эрчлэн татах,
- Дамар тогтворгүй байх,
- Дамрыг дээш шидэхдээ хурд болон өндрийг зөв тооцоолох,

Дамраар зөв жонглёрдох зөвлөмж

- Тайван, жигд хөдөлгөөнөөр дамрыг эрчлэн хөдөлгөөнийг тогтворжуулах,
- Дамрыг дээш хөөргөж сурсны дараа өндрийг бага багаар нэмэгдүүлэх,

с) Хөлөө утсан дээгүүр давуулан гаргаж дамраа утсан дээрээ өнхрүүлэх техник

- Дамрыг эрчтэй хөдөлгөөнд оруулна. Энэ үед гарыг тохойгоор нугалахгүй доош шулуун байрлалд байна.
- Дамар эрчтэйгээр тогтвортой хөдөлгөөнд орсны дараа хоёр гар дахь ишийг хоёр тийш дэлгэн утсыг үзүүлбэрт бэлтгэнэ.
- Утас чөлөөтэй дэлгэгдэн дамар зүүнээс баруун, баруунаас зүүн тийш өнхрөх үед аль сул байгаа орон зайд нь нэг хөлөө утсан дээгүүр урагш давуулан тавина.
- Дамар буцан эргэлдэж давуулсан талын хөлийн тушаа ирэх үед давуулсан хөлөөрөө утсыг доош дарж дамар хөндийрөн эргэлдэх боломжийг бүрдүүлнэ. Үүний дараа дамрыг утсан дээр тосож авна.
- Дамар утсан дээр буумагц ишийг доошлуулан утаснаас хөлийг хөндийрүүлнэ. Дамар утсан дээгүүр эрчлэгдэн хөлөн доогуур эсрэг зүгт хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ.



Зураг 31. Дамрыг хөлөн дээгүүрээ эргэлдүүлэх хувилбар

d) Хосоороо зогсон хоорондоо дамраар харилцах техник

- Хоёр оролцогч зэрэгцэн зогсож баг болно.
- Нэг оролцогч эхлээд дамрыг эрчлэн хөдөлгөөнд оруулна.
- Дамар сайтар эрчлэгдэн тогтвортой хөдөлгөөнд орсны дараа оролцогчид гар дахь ишийг нэг том тойрог маягтайгаар үндсэн барилтад аажмаар шилжүүлнэ.
- Дамар утасны дээд хэсэгт ирэхэд нөгөө оролцогчийн утас руу шидэж өгнө.



Зураг 32. Дамраар харилцах

- Нөгөө оролцогч өөрийн утсан дээр ирсэн дамрын хөдөлгөөнийг сааруулахгүйгээр утсан дээрээ дээрээс доош чиглэлээр эргэлдүүлэн нөгөө оролцогчийнхоо утас руу аажим шилжүүлнэ. Ингэж дамар дээрээс доош тойрог маягаар хоёр оролцогчийн утсан дээр хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ.

Дамраар жонглёрдох үед гардаг алдаа

- Оролцогчид хоорондынхоо зайг зөв тооцоолохгүй байх,
- Хурдаа жигдлээгүйгээс дамрын эрч сулрах,
- Дамрыг яаран эрт шидэх,

Дамраар жонглёрдох зөвлөмж

- Оролцогчид утасны урт богинод тааруулан хоорондын зайгаа зөв тооцоолон зогсох,
- Оролцогчдын нэг нь командлан дамрыг шидэх дохиог бие биедээ өгч багаар хамтран ажиллах шаардлагатай.

Дамраар наадах хувилбарууд:

- а) Мөрөн дээгүүрээ шидэж буцааж авах
- б) Дамраа дээш нь шидээд буух хооронд нь утсан дээгүүрээ үсэрч гарах (дээсэнд үсрэх хөдөлгөөнтэй адил)
- в) Дамраа өндөр шидээд буух хооронд урагшаа эргэх
- д) Утсан дээрээ хоёр дамраар ээлжлэн жонглёрдох үйлдлүүдийг хийж болно.

Анхаарах зүйл: 6-9 насны хүүхдэд ишний утсыг богиносгож өгнө.

- Орон зайг баримжаалахгүй хэт өндөрт шидсэнээс дамар таазанд тулаад эргэн буухдаа толгой нүүр рүү цохих эрсдэлтэй.
- Дамрын голын боолт суларч дамар салж унах,
- Багаар ажиллахдаа орон зай, чиг баримжаагаа анхааран аюулгүй байдлыг хангах,

САВААГААР ЖОНГЛЁРДОХ

Саваагаар жонглёрдох нь оролцогч хос иш бүхий саваа мод ашиглан агаарт олон төрлийн үйлдэл үзүүлэхийг хэлнэ. Саваагаар жонглёрдох нь мэдрэмжийг хөгжүүлэх, хэмнэлийг мэдрэх, бүтээлч байдлыг хөгжүүлэхэд тустай.

Хэрэгсэл:

Энэхүү үзүүлбэрт голчлон 40-50 см урттай хоёр иш, 60-80 см урттай нэг саваа модыг ашиглан жонглёрддог. Саваа болон иш нь 2 см голчтой шулуун байх бөгөөд хоёр талын үзүүр хэсгүүдийг 2 см өргөнтэй резин, тууз зэрэг материалаар давхарлан орооно. Мөн дасгал, үзүүлбэрийн явцад савааг унагах, гулгуулахгүй байх үүднээс иш болон савааны биеийг зөөлөн резин, тууз, зэрэг материалаар битүү хучиж наана.


Савааны хоёр үзүүрт 4-5 см-ийн урттай резин эсвэл туузыг цацаглан “цэцэг” хэлбэрээр бэхэлнэ. Энэ нь хөдөлгөөнийг улам гоёмсог болгох, эргэлтийг дэмжих боломжтой болгодог.

Бие халаах дасгал: 10-15 минут

Бэлтгэх байдал: Баруун, зүүн гартаа савааны иш болон савааг барин хөлдөө мөрний хэмжээтэй зай авч зогсоно.

Үндсэн техник:

- Хоёр гартаа нэг нэг савааны ишийг бариад биеэрээ урагш ялимгүй тонгойно. Гарын барилт нь ишний үзүүр хэсэг буюу нийт ишний уртын 4/1-д байхаар тооцоолон хангалттай хэмжээгээр атгана.
- Хоёр хөлийнхөө дунд савааг газарт босоогоор нь нэг ишний үзүүрт налуулан тавина.
- Савааг хөдөлгөөнд оруулахдаа зүүнээс баруун тийш баруунаас зүүн тийш гарын бугуйны хөдөлгөөнөөр ишийг дохин савааг ээлжлэн цохих маягаар хөдөлгөөнийг удирдана.
- Аажмаар ишний нааш цааш цохих хөдөлгөөнийг нэмэгдүүлэн савааны савлах хурдыг нэмнэ.



Зураг 33

- Савааг савлуулахдаа хоёр ишээр савааны дээд хэсэг рүү ээлжлэн цохино.
- Савааны хөдөлгөөн тодорхой хурдтай болсоны дараагаар гарыг аажмаар дээш өргөн цэх зогсоно. Энэ үед саваа агаарт хөдөлгөөнөө үргэлжлүүлсээр байх болно.

Саваагаар жонглёрдох хувилбар

- a) Хоёр гарт барьсан савааны ишин дээр саваа модыг хөндлөн байрлуулж тавиад дээш нь шидэж, буцаагаад ишэн дээрээ тосож авна. Хоёр хоёроороо хоорондоо харилцан дээш нь хөөргөж савааг агаарт солилцон шидэж болно.
- b) Ишин дээр хөндлөн тогтоосон саваагаа унагахгүйгээр биеэ тойруулан эргэлдэх хөдөлгөөн хийнэ.
- c) Хоёр гартаа ишээ бариад гараа урагш өргөн түүн дээр саваа модыг хөндлөн тавина. Аажмаар хоёр гараа зэрэг дээшлүүлэн дээш нь өргөх, буцааж зэрэг доош буулгахад саваа ишин дээгүүр өнхөрч эргэлт үүсгэнэ.
- d) Саваа модоо хөлөн доогуураа гаргах, нурууны араар тойруулах, багаараа эгнэж зогсоод командаар зэрэг дамжуулах гэх мэт үйлдлүүдийг зохиомжлон жонглёрдох боломжтой.

Саваагаар жонглёрдоход гардаг нийтлэг алдаа

- Савааг дээш нь агаарт татан гаргаж чадахгүй байх,
- Ишийг хооронд нь хэт ойрхон барих,

Саваагаар зөв жонглёрдох зөвлөмж

- Ишийг хооронд нь тодорхой зайд барин орон зайгаа мэдрэх,
- Хэмнэлтэй жигд хурдаар савааг цохиж савлуулах,
- Анхаарлаа төвлөрүүлэн тайван байх

СЭДЭВ 4.

ТЭНЦВЭРИЙН ТӨРӨЛ

Тэнцвэр буюу Эквилибр гэдэг нь тэнцвэрт байдал гэсэн утгатай латин үгнээс гаралтай. Энэ нь тогтворгүй гадаргуу дээр төрөл бүрийн хэрэгслээр тоглолт хийж тэнцвэрээ хадгалах чадварыг хэлнэ. Циркийн энэ төрөл нь хүнээс маш их тэвчээр, авхаалж самбаа, тэсвэр хатуужил, хөдөлмөрч байдлыг шаарддаг.

Тэнцвэр нь дотроо олсон дээр явах, дан дугуй, модон хөл, катушка зэрэг дээр тэнцэх, нугаралт, хөлөөр шидэгч зэрэг дэд төрлүүдтэй.

а) Дан дугуй буюу моносикл: Энэ нь унадаг дугуйны нэг төрөл бөгөөд гол ялгарах зүйл нь нэг дугуйтай, урдаа жолоогүй. Дан дугуй дээр тэнцэхийн тулд эмээл дээрээ тэгш сууж, дөрөөгөө жийнэ. Эхэлж сурахад их хэцүү унаж хөл гараа бэртээх эрсдэл ихтэй тул дан дугуй дээр эхлэн суралцаж буй хүүхдийн өндрийн хэмжээтэй адил ямар нэгэн хөдөлгөөнгүй зүйлээс барьж дэмжлэг авна.



Зураг 34

Дан дугуй дээр тэнцэх техник:

- Дугуйн дээр цэх сууж, биеийнхээ хүндийн жинг аарцаг, нуруу орчимд төвлөрүүлнэ. Хоёр гараа хажуу тийш дэлгэн мөрний тушаа авчирна.
- Тэнцвэрээ олсны дараа хоёр хөлөөрөө дөрөөгөө нааш цааш аажмаар жийж хөдөлгөөнд оруулна.
- Хэт хурдан, хэт аажуу биш тогтмол хурдтайгаар хоёр хөлөөрөө дөрөөгөө ойр ойрхон хойш урагш жийж (качь хийж) тэнцвэрээ олно.
- Олон дахин уйгагүй, давтамжтайгаар хийж сурсны дараа бусдын дэмжлэггүйгээр явж сурсан үедээ тойргоор явах, туг, дарцаг сүлжих, дугуйтайгаа үсрэх болон дугуйн дээрээ жонглёрдож болно. Анх сурч байгаа үедээ унаж бэртэх магадлал өндөр байдаг тул маш болгоомжтой байх хэрэгтэй.

b) Модон хөл: Өндөр, нарийн, суурь багатай зүйл дээр тэнцвэрээ олох, агаарт өөрийгөө мэдрэх, тэнцэх чадварыг илэрхийлнэ. Модон хөл дээр явахын онцлог нь түүнийг хөндлөнгөөс харахад маш хэцүү мэт санагдах боловч сурахад хялбар техник юм. Зориулалтын тоногдсон модон “хөлөнд” хөлөө бэхлээд хүний дэмжлэгтэйгээр босно. Хөлөө өвдгөөрөө нугалж доороо явж буй мэт хөдөлгөөн хийж тэнцвэрээ олно. Доороо байнга нааш цааш хөдөлснөөр тэнцвэрээ хадгалан удаан зогсож чадна. Ийм хөдөлгөөн хийж хөдлөхгүйгээр удаан зогсох нь тэнцвэрээ алдаж унах аюултай.



Зураг 35

Анхаарах зүйл: Бага насны хүүхдийг хэт өндөр модон хөл дээр гаргахгүй байх. Түүнчлэн анх тэнцвэрээ олж байгаа тохиолдолд аюулгүй байдлыг ханган хамгаалж, дэмжин туслах шаардлагатай. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд модон хөл дээр тэнцэж буй хүүхдүүдийн хөлийн бэхэлгээг бэхэлсэн байдлыг нягт нямбай шалгана. Модон хөл дээр тэнцэж байгаа оролцогчийг бусад нь айлгах, цочоох, модон хөлөөс нь барих, түлхэх зэрэг үйлдлүүдийг хийж болохгүй. Хүүхдэд хэт хүнд жинтэй “модон хөл”-ийг хэрэглүүлэхээс зайлсхийнэ.

с) Катушка буюу хэрчим: 25-30 орчим сантиметрийн урттай, 10-15 сантиметрийн голч бүхий хатуу цилиндр биетийг хажуугаар хэвтээ байрлалд оруулан түүн дээр хавтгай мод тавиад дээр тэнцвэрээ олж зогсоно. Тэнцэж байгаа үедээ огцом биш зөөлөн хөдөлгөөн хийж өгнө. Биеэ бэлтгэх байдалд авч бүсэлхийнээс доош суллаад хоёр өвдгөөрөө хагас нугалж зогсон тэнцвэрээ олно. Гүйцэд сурсны дараа жонглёр, цагираг, тэнцвэр алийг нь ч хийж болно. Маш их анхаарал, хяналт, тэвчээрийг шаарддаг.



Зураг 36

Анхаарах зүйл: Цилиндрийг тавьсан шал нь халтиргаа, гулгаатай бол доор нь заавал зөөлөвч дэвсгэр тавина. Аюулгүй байдлыг хангах үүднээс багшийн зааварчилгаа хяналт доор хийнэ. Хэзээ ч огцом хөдөлгөөн хийж болохгүй, хөдөлгөөнийг өвдгөөрөө хорьж зөөлөж өгнө. Огцом хөдөлгөөн хийснээр цилиндр тавцан хоёр хөлбөрч хажуу бөөрөөр унан хөл, шилбээ гэмтээх магадлалтай.

СЭДЭВ 5.

АЛИАЛАЛ

Циркийн салшгүй нэг хэсэг нь алиаллын төрөл юм. “Нийгэмшүүлэх цирк”-т хошигнолоор дамжуулан хүүхдүүдтэй харилцахдаа бэрхшээлийг даван туулах, бүлэгт аюулгүй тайван байх мэдрэмжийг хөгжүүлэх, шинэ ур чадварыг эзэмшүүлэх, итгэл үнэмшил бий болгох, тэдний сэтгэл санааг дэмжихдээ өргөнөөр хэрэглэдэг.

Сургалтад оролцогчдын сэтгэл санаа болон бие махбодын хувьд бэрхшээлтэй байдлаа даван туулахад тоглох, зугаацах, хөгжилдөн инээлдэхээс илүү чухал зүйл юу байж болох вэ? Инээдэм нь хувь хүнд бэрхшээлийг даван туулах боломжийг олгодог гайхамшигтай хэрэгсэл бөгөөд үзэл бодол, өөртөө хандах хандлагад эергээр нөлөөлж, мэдрэмж сэтгэл хөдлөлөөр дамжуулан зан үйлийн эерэг өөрчлөлтийг бий болгодог.

Хүүхдийн хошин шогийн мэдрэмжийг дэмжихийн тулд юу хийж болох вэ?

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд хүүхдийн хошин шогийн мэдрэмжийг хөгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна уу:

- а) Ямар нэгэн нэмэлт хэрэгсэл хэрэглэх.** Жишээ нь сургалтын явцад энгийн уруулын будгаар хамрын үзүүрийг будчихаад сургалтаа эхэлбэл хүүхдүүд хэрхэн хүлээн авах бол? Мөн алиалагчийн хиймэл үсийг өмсөөд дуу хоолойгоо нарийн, бүдүүн, инээдэмтэй гэх мэт олон өнгөөр өөрчлөн харилцвал тэд яах бол?
- б) Нүдний хөдөлгөөн, нүүрний хувирлыг ашиглах.** Заримдаа зөвхөн царай, төрхөө хөгжилтэйгээр хувирган харилцахад хүртэл баясан инээлддэг шүү дээ.
 - Толгой, гар, хөлийн хөдөлгөөн, биеийн хэлэмжээрээ ч хөгжилтэй дүр үүсгэн харилцаж болох юм.
 - Хөгжилтэй түүх, инээдтэй зүйлүүдийг хоорондоо ярилцан дасгал ажиллах.

с) Чангаар инээлдэх, зарим нэг жижиг асуудалд хөнгөн байдлаар хандах. Жишээ нь хүн унах, аяга хагарах гэх мэт дуучимээ, хөдөлгөөнийг хөнгөнөөр шоглон дуурайх байдлаар бусдыг баясган асуудлыг хөнгөн өнгөрүүлэх.

- Нийгэмшүүлэх дасгал тоглоом тоглонгоо гэнэн цагаанаар зугаацан хөгжиж инээлдэх боломжийг ч тэдэнд олго.
- Хөгжилтэй ном зохиол, түүх өгүүллэг, болсон явдал зэргийг харилцан ярилцаж байх. Зарим тохиолдолд инээдмийн киног хамтдаа үзсэн ч болох юм.
- Оролцогчдыг бүлэгт хуваан алиаллын төрлөөр жижиг хэмжээний үзүүлбэр бэлтгэх дасгал даалгавар хийлгэх гэх мэтээр тэдний мэдрэмжийг хөгжүүлэх боломжтой.

Хошигнолын хил хязгаарыг хэрхэн тавих вэ? Хор хөнөөлтэй зохисгүй хошигнолоос хэрхэн зайлсхийх вэ?

- Хэн нэг нь зохисгүй хошигнол ярьсан тохиолдолд түүнийг хөгжөөн дэвэргэж инээх хэрэггүй. Тэдэнд тухайн хошигнол яагаад инээдтэй биш байгааг тайлбарлан ярилцах нь зүйтэй.
- Зарим тохиолдолд хүүхдүүд циркийн дасгал техникт суралцах явцдаа алдах, эв дүй муутай, эвсэлгүй хөдөлгөөн хийн бүтэлгүйтэх тохиолдолд бусад нь шоолон тохуурхах, басамжлах явдал гаргадаг. Шоолон инээлдэх, тохуурхах байдлаас болоод хүүхдүүд ичиж зовон дахин сургалтад оролцохоос дургүйцэх, цааргалж болох юм. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд энэ тохиолдолд хүүхдүүдийг дэмжих, зоригжуулан сэтгэлийн урам дэм өгч тухайн хүүхдийн сэтгэлзүйн болон хувийн онцлог байдалд нь тохируулан мэдрэмжтэй хандаарай.

Сургалтад оролцож буй хүүхдүүд ямар тохиолдолд юу болоход инээж байгааг нь сайтар ажиглаарай.

СЭДЭВ 6.

ЭНГИЙН МАТЕРИАЛ АШИГЛАН ЦИРКИЙН ХЭРЭГСЭЛ ХИЙХ АРГАЧЛАЛ

1. Diabolo буюу Дамар.

Циркийн жонглёрын төрөлд өргөн ашигладаг уг хэрэгсэл нь ойролцоогоор 3000 орчим жилийн өмнө үүссэн бөгөөд XII зууны үед Хятадад өргөн хэрэглэж байсан “Ёо Ёо” тоглоом нь өөрчлөгдөн хөгжсөөр Diabolo буюу Дамар гэж өргөнөөр нэрлэгдэх болсон. Дамраар ганцаарчилсан үзүүлбэр хийхээс гадна хоёр гурваараа болон түүнээс олуулаа багаар жонглёрдоход тохиромжтой. Хүнээс хурд, уян хатан байдал, авхаалж самбаа, анхаарал зэргийг шаарддаг.



Дамар нь ихэвчлэн том, жижиг, дундаж гэсэн хэмжээтэй байна. Түүнчлэн 100 см – 120 см орчим урттай утсаар холбогдсон хоёр иш, нэг нь 7,5 орчим см өндөртэй аяга хэлбэрийн хатуувтар эдээр хийгдсэн хүнхэр (жишээлбэл аяга хэлбэрийн) хэлбэртэй салангид хоёр хэсгүүдээс бүтнэ. Гарын авлагаар дамжуулан энгийн хуванцар аяга, саваа мод ашиглан жонглёрын дамар хийх аргачлалыг танилцуулж байна.

Ашиглах материал:

1. Дундаж хэмжээтэй хэт нимгэн биш, хэт зузаан биш хуванцар аяга хоёр ширхэг
2. Аягануудыг хооронд нь холбох боолт
3. 1 сантиметрийн диаметр 30 орчим сантиметрийн урттай 2 ширхэг саваа
4. 1.2 метрийн урттай хоорондоо эрчлэгдэж зангирахгүй материал бүхий утас

Хийх аргачлал:

1. Дамар хийхээр сонгож авсан хоёр хуванцар аяганы ёроолын төв

хэсгийг олон голч цэгийг тэмдэглэн хооронд нь холбон боох боолтын диаметрийн хэмжээгээр нэг цоолон нүхэлж бэлтгэнэ.

2. Ийнхүү бэлтгэсэн хоёр аяганы ёроолуудыг өөд өөдөөс нь харуулан нийлүүлж холбоно. Хоёр аягыг нийлүүлэн боосон боолт дундаа 1-2 миллиметрийн хэмжээтэй зайтай байхаар тооцоолоорой. Аягануудыг холбон боох боолтыг уртдуулахгүйгээр тааруулах нь чухал. Учир нь аягануудын жин тэнцүү байх хэрэгтэй.
3. Дамрын ишийг хийхэд 30-35 см урттай, 1 см диаметр бүхий хоёр ширхэг шулуун саваа мод ашиглана. Дээрх хэмжээгээр бэлтгэсэн саваануудыг нарийн ширхэгтэй зүлгүүрээр гадаргууг бөөрөнхий, гөлгөр болтол нь өнгөлөн зүлгэж өө сэвийг арилгана.
4. Хоёр ишний үзүүрээс хойш 0,5-1 см зай авч ишийг тойруулан зүсэж бага зэргийн ховил гаргана.
5. Дараа нь хоёр ишийг модны өнгөгүй лакан будгаар жигд, нимгэн будаж хатаана.
6. Ишийг бэлтгэсний дараа 1,2 метрийн хэмжээтэй урьдчилан бэлтгэсэн утсааришний үзүүрт гаргасан ховилдамархантайлагдаж мултрахгүйгээр уяж бэхэлнэ.

Анхаарах зүйл:

1. Дамар хийх хуванцар аяганууд жигд хэмжээтэй, адил жинтэй байна.
2. Ишийг холбох утас нь хоорондоо орооцолдож, эрчлэгдээд байхааргүй бүтэц, шинж чанартай байхад анхаараарай. Давхарлан сүлжсэн нэхээс бүхий нарийн утас нь хоорондоо эрчлэгдэж орооцолддоггүй.
3. Сургалтад оролцогчидтой хамтран техник хэрэгслийг бэлтгэж байгаа тохиолдолд цахилгаан техник хэрэгсэл болон хурц ир бүхий багажтай ажиллахдаа гэмтэж бэртэхээс болгоомжлон аюулгүй ажиллаарай.

2. Жонглёрын бөмбөг хийх аргачлал:

Жонглёрдох нь хүний бие бялдар, оюун ухааныг хөгжүүлж, хөдөлгөөнийг зохицуулах, хянах, анхаарал төвлөрөх, асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг төдийгүй хөгжилтэй, зугаатай байдлыг бий болгодог. Хүмүүс 4000 орчим жилийн өмнөөс жонглёр хийж байсан тухай баримт манай эриний өмнөх 2500 оны үеийн Эртний Египетийн Бенни Хассан булшнаас олдсон байна.



Жонглёр хийж байгааг харахад хялбар мэт боловч хүнээс уйгагүй оролдлого, тууштай байдал, анхаарал төвлөрөл, тэвчээрийг шаарддаг циркийн төрөл юм. Гарын доорх материал ашиглан юугаар ч жонглёрын бөмбөг хийх боломжтой.

Даавуун материал ашиглан жонглёрын бөмбөг хийх аргачлалыг танилцуулъя.

Ашиглах материал:

Нэг ширхэг жонглёрын бөмбөг хийхэд орох материал:

1. Нягт нэхээс бүхий ус чийг нэвтрэхгүй 40*60 см хэмжээтэй сунадаггүй даавуу
2. 120 орчим грамм том жижиг будаа, үр тариа эсвэл пластик үрлэн бөмбөлгүүд
3. Зүү, утас
4. Шугам
5. Хайч
6. Картон цаас

Хийх аргачлал:

Даавуугаар жонглёрын бөмбөг хийхэд маш нягт нэхээс бүхий даавуун материал ашиглах нь илүү тохиромжтой байдаг. Эхлээд картон цаасан дээр эсгүүр гаргана. Ингэхдээ 10см урттай, 6см өргөн дугуй зууван дүрс зурж хайчлан авч эсгүүр гаргана. Эсгүүрийн дагуу бэлдэц даавуугаа 6 талаас бүрдсэн бөмбөг байхаар эсгэж амыг дотогш харуулан ирмэгүүдийг нийлүүлэн задрахааргүйгээр бөхлөн оёж бэлтгэнэ. Дотор нь 120 орчим грамм янз бүрийн үр тариаг хийж битүүлэн оёно.


Анхаарах зүйл:

Бөмбөг хийж буй даавуу материал нь сунахгүй, хүүхдэд харшил өгөхөөргүй, амархан цоорч урагдахааргүй материалыг сонгоно. Дотор хийх үр тариаг том жижгээр нь тэнцүү хэмжээтэй байхаар хольж хийнэ. Хэт нягт болбол хүнд болохоос гадна нягтран хатуурч сургалтын явцад бусдыг гэмтээх аюултайг санаарай. Иймд сургалтын өмнө бөмбөгийг нягтлан шалгаж байх хэрэгтэй. Хайч, зүү зэрэгтэй анхаарал болгоомжтой харьцаарай.

3. Жонглёрын цагираг хийх аргачлал

Циркийн жонглёрын төрөлд бөмбөг, цагираг, алчуур гэх мэт олон хэрэгслийг хослуулан хэрэглэдэг. Өнгө өнгийн цагирагаар чадварлаг наадах нь тайзан дээр гайхалтай харагддаг.

Энгийн нимгэн пластик хавтан ашиглан жонглёрын цагираг хийх аргачлалыг танилцуулж байна.



Ашиглах материал:

1. Зузаан нь 3 миллиметр, хааш хаашаа 40-45 см хэмжээтэй дөрвөлжин нимгэн пластик хавтан
2. Гортиг
3. Харандаа
4. Нарийн зүлгүүр
5. Нарийн хөрөө

Хийх аргачлал:

1. Зузаан нь 3 мм тус бүр нь 40-45 см хэмжээтэй пластик хавтан бэлтгэнэ.
2. Бэлтгэсэн хавтан дээрээ 30 см диаметртэй тойрог зурна.
3. Энэ тойргийн захаас дотогш 5 см, төвөөсөө 25 см диаметр бүхий тойргийг дахин зурна. Ингэхэд 5 см өргөнтэй цагирагны дүрс үүснэ.
4. Цагираг үүсгэхийн тулд дугуйн төвөөс дотор талын тойргийг дагуулан дахин цэвэр нямбай хөрөөднө.
5. Цагирагны бэлдцийг нарийн зүлгүүр ашиглан сайтар зүлгэж өө сэвийг дарна.
6. Эцэст нь цагирагийг сонирхолтой хүний анхаарал татахуйц болгох үүднээс өнгө бүрийн хуулган наалт эсвэл цахилгааны лентийг ашиглан бүрж гарт эвтэйхэн нухахгүйгээр зөөллөн орооно.

Анхаарах зүйл:

1. Пластик хавтан нь хатуу тул жонглёрын үед гарыг гэмтээхээс хамгаалан энгийн цахилгааны наалтыг ашиглан ирмэгийг бүрж зөөллөж болно.
2. Өөрийгөө гэмтээж бэртээхээс сэргийлж багаж хэрэгсэлтэй анхаарал болгоомжтой ажиллаарай.

4. Цэцэгт саваа хийх аргачлал

Саваагаар жонглёрдоход ихэвчлэн цэцэгт саваа, шулуун саваа гэсэн хоёр хэлбэрийг ашиглах бөгөөд бөмбөг болон цагирагаар жонглёрдохоос нэлээд ялгаатай.



Цэцэгт саваа нь хурдын хувьд удаан, жигд хөдөлгөөн шаарддаг тул бага насны хүүхдүүд, охид сонирхон хичээллэх нь их.

Ашиглах материал:

1. 50 см урттай шулуун саваа мод 2 ширхэг
2. 60 -80 см урттай шулуун саваа мод 1 ширхэг
3. Унадаг дугуй болон автомашины дугуйны дотуур хаймар -1 ширхэг
4. Өнгө өнгийн гялгар цаасан наалт
5. Цавуу
6. Цахилгааны наалт (лент)

Хийх аргачлал:

1. Савааны ишинд 2 см диаметртэй, 50 см урттай хоёр ширхэг; саваанд 60 - 80 см урттай, 2 см голчтой нэг ширхэг шулуун саваа модыг тайрч бэлтгэнэ.
2. Бэлдэцүүдээ нарийн зүлгүүрээр сайтар зүлгэн өө сэвийг дарж гадаргууг бөөрөнхий гөлгөр болтол зүлгэнэ.
3. Зүлгэж бэлтгэсэн 50 см урттай хоёр ширхэг ишийг нэг үзүүрээс нөгөө үзүүр хүртэл нь наалдамхай зөөлөн материалаар (цахилгааны лент) битүү ороож өгнө. Энэ нь савааг гулгаж унагахгүй барьцалдуулахад тустай байдаг. Үзүүрийг салахааргүйгээр сайтар бэхэлнэ. Хоёр талын үзүүрийг 2 см өргөнтэй их биеийн наалтаас өөр өнгийн наалтаар ороож наана.
4. Савааны их биеийг ишнээс ялгаруулахын тулд өнгө бүрийн наалддаг цаасан наалтаар битүү ороон нааж өгнө. Энэ нь савааны эргэлдэх хөдөлгөөнд гоёмсог харагддаг.
5. Дугуйны дотуур хаймрыг тус бүр нь 5 см өргөнтэй, урт нь 9 см байхаар 4 ширхэгийг тайрч бэлтгэнэ.
6. Бэлтгэсэн хаймрын өндрийн хэмжээ нийт 5 см байна үүнийг хоорондоо 1,8 см зайтай доош 4 см байхаар тооцоолон зүснэ.
7. Зүсэж бэлтгэсэн хаймрын зүсэгдээгүй битүү талыг ишний үзүүрүүдэд 1см өргөнтэйгээр тойруулан нааж бэхэлж өгнө. Энэ нь савааны эргэлдэх хөдөлгөөнд цэцэг хэлбэртэй болдог.

БҮЛЭГ IV.

“НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК” СУРГАЛТААР
ХҮҮХДҮҮДЭД БЭРХШЭЭЛИЙГ СӨРӨН
ТЭМЦЭХ ЧАНАРЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ



Нийгэмшүүлэх циркийн сургалтад оролцогчид нь амьдралын аливаа нугачаа, хүнд нөхцөл байдлыг даван туулж буй хүүхэд залуус байдаг. Эдгээр хүүхдүүдэд бэрхшээлийг сөрөн тэмцэх, даван туулах чадварыг сургалтаар хэрхэн олгох вэ?

Бэрхшээлийг даван туулах чанар гэж юу вэ?

Энэ чанар нь хүн ба бүлэг хүмүүсийн амьдралд тохиолдох аливаа хүнд бэрх нөхцөл байдлыг үл харгалзан урагш тэмүүлэх, цаашид улам хөгжин урагшлах чадвар юм.

Гэр бүлээсээ тусдаа байх, зүй бус харьцаа, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл дарамтад өртөх, дотнын хүнээ алдах, осол гэмтэлд орох, өвчин эмгэг тусах, нийгмээс тусгаарлагдах зэрэг аливаа хүнд асуудал нь сэтгэцийн гэмтэл, сэтгэлийн шарх үүсэх шалтгаан болж аюулгүй, тайван амьдрах болон хүүхдийн хөгжилд саад тотгор учруулж байдаг. Хүүхдийн эргэн тойронд байгаа тэдний хүмүүжил, хөгжилд нөлөө үзүүлж байдаг эцэг эх, гэр бүлийн гишүүд, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгчид гээд дотнын хүмүүс нь хэдхэн секундийн хугацаагаар хөмсөг зангидах, үл итгэсэн байдлаар мөрөө хавчих, нүдээ томруулан удаанаар тогтоож харах зэрэг нь хүүхдийн өөртөө итгэх итгэл, мөрөөдлийг бусниулан нураахад хангалттай. Эдгээр бараг өдөр тутамд гардаг сэтгэлзүйн дарамт нь хүүхдийн хөгжилд саад болдог бөгөөд энэ нь шууд харагдахгүй ч удаан хугацаанд үргэлжилж, хүүхдийн өсөлт хөгжилд ул мөрөө үлдээдэг урхагтай.

Нийгэмшүүлэх циркийн ажилтан бидний хувьд хүүхдэд өөртөө итгэх итгэлийг дахин олж авах, амьдралыг өөр нүдээр, үр өгөөжтэй, үр дүнтэй арга замаар эрж хайж, нээн илрүүлэх чадвартай болгодог бэрхшээлийг сөрөн тэмцэж даван туулах чадварыг эзэмшүүлэх нь хөтөлбөрийн цөм хэсэг нь билээ.

СЭДЭВ 1.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК СУРГАЛТАД ОРОЛЦОГЧ ХҮҮХДҮҮДЭД БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАНАРЫГ ХЭРХЭН ЭЗЭМШҮҮЛЭХ ВЭ?¹

Амьдралд тохиолдох бэрхшээл зовлон, гэмтэл, осолд өртсөн ч зарим хүмүүсийн хувьд бэрхшээл зовлонг төвөггүйгээр даван туулж чаддаг байхад, харин нөгөө хүмүүсийн хувьд цувран эргэлдэх байнгын бэрхшээлд ороогдон үлддэг байна.

Сэтгэлийн шарх

“Нийгэмшүүлэх цирк”-ийн дасгалжуулагч багш нар болон оролцогчдын хувьд аль аль нь сэтгэлийн шархтай байх тохиолдол олонтоо байдаг. Сэтгэлийн шарх, сэтгэцийн өвчин, нийгэмтэй үл зохицох гэсэн ойлголт нь нийгмийн ажлын үйлчилгээг шаардах бөгөөд энэ нь аливаа бэрхшээлийг даван туулж чадсан болон чадаагүй хоёр хүний хоорондын ялгааны талаарх асуулт юм. Энэхүү асуултыг задлан шинжилснээр аливаа бэрхшээлийг сөрөн тэмцэх чадвар эзэмшихэд нь туслах хамгаалалтын хүчин зүйл болон бэрхшээлийг сөрөн тэмцэх аргыг тодорхойлох боломж бүрдэнэ. Бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл, эцэг эхээ алдах, аваар осол, өвчин эмгэг, гэмт хэрэгт холбогдох, байгалийн гай гамшигт өртөх, эдийн засгийн хямралд орох, гэр бүл салалт, ганцаардал, нийгэмд эзлэх байр суурьтай холбоотой хямрал зэрэг бэрхшээлтэй нөхцөл байдалд шинээр дасан зохицох шаардлага хэнд ч тулгардаг. Эдгээр хямралт нөхцөл нь тухайн хүний сэтгэлзүйн онцлог, хямралын үргэлжлэх хугацаа, тохиолдлын хүндийн зэрэг, нийгэм соёлын орчин нөхцөл гэх мэт олон хүчин зүйлээс сэтгэлийн шарх үүсэх уг шалтгаан болдог.

¹ Морели. Д, Лафортун.Т. 2001, “Галт шувуу” Нийгэмшүүлэх циркийн сургагч багш нарт зориулсан сургалтын хөтөлбөр

Бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарыг бүрдүүлдэг ойлголтууд, энэ чанар хэрхэн идэвхжин сэргэдэг талаар дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд тодорхой ойлголт мэдлэгтэй байх нь туйлын чухал. Ийнхүү бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарыг бүрдүүлэгч ойлголтуудын талаар доор сийрүүлэн товч тайлбарласан болно.

Зан төлөв

Хүний зан төлөв нь бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарыг хөгжүүлэх суурь болдог. Өөрчлөгдөшгүй, генетикийн хувьд удамшдаг хэмээн үзэж ирсэн зан төлөв нь хүнийг генетикийн хувьд сайн, муу гэж хуваан үзэх чиг хандлагыг бий болгодог. Улмаар бэрхшээлтэй тулгарсан, эсрэг зан үйл гаргадаг, хэвийн хэмээх хэм хэмжээнээс өөрөөр биеэ авч явж байгаа хүүхэд, залуусыг буруутган ялгаварлах, тэр зам руу нь түлхэн оруулахад хүргэдэг байна. Зан төлөв нь төрөлхийн өөрчлөгдөшгүй зүйл биш, харин хүүхдийн төрсөн болон өсөн торниж байгаа орчин ба нийгэм, соёлын нөхцөл байдалтай холбоотойгоор хөгжиж байдаг. Хүүхдийн зан төлөвийг бүрдүүлэгч амьдралын туршлага нь түүний бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарыг тодорхойлох тул зарим насанд хүрэгчдийн анхаарал, өрөвдөн энэрэх сэтгэл, тусламж дэмжлэгийг өөртөө татах чадвартай байхад зарим нь ийм чадваргүй өөрт нь сайн санаагаар хандсан хүмүүсийг түлхэх байдал гаргадаг.

Ээнэгшлийн харьцаа

Ээнэгшлийн харьцааны дараах 4 төрлийг танилцуулж байна.

Бат бөх ээнэгшлийн харьцаа: Ээнэгшлийн харьцаа сайтай хүүхэд хүмүүстэй харилцаа сайтай байхдаа илүү амгалан, тайван, айх аюулгүй байдаг бөгөөд ээнэгшлийн харьцаанаас хөндийрөх үед өөр орлуулах зүйлийг идэвхтэй хайж тулгарсан бэрхшээлийг сөрөх, даван туулах чадвар сайтай байдаг.

Зугтаан зай барих ээнэгшлийн харьцаа: Ийм хүүхэд нь түүнийг тайван амгалан, айх аюулгүй байлгах өөр хувилбарыг эрж олох, эсвэл танихгүй хүнтэй сэтгэл санааны шинэ ээнэгшлийн харьцаа бий болгоход сэтгэлийн дотоод нөөц бололцоо муутай байдаг. Ийм хүүхэд нь өөрийг нь халамжлахыг хүсэж байгаа хүмүүсээс зай барих, хөндий байх зэргээр харилцдаг.

Шийдвэртэй биш ээнэгшлийн харьцаа: Ийм харилцаа нь хүүхдэд янз бүрийн зүйлийг нээн илрүүлэх боломж олгоогүй байдаг тул зөвхөн өөрийн уур уцаар, зовлонг илэрхийлж сурсан, харин бусдад туслах, бусдаас туслалцаа авах харилцаанд суралцаагүй байдаг. Ингэж уур уцаараа илэрхийлснээр тусламж

авах боломж бий болдог ч насанд хүрэгчдийн зүгээс хүүхдийг төвөгшөөх байдлаар харилцсанаас шалтгаалан холдож хөндийрөх байдал гаргахад хүргэдэг.

Замбараагүй ээнэгшлийн харьцаа: Энэ тохиолдолд хүүхэд өөртөө хэрэгтэй, ашигтай харилцаа бий болгож хөгжүүлэх, итгэл алдрахтай тэмцэх талаар ямар ч ойлголтгүй, арга барилд суралцаагүй байдаг. Ийм хүүхэд ээждээ, хэн нэгэн танихгүй хүнд, цаашилбал өөрөө өөрөөсөө хэрхэн тусламж эрж харилцахаа мэддэггүй. Энэ байдал нь насанд хүрэгчдийг өөрөөсөө хөндийрүүлэхэд хүргэдэг.

Дээрх тохиолдлуудын аль нь ч байсан хүүхэд бэрхшээлийг сөрөнтэмцэх чанарыг эзэмшиж болно. Энэ нь бат бөх ээнэгшлийн харьцаатай хүүхдэд арай амар байдаг бол зугтаан зай барих харьцаатай хүүхдэд арай хэцүү. Харин сүүлийн хоёр хэлбэрийн хувьд тэвчээртэй ажиллаж бат бөх ээнэгшлийн харьцааг бий болгож чадвал хүүхдийн хөгжил дахин эхэлж, улмаар бэрхшээлийг сөрөнтэмцэх чадварыг бий болгож болно. Энэ нь хүүхдийн амьдралд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхдөө тэдний талаарх өөрийн сөрөг ойлголтоо эвдэх нь чухал гэдгийг харуулж байна.

СЭДЭВ 2.

СЭТГЭЛЗҮЙН ХАМГААЛАЛТЫН ХҮЧИН ЗҮЙЛ

Зан төлөв, ээнэгшлийн харьцааны хэлбэрүүд нь бэрхшээлийг сөрөн тэмцэх чадварт тодорхой үүрэг гүйцэтгэдэг боловч хамгаалалтын хүчин зүйл болж чаддаггүй байна. Сэтгэлийн шархтай хүмүүсийн дунд түгээмэл илэрдэг сэтгэлзүйн хамгаалалтын зарим нэг арга хэрэгслийг танилцуулъя.

Хуваагдал: Энэ нь өөрийгөө нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хэсэг, нуугдмал хэсэг гэсэн хоёр хэсэгт хуваана. Жишээ нь: сургалтын явцад Б хүү биеэ тун сайн авч явж байсан боловч зөрчилдөөнтэй нөхцөл байдал үүсмэгц түүний зан чанар хоромхон зуур тэс өөр болно.

Үгүйсгэл: Энэ нь аюултай нөхцөл байдлыг анзаараагүй дүр эсгэх, эсвэл сэтгэл зовнилтыг багасгах боломжийг хүнд олгодог. Жишээлбэл: Ах дүү, төрөл садны хоорондох бэлгийн харилцааны талаар хэн нэг нь ярих бүр Э охин энэ тухай амьдралдаа анх удаа сонсож байгаа мэт дүр үзүүлдэг байв.

Өдрийн зүүд: Айдас, ядуу тарчиг, сэтгэлийн зовуурь бүхий бодит амьдралаас илүү сайхан мөрөөдлийн орчин өөртөө бий болгодог. Жишээлбэл: Ж хүү хэдийгээр маш ядуу муу байшинд амьдардаг ч түүнийгээ баян тансаг харш мэт дүрслэн ярьдаг юм.

Оюунлаг байх: Бидэнд ямарваа нэг асуудал, бэрхшээл учирлаа гэж төсөөлье. Оюун санаандаа хийсвэр ухагдахуун, хийсвэрлэлийг ашиглан бидэнд тохиолдсон тухайн асуудал, бэрхшээлийг даван гарах ерөнхий зүй тогтол, стратегийг олдог. Жишээ нь: Л охин сэтгэл хөдөлгөсөн, догдлуулсан, мөн сэтгэл бухимдуулсан нөхцөл байдалтай учрах болгондоо энэ нөхцөл байдал хэр ярвигтай вэ? Яагаад ийм байдал болсоныг тайлбарлахаас гадна энэ байдлыг бий болгоход нөлөөлсөн бүх хүчин зүйлсийн талаар дүн шинжилгээ хийдэг байна.

Хувиргал: Түрэмгийлэл, аливаа гаж үйлдлийг өөрийн оюун санаанд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа болгон төсөөлөн хувиргана. Жишээ нь:

С хөвгүүдтэй ойр дотно харилцаа тогтоохдоо муухан байсан бөгөөд буяны ажил хийж байгаа мэт өөрөөсөө азгүй хүмүүст тусалж байна хэмээн төсөөлдөг байв.

Тусгаарлал: Аливаа зовлон шаналал нь сэтгэл санааны гүн шарх үлдээдэг боловч тэр бүхнийг тухайн үйл явдлаас салган авч, сэтгэл хөдлөлд ямар ч хамаагүй үйлдэл мэт санаж явахыг хэлнэ. Жишээ нь: Д “Бүлэглэн үйлдсэн хүчингийн хэргийн хохирогч болсоноо тийм хэцүү асуудал биш” хэмээн үр нөлөөг нь бууруулан дурсдаг.

Хэт идэвх: Хүүхдэд ойр тойрноосоо богино боловч эрчимтэй цэнэг авах боломж олгодог. Жишээ нь: Б хүү маш тогтворгүй, сургалтын үеэр орж ирсэн хүн, ярьсан хүн болгоны чимээгээр Б хүүгийн анхаарал сарнидаг. Ойр орчинд нь байгаа хүмүүс түүнд байнга анхаарал хандуулах шаардлагатай болох бөгөөд тэр тэдэн дээр очиж, тэдэнтэй ярьж, тэр тоолонд түүнийг заавал буцааж байранд нь аваачих хэрэгтэй болдог.

Төсөөлөл, мөрөөдөл: Хангалттай хайр халамжинд өсөөгүй хүүхэд, ертөнцийн хаа нэгтэйгээс хүчтэй, чадалтай хэн нэгэн гэнэт гарч ирэн түүнийг хувь заяаны эргүүлгээс татан авч байна гэж төсөөлөн боддог. Жишээ нь: М охин од руу ширтэн өөрийн төсөөлсөн ээжийнхээ тухай янз бүрийн адал явдал зохион боддог.

Үл тоомсорлол: Тухайн өдөөгчийг хүлээн авч нөлөөлөхөөс нь өмнө шүүлтүүрээр шүүн, байхгүй эсвэл хүрэлцэхгүй байгаа зүйлээ орлуулдаг хамгаалалтын нэг хэлбэр. Жишээ нь: Б хүү аливаа зүйлд ямар ч анхааралгүй хандан үл тоомсорлодог. Энэ нь түүний аливаа болзошгүй дайралтаас өөрийгөө хамгаалах нэг арга ажээ. Тухайн үйл явдал болж өнгөрсний дараа нь тэрээр хүлээн авсан мэдээллээ боловсруулж, үнэлж үзнэ.

Хууль зөрчилт: Сургууль, гэр бүл, гудамж, ер нь нийгэмд гадуурхагдсан, доромжлол амссан хүүхдийн хувьд элдэв гэмт хэрэгт холбогдох нь тэдний бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарын нэг эх сурвалж болдог. Нийгэм, ёс заншлын хавчилтад баригдсан тэд хууль дүрэм зөрчих замаар бэрхшээлийг сөрөн тэмцэх чанартай болдог байна.

Хүрээлэн байгаа гадаад орчны нөлөөлөл, хүчин зүйлс нь хүүхдэд бэрхшээлийг сөрөн тэмцэх чанар бий болж хөгжихөд тусалдаг.

СЭДЭВ 3.

БЭРХШЭЭЛИЙГ СӨРӨН ТЭМЦЭХ АРГУУД

Энэ хэсэгт бэрхшээлийг даван туулах чанарыг нийгэмшүүлэх циркийн сургалтын үйл ажиллагаатай уялдуулан холбох боломжийн тухай авч үзэх юм.

Элэгсэг дотно харилцах

“Чухал учрал бидний амьдралыг өөрчилж чадна”

“М хүү амьдралынхаа эхний арван жилийг өдөр бүр хоорондоо зодолддог архичин эцэг эхтэйгээ хамт өнгөрүүлсэн байна. Түүнийг арван нас хүрэхэд хүүхэд асран хамгаалах төвд шилжүүлсэн боловч тэнд байх нь жаал хүүд огт таалагдсангүй. Гэтэл нэгэн өдөр тэрээр түүний амьдралд гэрэл гэгээ авчирсан цэцэрлэгчтэй тааралджээ. Өдөр бүр амьдралын жирийн асуулт асуухаар жаалхүү цэцэрлэгчийг хүлээдэг байв. Цэцэрлэгч хүүгийн асуултад найрсгаар харцулдаг байлаа. Насанд хүрэгчдийн хувьд хүүхдийн асуултад харцуулах нь тун амархан бөгөөд багахан хугацааг зарцуулдаг. Харин хүүгийн хувьд энэ бол том үйл явдал, гайхалтай зүйл байв. Хүү амьдралдаа анх удаа өөрийг нь тоож өөртэй нь найрсгаар харилцсан хүнтэй тааралдсан бөгөөд хожим нь тэрээр сайн эрдэмтэн болсон нь тэрхүү сайн санаат хүний харилцаа л хүүгийн амьдралыг эргүүлсэн гэж өөрөө дурсан ярьдаг.

Энэ жишээ нь хүүхдийг хүн гэж харьцдаг хэн нэгэнтэй уулзсан санамсаргүй уулзалт нь хүний амьдралыг хэрхэн өөрчилж болдгийг тодоор харуулж байна. Энэ бол бэрхшээлийг сөрөн тэмцэх хамгийн эхний бөгөөд хамгийн чухал арга юм.

Хүүхэдтэй харилцах ойр дотны халуун дулаан харилцаа ямар хэлбэрээр илэрч болох вэ? Бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарыг өдөөсөн энэхүү харилцаа үнэхээр үр дүнтэй байхын тулд сэтгэлийн шарх тээж яваа хүүхэд тийм харилцааг яаж таньж мэдэж болох вэ?

Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан сургалтын агуулгыг төлөвлөхдөө юуны өмнө сургалт нь хүүхдүүдтэй харилцаа холбоо

тогтоох нэг чухал боломж гэсэн ойлголтоор хандах хэрэгтэй. Энэ нь хүүхдэд нэн түрүүнд дутагдаж буй хэрэгцээг мэдрэх алтан боломж болдог.

Хүүхдийн хэрэгцээ нь ерөнхийдөө хүний үндсэн хэрэгцээ болох хоол, нойр, орон байр байдаг ч гэсэн амьдралынхаа утга учрыг олох хэрэгцээ тэдэнд бий. Хүүхэд бүрийг сургалтын жирийн нэгэн оролцогч биш, өөрийгөө хамт олны нэгэн чухал хэсэг, хамт олондоо хэрэгтэй хүн гэдгийг мэдрүүлэн түүнд ойлгуулахад чиглэн сургалтаа зохион байгуулбал бэрхшээлийг даван туулах чадварыг эзэмшүүлж буй нэг арга юм.

Бүтээлч байдал.

Бэрхшээлийг сөрөн тэмцэх үйл явцын нэгэн томоохон хэсэг нь хувь хүний, ихэнхдээ гашуун, хөндүүр, түүхийг бүтээлч урлагийн хэлбэрээр ашигтай, үнэтэй дурсамж, түүх болгон ашиглах явдал юм. Энэ нь зовлон шаналлыг даван туулах эрч хүчийг өгдөг байна. Өөрийн амьдралын туршлагад тулгуурлан зураг зурах, шүлэг, зохиол, өгүүлэл бичих зэргээр амьдралын түүхээ урлаг болгон хувиргах, өөрөөр хэлбэл бүтээлч урлагийн нэгэн хэлбэрт шилжүүлэх нь бидний амьдралын түүхийг утга учиртай болгож, бидний дотоод сэтгэлийн шархыг мэдрэн ойлгох, бусад хүмүүс биднийг ойлгон харах арга хэлбэрийг өөрчилж байдаг.

Төсөөлөн бодох нь бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарын хамгийн үнэт дотоод нөөц юм. Бүтээлч ажиллагаа нь чөлөөт цагаа өнгөрүүлэх үйл ажиллагаа биш юм. Бүтээлч байдал нь хүнийг өөрчлөх цоо шинэ ертөнцийг бий болгох ёстой. Энэ нь амьдрах замаа олох, өөртөө болон амьдралдаа итгэх итгэлээ дахин олж авах гол арга зам болдог. Иймд сургалтад хамрагдагч хүүхдүүдийн бүтээлч сэтгэлгээ, бүтээлч байдлыг хэрхэн дэмжин хөгжүүлэх вэ гэдгийг сайтар бодолцох ёстой.

Өөрийгөө хүндэтгэх

Бүтээлч урлагаар дамжуулан өөрөө өөрийгөө харах, ойлгох арга замыг өөрчлөх, мөн бусад хүмүүс биднийг ойлгож харах арга замыг өөрчлөх явдал нь өөрийгөө хүндэтгэх, үнэлэхийн суурь болдог. Бид үйл ажиллагаа явуулахдаа жинхэнэ бодит үр дүнд хүрэхийн төлөө л ажиллах хэрэгтэй бөгөөд энэ нь биднээс бүхий л ур чадвараа дайчлахыг шаарддаг. Хүүхдүүдийн хувьд бодитоор ахиц дэвшил гаргаж байгаа нүдэнд илт харагдаж мэдрэгдэхүйц зүйл дээр урамшуулан зоригжуулж итгэл хүлээлгэн ажиллах арга барилыг хэрэглэх нь тустай.

Хошин шогийн мэдрэмж

Хамгийн сайн дасан зохицох стратеги болох хошин шог нь хүнийг сэтгэлзүйн хувьд бараг бүхэлд нь эзэмддэг. Бид бодит байдал, төсөөллийн байдал хоёрын хоорондын зааг ялгаатай нүүр тулан учрах үед хошин шог нь сэтгэл санааны чухал дэмжлэг болно. Алиа хошин байдал нь бидэнд хүнд нөхцөлөөс гарах гарцыг бий болгодог.

Бусдын төлөө чин сэтгэлээсээ хандах

Өөрсдөө бид сэтгэлийн шархтай ч бусдад тийм шарх бийг мэдрэх чадварынхаа ачаар бид зовж шаналж байгаа хүмүүст туслах чадвартай байдаг. Энэ нь бид бусдад хэрэгтэй юм байна гэдгээ мэдэрч, амьд явах нэг шалтгаан болж, амьдралын утга учрыг олох, өөрөө өөрийгөө хүндлэх, өөрийгөө үнэлэх чадвараа дээшлүүлэх боломж олгодог.

Олон нийтийн үйл ажиллагаанд оролцох

Олон нийтийг хамарсан ямарваа нэгэн үйл ажиллагаанд оролцох нь бидэнд сэтгэл санааны хувьд ихээхэн дэмжлэг болдог. Энэ нь аливаа зүйлийг өөрчлөх хүсэл эрмэлзэл, нөхцөл байдлыг ойлгох боломжийг бүрдүүлдэг. Түүнчлэн асуудлыг минь ойлгон хуваалцдаг хүмүүсээр орчноо бүрдүүлэхэд тусалдаг.

Аливаад харьяалагдах, хамаарагдах мэдрэмж

Ямар нэгэн бүлгийн гишүүн биш хаана ч харьяалагддаггүй хүүхэд бусдад танигдах, бусадтай хамтрах хүсэлгүй байдаг. Тэд өөрсдийгөө нийгмээс гадуур төсөөлдөг. Аливаа бүлэгт харьяалагдах нь хүний үзэл бодлыг төлөвшүүлж, өөрийгөө хөгжүүлэх, ур чадвар эзэмших орон зайг бүрдүүлж өгдөг байна.

Ийнхүү бид бэрхшээлийг сөрөн тэмцэх зарим аргуудын талаар ойлголттой боллоо. Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд эдгээр аргуудыг амьдралд хэрэгжүүлэхдээ доорх чанаруудыг эзэмшсэн тохиолдолд илүү хялбар байх болно.

1. Хүүхдийг хүн хэмээн бүрэн хүлээн зөвшөөр;
2. Хүүхдэд өөрийн чадвараа илтгэн харуулах орчин бүрдүүл; Бүтээл чадвараа хөгжүүлэх тийм тохиромжтой орчинд хүүхэд сэтгэлийн хөөрөл, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, төсөөлөл, мөрөөдлөөрөө дамжуулан боломж, бололцоог эрж хайж сурах, өөрсдийнхөө тухай болоод дэлхий ертөнцийн тухай төсөөллөө өөрчлөх чадвартай болдог.
3. Хүүхдүүдэд хоорондоо болон бусадтай чөлөөтэй, илэн далангүй харилцах орчин үүсгэ. Тэдэнд бусад хүмүүс өөрсдийг нь зүрх сэтгэлээсээ

сонсдог гэдгийг мэдрүүл. Энэ тохиолдолд тэд амьдралдаа үзэж өнгөрүүлсэн туршлагаас өөр аргаар хүмүүстэй харилцаж, ярилцаж болдгийг мэдэж авна.

Хүүхдэд бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарыг эзэмшүүлэхдээ дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд “урьдчилсан нөхцөлүүд”-ийн талаар ойлголттой, хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдлэг, чадвартай байх нь зүйтэй.

Эдгээр урьдчилсан нөхцөлүүдэд дараах ойлголтууд багтана:

- Хүүхдийн хөгжлийн онцлогийг харгалзах;
- Халуун дотно, утга учиртай харилцаа холбоо тогтоох;
- Санаачлагч байх;
- Оролцогч бүр идэвхтэй байх ёстой, тэд бүгд чухал үүрэгтэй гэдгийг ойлгон хүлээн зөвшөөрөх;
- Чиглэл тогтоож өгөх;
- Хийж чадах зүйлээс нь арай хэцүү зүйлийг хийхийг хүсэх;
- Ид шидийн орон зайг бий болгох;
- Ярилцах, санаа бодлоо илэрхийлэх орон зайг бий болгох;
- Харьяалагдах, хамаатах бүлэг бий болгох;
- Өөртөө туслах сүлжээг бий болгох;
- Тогтсон дадал бий болгох;
- Сургалтын үе шатуудад болон оргил үед билэгдлийн шинж чанартай нэр өгөх, кодлох;
- Хэмнэлийн ач холбогдлыг ухааруулах;
- Наргианч алиа хошин байх;
- Итгэлцэл бий болгох;
- Амьдралыг харах өөр үзэл баримтлал, үзэл санааг төлөвшүүлэх;
- Биеийн хэлэмжийг ойлгон уншиж сурах;

Хүүхдийн хөгжлийн онцлогийг харгалзах

Бид сургалтад хамрагдаж байгаа хүүхдүүдээ, нэг талаас биологи, сэтгэлзүйн буюу дотоод хүчин зүйлс, нөгөө талаас гэр бүл, соёл нийгмийн нөлөөлөл буюу гадаад хүчин зүйлсийн харилцан үйлчлэлд байгаа, хөгжлийн шатандаа яваа хүн гэж үзэж хандах хэрэгтэй. Хүүхдийн давуу тал, чадварыг хэрхэн үнэлж хөгжүүлэх нь биднээс л хамаарна. Мөн зан үйлийн бэрхшээл тохиолдож буй тэрхүү цэгийг олж, түүнд хүрч ажиллаж чадах эсэх нь мөн л биднээс шалтгаална. Үнэндээ бол бэрхшээлтэй асуудал “үржил шимтэй хөрс шороон” дээр үүсдэг бөгөөд яг тэрхүү эмзэг газар бид авьяас чадварыг хайж илрүүлэх хэрэгтэй байдаг. Иймээс зан суртахууны доголдолтой хүүхдүүдтэй шантралгүй ажиллах шаардлагатай.

Санаачлагч байх

Сургалтынхаа явцад бид хүүхдүүд, оролцогчидтой ойр дотно, халуун дулаан уур амьсгал, харилцаа холбоог бүрдүүлэн оролцогч талуудын үүргийг маш тодорхой болгох хэрэгтэй. Хүүхдэд бусад хүмүүстэй хамтран ажиллахын амтыг мэдрүүлсний дараа, тэднийг анхааралтай сонсож, найрсагаар хандсаны дараа, тэдэнтэй инээж наадсаны дараа тэд чадлынхаа хэрээр өөрсдийгөө илэрхийлж, туршлага, ур чадвар сууж, өөрөө өөрийгөө дахин хүндэлж эхлэхийг харах эсэх нь биднээс хамаарна. Тэдэнд урам өгч, тэдний ахиц, дэвшил болгоныг дэмжиж, тэдний өмнө зорилго тавьж, амжилт, ололтод хүрэхэд нь дэмжин тусалж, мөн алдаа дутагдлаа хүлээж сурахад тусал. “Санаачлагч” гэдэг нь мэдлэгийг зөвхөн механикаар дамжуулах биш харин сурах үйл ажиллагааны явцад хүн өөрөө өөрийгөө нээх боломж юм гэдгийг ойлгоно.

Оролцогч бүр идэвхтэй байх ёстой, тэд бүгд чухал үүрэгтэй гэдгийг ойлгон хүлээн зөвшөөрөх

Сургалтыг зохион байгуулахдаа манлайллыг бодитой бөгөөд зохих ёсоор хувааж хэрэгжүүлэх нь чухал. Үүний зэрэгцээ тухайн үед сургалтыг удирдан явуулаагүй ч оролцогч бүрийн гүйцэтгэх үүрэг сургалтыг удирдаж буй манлайлагчийнхтай яг адил чухал гэдгийг ойлгосон байх хэрэгтэй. Тэдэнд туслахыг эрмэлзсэн аливаа оролдлого бүр, тэдэнд хандуулсан аливаа анхаарал бүр, тэдэнд өгсөн урам зориг, энэ бүгд бэрхшээлийг сөрөн тэмцэх аргад сургадаг.

Чиглэл тогтоож өгөх

Зааварчилсан байдлаар хүүхдүүдтэй харилцана гэдэг нь бид тэдэнд хүсэл зориг, эрх мэдлээ тулган хүлээлгэж байгаа хэрэг биш юм. Харин энэ нь хүүхдүүдэд өөрсдийн тогтсон итгэл үнэмшил, ертөнцийг үзэх үзлээсээ (тэднийг одоогийн байгаа энэхүү байдалд хүргэсэн) гарч, оршин тогтнох болон аливаа зүйлийг хийх өөр арга барилыг нээж илрүүлэх боломж олгох төдийгүй өөрсдийн гадаад, дотоод орчин нөхцөлд өөрчлөлт хийх боломжийг нээж өгдөг. Жишээлбэл: Соёлын олон талт байдлыг танилцуулах нь урд нь мэдэхгүйгээсээ болоод ер нь эзэмшээгүй байсан шинэ ертөнц шинэ боломж нээгддэг.

Хийж чадах зүйлээс нь арай хэцүү зүйлийг хийхийг хүсэх

Бид хүүхдийн хөгжилд нөлөөлөх хамгийн сайн арга зам бол олон төрлийн үйлчилгээ үзүүлэх явдал хэмээн ойлгох тал бий. Бүтээлчээр бус, идэвхгүй авсан тусламж, дэмжлэг өөрөө өөрийгөө дайчлах, хүндлэх, өөрийнхөө амьдралын

төлөө хариуцлага хүлээх зэрэгт ямар ч нөлөө үзүүлдэггүй. Хүүхдүүд өөрсдөө өөрийгөө өөрчлөх өөрчлөлтийн гол хөдөлгөгч хүч нь байх ёстой. Хүүхдийн чадварыг бодитой үнэлж, чадварт нь тохирсон зүйлийг нь хийлгэх хэрэгтэй. Тэдэнд тохирсон даалгавар, дасгал өгч “би чадахгүй байна”, “энэ надад таалагдахгүй байна” гэх зэрэг ярианд нь бодитой хандах нь чухал. Зарим хүүхэд хүссэн ч залхуугаасаа болоод хөдөлдөггүй, нөгөө хэсэг нь алдаа гаргахаасаа айн үйлдэл хийдэггүй улмаар хэн ч тоолгүй хаягдахад хүрдэг. Энэ үе шатыг даван туулахад нь тусалснаар тэдэнд томоохон итгэмээргүй өөрчлөлт хийх эхлэл тавигдана.

Ид шидийн орон зай бий болгох

Сайхан засаж тохижуулсан заал эсвэл юу ч үгүй хоосон дасгалын өрөө ч бай түүнийг ид шидийн гайхамшигтай орчин болгож хувиргах нь та биднээс шалтгаална. Тоног төхөөрөмж, хэрэгсэлээ болгоомжтой, урлагтай байрлуулж, хүүхдүүд болон дасгал сургуулилтын орчинг илүү хамгаалалттай, аюулгүй болго. Бид жирийн ажлын орчин, уур амьсгалыг бүрдүүлэх нь бидний зорилгод нийцэхгүй. Иймээс хүүхдүүдэд өөр хоорондоо, бусадтай, дэлхий ертөнцтэй холбогдох өөр арга замыг нээж өгөх учиртай.

Ярилцах, санаа бодлоо илэрхийлэх орон зайг бий болгох

Сургалтын үргэлжлэх цаг ихэвчлэн долоо хоногт 4-8 цаг байна. Үүнээс бусад цагт тэдний амьдрал өөр газар өрнөдөг. Ярилцах орон зай буюу энэ газар нь тэдний хувьд энэ хоёр газрын хооронд бамбай зурвасын үүрэг гүйцэтгэнэ. Хүний дотоод сэтгэлийн ертөнцөд явагдаж буй өөрчлөлт нь гадаад ертөнцөд өөрчлөлт хийхэд уриалан дууддаг учир хүүхдүүд тэдний амьдралд юу болоод байгааг ойлгож, мөн тайлбарлан амьдралдаа болж байгаа тэр үйл явцыг дүгнэн цэгнэх боломжийг олго.

Харьяалагдах бүлэглэлийг бий болгох

Сургалтын эхний өдрөөс л хүүхдүүдийн дунд харьяалагдах бүлэглэл бүрэлдэж эхэлж байгааг анзаар. Оролцогчид бие биеэ таньж мэдэх, хоорондоо харилцан мэдээлэл солилцох байдлыг дэмжих бүхий л боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Бүлгээрээ тоглох тоглоом нь хамтач сэтгэлгээ, бие биетэйгээ холбогдон харьцах байдлыг хөгжүүлдэг. Өрсөлдөн тэмцэх тоглоомоос аль болох зайлсхийх нь зүйтэй. Тоглоом нь оролцогч бүр өөрийгөө бусадтай биш өөртэйгөө харьцуулан чадлынхаа хэрээр багийн ялалтад хувь нэмэрээ оруулдаг байхад чиглэх учиртай.

Өөртөө туслах сүлжээг үүсгэ

Харилцан бие биедээ туслах, мэдээллээ хуваалцах, сургалтад хөндсөн асуудлуудыг хоорондоо хэлэлцэн ярилцах зэргээр хамтран ажиллах нь хүүхдүүдэд амьдралынхаа утга учрыг дахин олж нээхэд тусална.

Тогтсон дадлыг бий болгох

Тухайн бүлгийн хувьд тогтсон дадал хэвшил нь уур уцаар, түрэмгийлэл гэх зэрэг аливаа сөрөг харилцааг бүх бүлгээрээ хүлээн зөвшөөрөгдсөн, бүлэгт эергээр нөлөөлөх гэрээ тохироо болгон зөөлрүүлдэг. Ингэснээр хүчирхийлэлд хүргэх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлдэг байна.

Угтан авч мэндчилэх дадал хэвшил нь хүүхдүүдийг сургалтын бодит орчинд оруулж гадаад орчны бэрхшээлтэй аливаа асуудлаас нь түр ч болов хөндийрүүлэх зорилготой. Ингэснээр тэдэнд сургалтаас аль болох ихийг мэдэж авах боломжийг олгоно. Сургалтын явцад нууц үг, нууц код бий болгох, нэр оноох, эсвэл сургалтын үе шатыг болон гол гол чухал ач холбогдолтой хэсгийг тэмдгээр юмуу бусад дохиогоор төлөөлүүлэн тодорхойлох нь цаг хэмнэхээс гадна хүүхдүүдэд илүү тайван орчин бий болгодог байна. Жишээ нь: Бид тойргоо сургалтын эхэнд болон төгсгөлд хийж түүнийгээ “амьдралын харгуй”, “ариун тойрог”, “омог бүлэг” гэх мэтээр нэрлэж болох юм. Дохио зангаа, чанга болон чихэнд шивнэсэн үг, эсвэл алга таших зэрэг нь тухайн заасан тойргийг үүсгэх, орон зайд бүлэг үүсгэх, шинэ зааврыг анхааран сонсох, хэмнэлээ өөрчлөх гэх мэт тодорхой үйлдлийг тогтсон илэрхийлэл болгон хэвшүүлж болно.

Хэмнэлийн ач холбогдлыг ухаарах

Хэмнэл нь сургалтын уур амьсгалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ганцаараа болон бүлгээрээ дасгал хийж хоорондын харилцан хамаарлаа мэдрэх эрчимтэй мөчүүд, арай тайван байх үе гэх мэтээр аль алийг нь сургалтын явцад мэдрэмжтэйгээр зохицуулан хий. Сургалтын явцад хэнд ч уйдаах цаг гарах ёсгүй. Бид сахилга бат, зан үйлийн бэрхшээлтэй асуудал үүсэхэд хүргэдэг сул цаг гаргахгүйг хичээнэ. Ингэснээр хүүхдүүдийн хүсэл, тэмүүллийг хэвээр хадгалан, бүлгийнхээ эрч хүчийг тэтгэж чадна.

Амьдралыг харах өөр үзэл баримтлал, үзэл санааг төлөвшүүлэх

Бид циркийн дасгал сургуулилтаар хүүхдүүдийн бие бялдартай ажиллан, дүр бүтээлтээр дамжуулан тэдний сэтгэл, оюун бодолд хүрч очиж байдаг. Харин тэдэнд шинэ амьдрал зохиох эрч хүчийг өгөх бүтээлч ажиллагааг

эрчимжүүлэхийн тулд бид үг, дүрслэл, тэмдэглэгээ ашиглаж болно. Амьдралын тухай шинэ үзэл бодлыг бий болгоно гэдэг бид өнгөрсөн амьдралынхаа тухай төсөөлөл ойлголтоо өөрчилнө гэсэн үг юм. Ийм өөрчлөлт нь бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарыг өдөөхөд ихээхэн ач холбогдолтой байдаг. Сургалтын явцад олж авсан чадвар, туршлагыг хүүхдүүдийн өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж, тэднийг өөрсдийн амьдралд өөрчлөлт хийх чадвартай болгохын тулд хүүхэд, бүлгийн онцлогт тохируулан “дараагийн сургалт хүртэл өнөөдрийн сургалтан дээр зохиосон алхалтаа сайн хийж байгаарай”, “Ирэх гурван өдөр гадуур явахдаа чиний амьдралыг бүхлээр нь өөрчлөх ямар нэгэн эрдэнэ олсон юм шиг л алх”, “Гудамжинд гараад аль болох олон хүн рүү хараад инээмсэглээрэй, сайн байна уу гэж мэндлээрэй” эсвэл “хэнтэй ч бүү ярь, хүн рүү харахдаа бүр айсан юм шиг байдал гарга” гэх мэтээр зааварчилгааг өгч болох юм. Бид мөн хүүхдүүдэд санал тавьж эерэг таамаг дэвшүүлэх замаар ганцаарчилсан даалгавар гүйцэтгэх заавар өгч болно. Жишээ нь: “Дараагийн удаа бид эргэн уулзахад чи бүр их хүсэл эрмэлзэлтэй байх болно” гэх зэрэг үг ашиглан урьдчилсан эерэг таамаглал дэвшүүлэн урам зоригоор тэтгэж болох юм.

Биеийн хэлэмжийг ойлгон уншиж сурах

Харилцаа холбоо гэдэг нь хэл яриа, гар хөлийн хөдөлгөөн, нүдний харц, сонсгол, үнэр амт, хүртэхүй бүгдийг нэгтгэсэн тогтолцоо гэдгийг мэдэж байх ёстой. Хүүхдүүдийн хоорондын харилцааны хэлийг ойлгож сурснаар тэдэнд өөрсдийг нь бусад хүмүүс ойлгохыг хүсэж байна, улмаар ойлгож байна гэдгийг мэдэх болно. Үүний дараа бид тэдэнд ертөнцийн тухай тэдний үзэл бодлыг өргөжүүлэхийн тулд бусад хэл, харилцааны аргуудыг танилцуулах болно.

Нийгэмшүүлэх циркийн сургалтаар эдгээр урьдчилсан нөхцөлүүдийг хүүхэд бүрийн өвөрмөц онцлог, түүний бие бялдар, сэтгэлзүйн болон дотоод сэтгэлийн онцлогтой, амьдралын түүхтэй нь, авьяас билэгтэй нь, нөөц бололцоо, дасан зохицох чадвартай нь харгалзан үзэх хамгийн чухал юм. Гэхдээ энэ бол бүх нөхцөлд тохирох бэлэн жор биш ч сургалтад оролцогч бүрийн өвөрмөц онцлогийг олж мэдрэн, хүн болгонд тохирсон аргыг хэрэглэх ур чадвараа хөгжүүлэх ёстой.

БҮЛЭГ V.

**ХҮНД НӨХЦӨЛ ДЭХ ХҮҮХЭД
ЗАЛУУЧУУДТАЙ АЖИЛЛАХ НЬ**

СЭДЭВ 1.

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

“Нийгэмшүүлэх цирк” сургалтад оролцогчдын ихэнх нь нийгэм, сэтгэлзүй, эдийн засгийн хүнд нөхцөлд амьдарч буй эрсдэлт бүлгийн хүүхэд залуучууд байдаг талаар дээр дурдсан билээ. Хэдийгээр эрсдэлтэй, хүнд нөхцөлд амьдарч байгаа ч гэсэн тэд бусад өсвөр үеийнхнийхээ адил бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүйн хувьд хөгжиж байдаг.

Хүүхдийн хөгжил нь маш олон талтай, олон хүчин зүйлээс хамаарах хэдий ч хүүхэд бүрийн хөгжил харилцан адилгүй ялгаатай, дахин давтагдашгүй шинж чанартай байдаг.

Хөгжлийг маш энгийнээр тайлбарлавал биологийн болон орчны хүчин зүйлүүдийн нөлөөгөөр хүүхдийн бие махбод, зан үйлд гарч буй дэвшилтэт өөрчлөлт юм.

Хүүхдийн хөгжил нь бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүй гэсэн өөр хоорондоо салшгүй холбоотой гурван хэсгээс бүрддэг.¹

Бие махбодын хөгжил

Хүүхдийн бие эрхтний хэлбэр, хэмжээ, тархи мэдрэлийн эрхтэн системийн хөгжил, аливаа зүйлийг хүртэн мэдрэх, хүлээн авах чадвар буюу мэдрэхүйн эрхтнүүдийн хөгжил, дотоод шүүрлийн булчирхайнуудын үйл ажиллагааны өөрчлөлт, булчин шөрмөсний хөгжил зэрэг хүний биеийн гадаад дотоод бүтцэд гарч буй үйлүүд нь энд багтана.

Танин мэдэхүйн хөгжил:

Хүүхдийн оюун ухаан, сэтгэхүй, ой, анхаарал, хүртэхүй, аливаа зүйлийг задлан ялгах, нэгтгэн дүгнэх чадвар зэрэг сэтгэцийн нарийн үйлүүд болон асуудал шийдвэрлэхтэй холбоотой сэтгэцийн процессууд энд багтана.

1 О. Мягмар, Т. Цэндсүрэн, М.Нямдорж, Б. Нямсүрэн, Я. Нарангэрэл, Хүүхдийн хөгжил ба нийгмийн ажил, УБ 2002,

Нийгэмшихүйн хөгжил:

Нийгэмшихүйн хөгжил нь нэг талаас хүүхдийн зан үйлийн хувийн өвөрмөц онцлог буюу хувь хүний онцлог, нөгөө талаас бие хүний шинж чанаруудын төлөвшил буюу нийгмийн орчны нөлөөлөл, нийгмийн туршлага, харилцаа, гэр бүл, нийгмийн бусад байгууллага, бүлгүүдийн харилцан үйлчлэл, өөрөө өөртөө хандах хандлага болон аливааг үнэлэх нийгмийн үнэлэмж баримжаалалд гарч буй өөрчлөлтийг багтаадаг байна. Хөгжлийн энэ хоёр тал нь хоорондоо нягт харилцан холбоотой явагддаг.

Хүүхдийн хөгжлийн эдгээр чиглэлүүд нь харилцан хоорондоо уялдаа холбоотой бөгөөд нэг чиглэлд гарсан өөрчлөлт нь бусдадаа нөлөөлж байдаг. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан нь хүүхэд, залуучуудын нас, бие бялдрын хөгжлийн талаар зохих мэдлэгтэй байснаар:

- Оролцогчдын хөгжлийн үе шатыг хүлээн зөвшөөрөх
- Тэдний суралцах хурдыг хүндэтгэх
- Сургалтын агуулгыг төлөвлөх
- Насны бүлэгт тохирсон аргачлалаар ажиллах
- Оролцогчидтой харилцах харилцааны эерэг хандлагыг төлөвшүүлэхэд дөхөм болох юм.

Хүний насны үе шат бүрд гарах хөгжлийн талаар тухайлбал хувь хүний биологийн хөгжлийг нийгмийн орчинд дасан зохицох үйл явцтай хослуулсан тайлбарласан олон онолууд байдаг. Эдгээр онолуудад хүний насыг бүлэглэхдээ өөр өөрийн онолын үүднээс харилцан адилгүй ялгаатай байдлаар авч үзсэн байдаг учир бусад эх сурвалжаас уншин танилцаж судлах боломжтой.

СЭДЭВ 2.

ХҮҮХДИЙН НАСНЫ ҮЕЧЛЭЛ, ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ

Нийгэмшүүлэх цирк сургалтад ихэвчлэн 6-18 хүртэлх насны хүүхэд залуучууд хамрагдаж байгаа тул энэ насны хүүхдүүдийн насны онцлог, хөгжлийг энд авч үзье.

6-12 насны хүүхдийн хөгжлийн онцлог

Америкийн нэрт сэтгэл зүйч Эрик Эриксоны хүний хөгжлийн онолоор бол энэ насыг бүхэлд нь сургуулийн нас гэж нэрлэсэн байдаг.

Хүснэгт 4

	Хүүхдийн хөгжил	Багшийн анхаарах зүйл
6-12 насны хүүхдийн хөгжлийн онцлог		
Бие бялдрын хөгжил	Энэ насны хүүхдийн бие махбодын өсөлт хөгжил ерөнхийдөө маш эрчтэй хурдан явагдана. Бие эрхтнүүдийн өсөлт хөгжлөө дагаад биеийн хөдөлгөөн, хурд, хүч нь сайжирна. Энэ насны хүүхдүүдийн хувьд нурууны яс болон хөлийн улны (тавхайны) ясжилт гүйцэт хөгжиж бэхжээгүй байдаг. Мөн гарын сарвууны жижиг нарийн булчингийн хөгжил гүйцээгүй байна.	Жонглёрын төрлийг заахдаа хатуу, хүнд жинтэй хэрэгсэл ашиглахаас татгалзах нь зүйтэй. Үсрэлт харайлтын дасгал техник хийлгэхдээ 80 сантиметрээс дээш өндрөөс үсрэлт хийлгэхийг хориглоно.

Танин мэдэхүйн хөгжил

Энэ насанд хүүхдүүдийн өсөлт хөгжилт жигд биш харилцан адилгүй явагдана. Охид хөвгүүдээс эрт өсөх хандлагатай байдаг. Энэ наснаас эхлэн хүйсийн ялгаа онцгой тодорч ирэх бөгөөд бие махбодын эрхтнүүдийн бүтэц, үйл ажиллагааны өөрчлөлтүүд мэдэгдэхүйцээр болж эхэлдэг. Мөн бэлгийн бойжилтын анхдагч ба хоёрдогч шинж тэмдгүүд тодорно.

Швейцарын сэтгэл зүйч эрдэмтэн Жан Пиаже хүүхэд, өсвөр үеийнхний хөгжлийг нарийн судалсан байдаг.

Тэрээр тархины хөгжил, оюуны үйлийн хөгжил хоорондоо салшгүй холбоотой гэж үзсэн. Энэ насны хүүхдийн танин мэдэхүйн хөгжил нь бодит үйлдлийн сэтгэхүйгээс хийсвэр үйлдлийн сэтгэхүй рүү шилжин хөгжинө гэж дүгнэсэн.

Тодорхой үйлдлийн шат:

7 наснаас эхлэн хүүхдийн логик сэтгэлгээ хөгжиж эхэлнэ. Юмсыг ангилж, бүлэглэж, дэд бүлгүүдэд хувааж чаддаг болно. Энэ шатан дээр зарим нөхцөл байдал өөрчлөгдөж байхад юмсын шинж чанар тогтвортой хадгалагддаг гэдгийг хүүхэд ойлгох чадвартай болно. Энэ үеэс эхлэн хүүхэд логикоор өөрөөр хэлбэл юмсын утга учир тулгуурлан сэтгэж эхэлнэ. Энэ насанд хүүхдийн оюун ухаан танин мэдэхүйн чиглэл түлхүү хөгжинө. Хүүхдүүд сониуч, аливаа зүйлийг танин мэдэх гэсэн хүсэл эрмэлзэл дүүрэн, идэвхтэй байдаг. Аливаа зүйлийг зориуд хийх чадвартай ч зориг тэвчээр багатай, анхаарал төвлөрөл, сонирхол, хэрэгцээ нь тогтворгүй, өөрийгөө хянан жолоодох чадвар сул хөгжсөн байдаг.

Энэ үед дасгалжуулагч багшийн зүгээс сургалтын явцад эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд олуулаа хийх дасгал, техникүүдийг хийлгэхдээ мэдрэмжтэй хандах шаардлагатай.

Энэ насныхныг урмаар тэтгэх, сонирхол хэрэгцээнд нь тохирсон зүйлсийг хийлгэх нь илүү үр дүнтэй. Мөн аль болох олуулаа оролцсон бүлгээр тоглох, нийгэмшлийг дэмжих тоглоомыг тоглуулах нь зүйтэй.

<p>Нийгэмшихүйн хөгжил</p>	<p>Энэ насныхны сэтгэл хөдлөлийн хамгийн гайхамшигтай талуудын нэг нь өөрийгөө бусдад танин мэдүүлэх явдал байдаг. Тэд үсний өнгө, биеийн өндөр, хийх дуртай зүйл зэрэг тодорхой зүйлээр өөрсдийгөө тодорхойлж байдаг. Энэ үе шатанд мэдрэмж, бодол, итгэл үнэмшил зэрэгтээ тулгуурлан аливаа зүйлийг хийсвэрлэн бодож төсөөлөх нь их. Энэ насанд найз нөхдийн болон түүнийг хүрээлэн байгаа насанд хүрэгчдийн харилцаа чухал. Эдгээрээс тэд зан үйлийн хэм хэмжээг мэдэх, өөртөө шүүмжлэлтэй хандах, хариуцлага хүлээх зэрэг чадварыг эзэмшиж байдаг. Түүнчлэн олуулаа хамтран ажиллах, суралцах, хийх дуртай зүйлээ хийж байх үедээ ч нийгэмшин төлөвшдөг. Харилцааны хувьд ижил хүйсийн харилцаа давамгайлна.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тэдэнд өөрсдийгөө илүү сайн ойлгох, нийгмийн амьдралыг судлан ойлгох, өөрсдийн соёл, зан заншилтай танилцахад нь дэмжин тусал. 2. Ур чадвараа хөгжүүлэх, чадавхыг нь дээшлүүлэх боломжийг олго (тэд юуг сайн хийдэг, юуг хийж чаддаг болохоо мэдэх, хүмүүст үнэлэгдэх, хүмүүсийг үнэлэх, эерэг харилцаа холбоог хэрхэн тогтоох, бусад хүмүүстэй хамтран ажиллах гэх мэт) 3. Гэр бүл, сургууль, олон нийтийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг олго. 4. Бие бялдрын хувьд идэвхтэй байх, өөрийнхөө шинэ чадваруудыг нээж илэрхийлэх нөхцөлийг бүрдүүл. 5. Бүтээлч байх, өөрөө юу бодож, хүсэж мөрөөдөж явдаг түүнийгээ илэрхийлэх боломжийг олго.
<p>12- 14 насны хүүхдийн хөгжлийн онцлог</p>		
<p>Бие бялдрын хөгжил</p>	<p>Энэ насанд бие бялдрын хувьд эрчтэй олон өөрчлөлтүүд гарна. Биеийн өндөр болон жин нэмэгдэнэ. Бэлгийн бойжилтын хоёрдогч шинж тэмдгүүд бүгд илэрч суга, умдагт үс ургаж хөвгүүдийн дуу хоолой бүдүүрч эхэлнэ. Охидод анхны сарын тэмдэг ирж эхэлнэ. Бэлгийн бойжилт, дотоод шүүрлийн булчирхайн үйл ажиллагаанаас шалтгаалан нүүр, нуруу орчмын арьсанд зарим өөрчлөлт гарна. Энэ өөрчлөлт нь хүүхдийн зан байдалд зарим талаар нөлөөлөх тал бий.</p> <p>Хөдөлгөөний эвсэл хөгжүүлэх нилээд төвөгтэй хэцүү дасгал, хөдөлгөөнийг эзэмших чадвартай болно. 13-14 насанд булчингийн агшилтын хурд дээд хэмжээнд хүрдэг бөгөөд хөдөлгөөний хурд хөгжих боломжоор бүрэн хангагддаг.</p>	<p>Нийгмийн ажилтан энэ насны хүүхдүүдийн бие бялдарт гарч буй өөрчлөлт, хөгжлийн талаар тэдэнд таниулан ярилцах, эрүүл мэнд болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар нээлттэй чөлөөтэй ярилцах боломжийг бүрдүүлж байх хэрэгтэй.</p> <p>12 наснаас эхлэн булчингийн сунгалтын хүчдэл эсэргүүцэл үзүүлдгийг анхаарч уян хатан чанар хөгжүүлэх дасгалыг түлхүү оруулах хэрэгтэй.</p> <p>Мөн хүч, хурд, гавшгай чанарыг хөгжүүлэхэд дасгалжуулагч багш анхаарна.</p>

<p>Танин мэдэхүйн хөгжил</p>	<p>Бие бялдрын хөгжлөө дагаад уураг тархины хөгжил мөн эрчимтэй явагдана. Тэд олон төрлийн зүйлийг сонирхон судлах чадвартай болно. Албан ёсны тодорхой баримтуудад тулгуурлан хийсвэрлэн нэгтгэн дүгнэж оюун дүгнэлт гаргах тодорхойлох чадвартай. Ийнхүү хийсвэр түвшинд сэтгэх болсноор хүүхдийн оюуны үйлдэл нь тухайн үеийн бодит байдлын хүрээнээс халин таамаглан сэтгэх боломжийг хүүхдэд олгодог. Ингэж таамаглан сэтгэх чадвар нь хийсвэрлэн сэтгэх чадвар түргэн хөгжсөнтэй холбоотой.</p>	<p>Энэхүү хийсвэрлэх сэтгэлгээг аажмаар бүтээлчээр сэтгэх үйл рүү залан чиглүүлнэ. Жишээ нь: Тухайн хүүхдийн хийж чадаж буй дасгал техникийг түүний чадвар боломжид тулгуурлан тодорхой агуулга илэрхийлсэн үзүүлбэрийг хэрхэн бэлтгэх талаар ярилцан чиглүүлэн хөгжүүлэх нь зүйтэй.</p>
<p>Нийгэмшгүйн хөгжил</p>	<p>Энэ насандаа хүүхдүүд өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй болж, бие даахыг илүү их хүснэ. Тэд зарим зүйл дээр эцэг эхтэйгээ зөвшилцөлгүйгээр бие даан шийдвэр гаргана. Тэдний өөртөө итгэх итгэл нь бусдыг хүлээн зөвшөөрөх, өөрөө бусдад хүлээн зөвшөөрөгдөхтэй нягт холбоотой.</p> <p>Найз нөхдийн холбоо харилцаа чухал байр суурийг эзлэх бөгөөд эцэг эх, гэр бүлийнхнээсээ илүү найз нөхөдтэйгээ цагийг өнгөрөөх нь ихэснэ. Хүсэл сонирхол, итгэл үнэмшил бий болоход найз нөхөд нь хүчтэй нөлөө үзүүлнэ.</p> <p>Бэлгийн бойжилтоос шалтгаалан бие бялдарт гарч буй өөрчлөлт нь зан үйлд нь ч нөлөөлдөг. Үүнээс шалтгаалан уурлах, бухимдах, баярлах, гомдох нь амархан болно.</p> <p>Тэд шинэ зүйлийг танин мэдэж турших их хүсэл тэмүүлэлтэй байдаг. Энэ байдлаас шалтгаалан зарим тохиолдолд эрсдэлтэй зан үйлийг туршиж үзэх магадлал өндөр. Тухайлбал тамхи татах, архи мансууруулах бодис хэрэглэн туршиж үзэж ч болно.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Өсвөр үеийнхнийг бие бялдрын хувьд идэвхтэй байлгах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Зохион байгуулж буй үйл ажиллагаа бүр нь тэдний хүсэл сонирхол, санал, санаачилгад тулгуурлан аль болох урам зоригтойгоор татагдан оролцох, төвлөрөх нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран зохион байгуулаарай. 2. Өсвөр үеийнхэнд оюуны шинэ чадвараа ашиглах, асуудлыг бие даан эсвэл бүлгээр шийдвэрлэх боломжийг олгох нь чухал. 3. Тэдэнд төсөөлөл, хийсвэрлэлээ хөгжүүлэхэд нь туслан тодорхой сэдвээр үлгэр, түүх зохиолгон түүнийгээ илэрхийлэх гэх мэт аргуудыг ашиглах нь үр дүнтэй. 4. Тодорхой сэдвээр хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэн өөрсдийн санаа бодлыг хамгаалах, бусдын санаа бодлыг сонсох, хүндэтгэх, тэднээс суралцах зэргээр ур чадвараа хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь чухал. 5. Соёл, зан заншил, бусад соёлтой танилцан судлах боломжийг олгох танилцан судлах 6. Насанд хүрэгчид болон бусдын зүгээс тэдэнд гарч буй өөрчлөлт хөгжлийг хүндэтгэн хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

15- 18 насны хүүхдийн хөгжлийн онцлог

<p>Бие бялдрын хөгжил</p>	<p>Бие бялдрын хувьд өсөлт хөгжилт нь жигдэрч насанд хүрсэн хүний ерөнхий шинж бүрдэнэ. Хөдөлгөөний эвсэл тогтоно. Булчингийн жин нэмэгдэж зүрх судас, мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаа тогтворжиж хурд, хүч шаардсан дасгал хөдөлгөөнийг хийх чадвартай болсон байдаг. Сэтгэлийн хөдөлгөөнөө барих, хянан жолоодох чадвар харьцангуй сайжирна. Бэлгийн бойжилт эрчимтэй явагдана.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тэдэнд өөрсдийн зан төлөв, үүрэг хариуцлагаа ухаарах, хандлагаа өөрчлөх, бусадтай эерэг харилцаа холбоо тогтоох, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх боломжийг сургалтаар дамжуулан олгоно. 2. Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр тэдэнд нийгмийн хариуцлага, шударга байдал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, олон нийтийн хандлагад нөлөөлөх зэрэг олон чадварыг олж авах нөхцөл бүрдэнэ. 3. Сургалт төслөөр дамжуулан тэдэнд эсрэг хүйсийнхээ хүмүүстэй ярилцах, тэдний биеэ авч явах байдлын талаарх ойлголт, хандлагад нөлөөлөх замаар бэлгийн боловсрол олгох, гэр бүл төлөвлөлтийн талаар эерэг төсөөлөл, сэтгэлгээтэй болоход нь тусална. 4. Өөрийн өмнө тодорхой зорилго дэвшүүлэх, зорилгодоо хүрэх алхмуудыг төлөвлөх, асуудал бэрхшээлийг хэрхэн эергээр шийдвэрлэх, цагийн зөв менежменттэй, шийдвэр гаргах зэрэг насанд хүрэгчдэд шаардлагатай ур чадваруудыг хөгжүүлэх зэргээр ирээдүйд бэлтгэх боломжийг олго.
<p>Танин мэдэхүйн хөгжил</p>	<p>Энэ нас нь хүүхэд наснаас насанд хүрэх шилжилтийн үе юм. Өөрийн ухамсар, зан төлөв төлөвшин тогтсоноор ёс суртахууны үнэт зүйлс, итгэл үнэмшил бий болоход нөлөөлнө. Нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож өөрийн байр сууринаас шүүмжлэлтэй ханддаг болно. Түүнчлэн өөрт хэрэгцээтэй мэдээллийг эрж хайх, бусдад санаа тавих, ирээдүйн амьдралдаа санаа зовох, мэргэжил сонгох гэх мэт олон чухал хэрэгцээнүүд гарч эхэлнэ. Уураг тархины хөгжил бүрэн хөгжөөгүй байдаг. Ялангуяа төлөвлөх, аливаа үйлдлийн үр дагаврыг урьдчилан бодох тархины өмнөд хэсгийн хөгжил гүйцээгүй байна. Тиймээс бие даан өөрийн гаргасан шийдвэр ямар эрсдэл, үр дагавартай байхыг нарийн сайн ухаарч ойлгож чаддаггүй.</p>	

Энэ насны эхэн үед хүүхэд залуучууд өөрсдийгөө өнгөрсөн, одоо, ирээдүйд төсөөлөх чадвартай болсон байна. Тэд бие даасан байдлаа үргэлж эрэлхийлнэ. Энэ насныхан “Би хэн бэ?”, “Би юунд итгэдэг вэ?”, “Би амьдралаас юу хүсэж байна вэ?” гэх зэргээр өөрийн дотоод ертөнц рүү илүү их анхаарч өөрийн бие хүнийг бүтээхийг эрмэлзэж байдаг. Мөн тэдэнд харьяалагдах хэрэгцээ маш их байна. Мөн тэд үе тэнгийнхэндээ хүлээн зөвшөөрөгдөж хамт олны нэгэн салшгүй хэсэг гэдгээ мэдрэх нь чухал.

Сэтгэлийн хөдөлгөөний талаас ялимгүй зүйлд уурлан уцаарлаж, тогтворгүй болно. Энэ нь өөрийгөө хэнд ч хэрэггүй болсон мэтээр бодох, төсөөлөх, бүтэлгүйтвэл өөрийгөө шүүмжлэн буруутгах байдал гаргадаг. Энэ насныхан эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хувьд үерхэл нөхөрлөлд өөрсдийн итгэл, үнэмшилд тулгуурлан чин сэтгэлээсээ ханддаг. Тэдний найз нөхдийн хүрээлэл улам нэмэгдэж найз нөхдөө сонгохдоо илүү сонголттой болсон байна.

СЭДЭВ 3.

ХҮЧИРХИЙЛЭЛ, ҮЛ ХАЙХРАХ БАЙДЛЫН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хүүхдийн нас, хөгжлийн онцлог нь тэднийг хүчирхийлэлд өртөх эрсдэлд шууд нөлөө үзүүлдэг. Хүүхдийн нас хэдий чинээ бага байх, түүнчлэн хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байх нь хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх эрсдэл өндөр байдаг. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хүүхдийн хөгжилд хүчирхийлэл ямар сөрөг нөлөөллийг үзүүлдэг талаар судлан мэдэх нь хамгаалал, тусламж шаардлагатай хүүхдийг илрүүлэх, тэднийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, ялангуяа хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд нөлөөлдөг.

6 - 12 насны хүүхдийн хэвийн хөгжилд хүчирхийлэл, зүй бус харьцааны үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Хэрүүл маргаан, хүчирхийллийн харилцаа ноёлсон гэр бүлийн орчин нь энэ насны хүүхдийн ерөнхий хөгжилд сөргөөр нөлөөлдөг. Хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртсөн энэ насны хүүхдүүд хэрэгцээтэй үедээ бусдаас тусламж хүсдэггүй. Учир нь хүнээс тусламж авах нь боломжгүй зүйл, тусламж хүсэх нь сул доройн шинж гэж тэд өөрсдийн амьдралаас сурсан байдаг².

Эдгээр хүүхдүүдэд ихэвчлэн дараах шинж тэмдэг илэрдэг.

Сэтгэлзүйн хувьд:

- Өөртөө итгэх, өөрийгөө үнэлэх үнэлэмж сул,
- Бусдад итгэдэггүй,
- Аливаа зүйлд анхаарал төвлөрөх нь муу,
- Бусдын нөлөөнд амархан ордог, өөрийгөө удирдах чадвар сул,
- Зориггүй, аймхай,
- Өөрийгөө бусдын өмнө сул дорой, хүчгүй, ямар ч чадваргүй гэж үнэлэх,

2 С. Энхтуяа. Хүүхэд хамгааллын үндэс. Улаанбаатар 2009 он

- Байнгын сэтгэл зовнилттой,
- Өөрийгөө хянах чадвар сул,

Нийгэмшихүйн хувьд:

- Бусадтай төдий л нийтэч биш, тусгаарлагдмал, зожиг ганцаардмал,
- Бусад хүмүүс түүнийг хэрхэн дүгнэж байгаа бол, хэрхэн хүлээн авах бол, өөрийгөө бусдын төсөөлж байсанд хүрэхгүй байх вий гэж дотроо айж, түгших, ичих мэдрэмж давамгайлна,
- Зарим хүүхдийн хувьд түрэмгий догшин зан авир гаргаж бусдыг хянахыг оролдоно,
- Өөрийн үзэл бодлыг барагтай бол илэрхийлдэггүй,
- Эхэлсэн зүйлээ бүтээлчээр дуусгах чадвар сул,
- Ямар нэгэн бэрхшээл тохиолдоход даван туулах сэтгэлийн тэнхээ бага, амархан бууж өгдөг,

Эдгээр сэтгэлзүйн тавгүй байдал, нийгэмшихүйн саад бэрхшээлээсээ болоод хүүхдийн зан авир ууртай, түрэмгий, нийгмийн эсрэг хандлагатай хувь хүн болж төлөвших нөгөө талаар бусдаас тусламж дэмжлэг хүсэх, хүлээн авах чадвар сул дорой нэгэн болоход нөлөөлдөг байна.

Өсвөр насны хүүхдийн хөгжилд хүчирхийлэл, үл хайхрах байдал хэрхэн нөлөөлөх вэ?

Хүүхдийн хөгжлийн энэ хурдацтай өөрчлөлтийн үед хүүхэд хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртсөн тохиолдолд сургууль завсардах, гэр орноосоо дайжих нь бий.

Сэтгэлзүйн хувьд:

- Сэтгэлийн айдас түгшүүртэй,
- Өөрсдийгөө хэнд ч хэрэггүй, хэн ч түүний төлөө санаа тавьдаггүй гэсэн бодол мэдрэмжтэй,
- Аливаа зүйлийг сонирхох сонирхолгүй,
- Хэл яриа, үйлдэл хөдөлгөөн нь удааширна,
- Өөрийгөө хянах чадвар сул,
- Сэтгэл тогтворгүй,
- Сэтгэл гутралд орох,
- Ганцаараа зовж шаналж байгаа мэт сэтгэгдэл төрөх,
- Амиа хорлох тухай бодох, оролдлого хийхийг завдах,

Нийгэмшихүйн хувьд:

- Зожиг, ганцаардмал болох,
- Бусдад итгэх итгэл алдрах,
- Эрсдэлтэй зүйл хийх, буруу нөлөөнд автах, гэмт хэрэг төвөгт өртөх,
- Догшин ширүүн авирлах,
- Архи тамхи, мансууруулах бодис хэрэглэх,
- Уур уцаартай болох,
- Эцэг эх, насанд хүрэгчдийн үгийг үл дагах,
- Найз нөхөд, үе тэнгийнхэндээ илүү итгэж найдах,
- Аливаа асуудлыг хүчирхийллийн аргаар шийдэхийг оролдох,
- Охид ялангуяа болзооны үеийн хүчинд өртөх эрсдэлтэй. Үүнээс БЗХӨ өртөх, эрт жирэмслэх зэрэг сөрөг үр дагаварт өртдөг.

Хүчирхийлэл, үл хайхрах байдал хүүхдийн сэтгэлзүй болон нийгэмшихүйд хэрхэн нөлөөлдөг, ямар шинж тэмдэг илэрдэг талаар товч танилцууллаа.

СЭДЭВ 4.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК СУРГАЛТЫГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ НЬ

Сургалтад хамрагдаж буй хүүхдүүдийг хүчирхийлэл, дарамт, зүй бус харьцаанд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан дараах арга хэмжээг авах шаардлагатай:

Урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хүүхдийн эрхийн аливаа зөрчлийн улмаас тэднийг эмзэг байдал, эрсдэлт нөхцөлд оруулах, оруулж болзошгүй шалтгаан нөхцөлийг тодруулан түүнийг арилгах, бууруулах үйл ажиллагаанууд багтана.

Хүүхдийг эрсдэлд оруулж болзошгүй шалтгаан нөхцөлүүд нь:

- Хүүхдүүд эрхээ мэдэхгүй, ойлгохгүй байсны улмаас хүүхдийн эрхийн зөрчлийг танихгүй байх,

- Хүүхэдтэй ажилладаг ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн эрхийн талаарх ойлголт мэдлэг, хандлага хангалтгүй, хүүхдийн эрхэд суурилсан аргагүй дутмаг байх,

Иймд нийгмийн ажилтан гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж хүүхдийн эрхийг таниулах, ойлгуулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх нээлттэй орчин бий болгохын тулд ямар үйл ажиллагааг хэнд зориулан хэрэгжүүлэх шаардлагатай байгаагаа тодорхойлон хийгээрэй.

Сургалтад хамрагдагч хүүхдүүд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад, хамтран ажиллагч дасгалжуулагч багш, бусад ажилтнуудад зориулан нэн даруй хийх ажил нь:

- Хүүхдийн эрхийн чиглэлээр мэдээлэл өгөх, энэ чиглэлийн сургалтыг идэвхтэй оролцооны аргуудад тулгуурлан зохион байгуулах,
- Харилцааны чиглэлийн сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
- Хууль, эрхзүйн мэдээлэл өгөх,
- Хүүхдийн оролцооны талаарх мэдээллийг өгөх, оролцоог үнэлэх арга хэрэгслүүдийн талаар мэдээлэл өгөх,
- Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх, хүүхэдтэй харилцах эерэг арга туршлагаа хуваалцах үйл ажиллагааг тэдэнд тохирсон арга барилаар зохион байгуулна.

Хамгаалал, тусламж шаардлагатай хүүхдийг илрүүлэх

Сургалтын явцад хүчирхийлэл, дарамтад өртсөн байж болзошгүй нөхцөл байдлыг тандан ажиглаж оношлон илрүүлэх нь хамгаас чухал. Иймд хүүхдэд тулгамдаж буй асуудал бэрхшээл, хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхдийг хэрхэн илрүүлэх, хэрхэн оношлох, тэдэнтэй ярилцан мэдээлэл авах, ярилцлага хийх гэх мэт тодорхой ур чадварууд нийгмийн ажилтанд шаардлагатай.

Хүүхэд хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй үед тэдэнтэй хэрхэн ярилцах вэ?

- Хүүхдэд юу тохиолдсон, юу болсон талаар ярих дургүй, ярихыг хүсэхгүй болон айдастай байж болох учраас хүүхэдтэй ярилцах арга барилаа сайтар бодож сонгох хэрэгтэй.
- Нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш өөрсдөө маш тайван, энгийн байж тэдэнд чинь сэтгэлээсээ тусалж чадна гэдгээ ойлгуулах нь чухал,
- Танд хангалттай цаг байгаа гэдэгт итгэлтэй байж, хэн нэгэн ярилцлагад

- саад болохгүй яриаг дундуур нь таслахгүй байх газрыг сонго,
- Хүүхдэд аль болох бодитой хандах ба таны ажигласан шинжүүдийн талаар хүүхдээс тодруулан асуу (асуухдаа хэт их тулгахгүй, яриулахыг хүчлэхгүй байхад анхаарна)
 - Сайн сонсогч байх нь хүүхдэд итгэл төрүүлж, тэдний аюулгүй байдал, сайн сайхны тулд гэдгээ чин сэтгэлээсээ харуул,

Хүчирхийлэл үл хайхрах байдалд өртсөн тухайгаа хүүхэд хэрхэн илчилдэг бэ? Хүүхэд хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртсөн тухайгаа шууд, зарим үед энэ тухайгаа зурах, бичих болон далд утгаар хэлэх зэргээр шууд бус замаар илэрхийлэх явдал бий.

Шууд илчлэх

Хүүхэд зарим үед хүчирхийлэл болон үл хайхрах явдалд өртсөн гэдгээ бусдад шууд хэлдэг. Хүүхэд өөрийнх нь ярьж байгаа зүйлд хэрхэн хандаж хүлээж авч байгааг харахын тулд яриагаа жижиг зүйлээс ч эхэлж болно. Судалгаанаас харахад хамгааллын үйлчилгээг үзүүлэхээс өмнө хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухайгаа маш олон удаа хүмүүст ярьсан байдаг байна.

Нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нарын аль аль нь хүчирхийлэл болон үл хайхрах байдлын талаар хүүхэд ярихад нь нээлттэй, ухаалгаар хандан, тэдэнд итгэж байгаагаа үг яриа, үйлдэл хөдөлгөөнөөрөө ойлгуулах ёстой.

Шууд бус байдлаар илчлэх

Зарим тохиолдолд хүүхэд хүчирхийлэл болон үл хайхрах байдалд өртсөн тухайгаа шууд хэлж чаддаггүй учраас ихэнхдээ харилцааны шууд бус аргыг ашигладаг. Энэ тохиолдолд тэдний гаргаж буй зан байдал, сэтгэл хөдлөлөө илэрхийлж байгаа байдал, зурсан зургаараа, бичсэн зүйл, гадаад байдал, бусадтай харилцаж буй харилцаагаараа дамжуулах гэх зэргээр ямар нэгэн байдлаар илэрхийлдэг. Түүнчлэн бусадтай харилцах явцдаа тэдэнтэй ярилцаж байгаа, асуулт асууж байгаа байдлаараа ч илэрхийлэх нь бий. Энэ нь хүүхэд өөрийнх нь сэтгэлийг зовоож буй зүйлийн талаар ярихдаа шууд бусаар тойруулж хэлэх, тодорхой нөхцөл заах (жишээ нь бусад хүнд хэлэхгүй гэдэг амлалт авах) байдлаар харилцан тусламж авахыг хүсдэг байна. Иймд тэдэнтэй харилцах явцдаа хэлж ярьж байгаа зүйл, үгийн сонголт, биеийн хэлэмж, нүүр царай, сэтгэлийн хөдөлгөөнийг нарийн гярхай ажиглаарай.

Хүүхэд хүчирхийлэл болон үл хайхрах явдлыг илчлэх үед Та:

Сандралгүй, тайван сонс

Өөрийг нь ярьж байх үед сандрахгүй тайван байхыг тань хараад өөрт нь туслах боломжтой гэдгийг мэдэрч тэдэнд итгэл төрдөг. Хүүхдийн яриаг таслалгүй, шүүж цэгнэлгүй, чин сэтгэлээсээ сонсон хүлээн авах нь зөвхөн хүүхдэд ярих боломж олгоод зогсохгүй, түүнд тохиолдсон асуудал нь хүнд ярьж ойлгуулах, шийдэх боломжтой асуудал гэдгийг ойлгоход нь тусалдаг. Хүчирхийллийн улмаас хүүхдэд бий болсон айдас, санаа зовнилт нь ярилцлагад саад болж болзошгүй тул тэднийг ярьж байх үед тасралтгүй ширтэх, яриаг таслах, биеийн тодорхой хэсгийг харах, анхаарлаа өөр зүйлд хандуулах зэрэг үйлдлийг бүү хийгээрэй.

Аажим аажмаар асуудал руу ойрт, бүү яар

Хүүхэд асуудлынхаа талаар ярих үед танд хэвийн бус мэдрэмж төрөхөөс гадна юуг хийх талаараа төдийлөн итгэлгүй байх явдал ихээхэн тохиолддог. Энэ үед яаран сантран маш олон асуултыг зэрэг асуух тохиолдол байдаг. Иймээс яарах хэрэггүй. Болсон явдлын талаар арай илүү зүйл хэлж өгч чадах уу? эсвэл чамд юу тохиолдсон талаараа дэлгэрэнгүй ярихгүй юу гэх мэт энгийн асуултаас яриагаа эхлэх нь тохиромжтой.

Ямар нэг буруу зүйл хийгээгүй гэдэгт тэднийг итгүүлэн тайвшруул

Хүүхдээс асууж буй аливаа асуулт нь хүүхдийн санаа бодолд айдас түгшүүрийг хамтад нь авчирдаг. “Яагаад” гэсэн асуултыг тавихаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Учир нь “Яагаад” гэдэг асуулт нь тухайн үйлчлүүлэгчид өөрөө буруутай мэт далд мэдрэмжийг төрүүлдэг. Жишээ нь “Яагаад тэр чамайг цохисон бэ?” гэж асуух нь хүүхдэд ямар нэгэн зүйл буруу хийсэн учраас цохиулсан гэсэн санаагаар ойлгогдож хүүхэд энэ асуудлаар дахин ярихгүй байх, дургүйцлийг нь төрүүлдэг.

Тэднийг дэмжиж туслахад бэлэн гэдгээ илэрхийл

Хүчирхийлэл болон өөрт тулгамдсан асуудлын талаар ярилцаж байх үед хүүхдэд бусдын дэмжлэг туслалцааг авах, сэтгэлзүйн хувьд тайвшрах, нийгмийн ажилтан болон багшид итгэх хэрэгцээ шаардлага ихээхэн чухал байдаг. Тэдэнд асуудал, бэрхшээлийнхээ талаар ярьж байгаа нь зөв зүйтэй үйлдэл гэдгийг тайлбарлан ойлгоход нь тусал. Жишээ нь:

- Чи бидэнтэй байхад аюулгүй,
- Энэ талаар надад итгэж ярьж байгаад баяртай байна
- Чи энэ байдлыг хэн нэгэнд хэлснээс болж хүнд байдалд орохгүй

- Энэ асуудлыг шийдэхэд туслах бусад хүмүүсийг мэднэ гэх мэтээр ярилц. Мэдээж таны өгч буй мэдээллүүд бодитой байх ёстой.

Зөвхөн чухал баримтуудыг цуглуул

Хүүхэд хүчирхийлэл ба үл хайхрах явдлыг илчилж байгаа бол энэ асуудлыг цаашид тодруулах зайлшгүй шаардлагатай. Хэрэв та хүчирхийлэл ба үл хайхрах явдал мөн гэдэгт итгэх хангалттай мэдээлэл авсан бол хүүхдийг дэмжин туслахад бэлэн гэдгээ харуулахын хажуугаар нэмэлт зүйл асууж тодруулахаа зогсоох хэрэгтэй болно. Ингээд хүүхэд хамгааллын хамтарсан баг, холбогдох ажилтнуудад мэдээлэл хүргэж холбон зуучилна.

Хүүхдэд үүний дараа юу хийх талаараа хэл

Хүчирхийллийг илчилсэн хүүхэд хүмүүс түүний талаар юу гэж бодож байгаа болон дараа нь юу болох талаар сэтгэл нь түгшин эмзэглэдэг. Гэхдээ тэдэнд аливаа амлалтыг өгөхөөс зайлсхийх хэрэгтэй. Хүүхдэд итгэл төрүүлж тайвшруулахдаа зөвхөн бодитой үйл ажиллагааны талаар л ярилц. Дараа дараагийн авах арга хэмжээ, үйл ажиллагаа ямар байх, хэн энэ үйл ажиллагаанд хэрхэн оролцох талаар хүүхэдтэй нээлттэй хэлэлцэх хэрэгтэй.

Хүүхэд хамгааллын ажилтанд мэдээлэх

Хүүхдийн мэдээллийг хүүхэд хамгааллын нийгмийн ажилтанд мэдээлэх хэрэгтэй ба тухайн ажилтан цаашид энэ асуудлыг гүнзгийрүүлэн судлан шаардлагатай арга хэмжээг авна.

Ярилцлагын тэмдэглэл хөтлөх

Хүчирхийлэл ба үл хайхрах байдлын талаар хүүхдийн хэлсэн ярьсан зүйлийг тэмдэглэж авах хэрэгтэй. Ингэхдээ аль болох хүүхдийн өөрийн ярьсан үгээр бичнэ. Хүүхдийн зурсан, бичсэн бүтээл ажлуудыг хадгална. Эдгээр мэдээллийг шаардлагатай бол хүүхэд хамгааллын ажилтан, цагдаагийн ажилтанд өгнө. Нийгмийн ажилтан та бүхэнд ярилцлагын тэмдэглэл хөтлөх маягыг санал болгон танилцуулж байна.

ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

ХБ-02 маягт

Огноо: Ярилцлага хийсэн газар:

Ярилцаж буй хүний нэр:

Хүүхэдтэй ямар хамаатай болох:

Ярилцлагын дугаар:

Ярилцлагын хэлбэр: биечлэн утсаар цахим шуудангаар

Ярилцлага эхэлсэн ___цаг ___мин

Үргэлжилсэн хугацаа: ___цаг ___мин ___сек

Ярилцлагын зорилго:

Ярилцлагын тэмдэглэл:

Ярилцлагын явцад нийгмийн ажилтанд төрсөн сэтгэгдэл:

Цаашид үзүүлэх шаардлагатай үйлчилгээ:

Ярилцлага өгөгчийн үзэж байгаагаар:

Нийгмийн ажилтны үзэж байгаагаар:

Дууссан: ___цаг ___мин

Ярилцлага хийж, тэмдэглэл хөтөлсөн хүний нэр, гарын үсэг: / /

Нөхөн сэргээх үйлчилгээ

Энэ үйлчилгээ нь хүчирхийлэл дарамтад өртөн бэрхшээлийг даван туулж байгаа хүүхдэд туслах, өөртөө болон бусдад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, одоогийн болон шинээр амьдрах орчин нөхцөлд нь дасан зохицох байдлыг дэмжихэд чиглэсэн үйлчилгээнүүдийг нийгмийн ажилтан дангаараа буюу бусад байгууллагууд, хүүхэд хамгааллын хамтарсан багаар, хүүхдүүд, тэдний гэр бүлийн гишүүдтэй хамтран төлөвлөж хэрэгжүүлнэ. “Нийгэмшүүлэх цирк” сургалт нь энэхүү нөхөн сэргээх үйлчилгээний нэгэн хэсэг юм. Иймд сургалтаа оролцогчдынхоо онцлогт тохируулан төлөвлөн хүргэх нь юу юунаас илүү чухал.

БҮЛЭГ VI.

“НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК” СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ



СЭДЭВ 1.

СУРГАЛТЫН ЗАРЧМУУД

Нийгэмшүүлэх циркийн сургалтын аргазүй нь олон жилийн практик туршлагаар улам бүр баяжсаар байна. Нийгэмшүүлэх циркийн зорилго нь:

Өсвөр, залуу үеийг циркийн урлагаар дамжуулан бие бялдар, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих замаар нийгмийн амьдралд оролцох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэдэг.

Энэ зорилгод хүрэхийн тулд дараах сургалтын зарчмуудыг баримтална.

Ачаалал өгөх зарчим

Сургалтын ачааллыг хөнгөнөөс хүнд рүү аажмаар нэмэгдүүлж байх ёстой боловч оролцогчдыг гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай. Ачааллыг гэнэт хурдацтайгаар өгөх биш харин аажмаар дасгал хөдөлгөөний техникийг хүндрүүлэн суралцагчдын бие махбодыг дасгана.

Давтамжтай байх зарчим

Сургалтаар эзэмшүүлэхээр зорьж буй дасгал, техник, хөдөлгөөнүүдийг тогтмол тодорхой хугацаанд давтан гүйцэтгэнэ. Давтамж нь оролцогчдын гүйцэтгэлийн түвшин, сургалтын мөчлөгөөс хамааран янз бүр байна.

Тодорхой цаг хугацаатай байх зарчим

Энэ нь тухайн дасгал хөдөлгөөнийг ямар хугацаанд хийж гүйцэтгэхийг илэрхийлэх хэмжүүр юм. Энэ нь оролцогчдын хувийн онцлог, чадвар, гүйцэтгэлийн түвшин зэргээс шалтгаалан ямар хугацаагаар хөтөлбөрт хамруулах, нэгж хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа ямар байх, ямар давтамжтайгаар гүйцэтгэл хийх зэргийг хослуулан авч үздэг.

Амрах ба нөхөн сэргэх боломж олгох зарчим

Нийгэмшүүлэх цирк нь оролцогчдоос бие физиологийн ачаалал, үйл ажиллагааны идэвхтэй хөдөлгөөнийг шаарддаг. Энэ утгаараа нэгж хичээлийн

явцад тэднийг тодорхой хугацаанд амраан, бие физиологийн хувьд нөхөн сэргэх боломжийг олгох ёстой. Нэгж хичээлийн явцад оролцогч ямар ачаалал авсан, хэр өрсөлдөөнтэй дасгал техник гүйцэтгэсэн, булчингийн гэмтлийг өдөөх дасгал хэр зэрэг хийсэн зэргээс шалтгаалан амраах хугацааг дасгалжуулагч, нийгмийн ажилтан мэдрэмжтэй хандан зохицуулна. Жишээлбэл: сургалтын аль шатанд амраах, амны цангаагаа тайлах боломжийг бүрдүүлэх, сунгалтын дасгал хийх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх зэргээр байж болно.

Сэтгэлзүйн тэнцвэрт байдлыг хангах

Дасгалжуулагч, нийгмийн ажилтнууд оролцогчдын сэтгэл санааны байдлыг ажиглан хянах шаардлагатай. Сургалтын явцад дасгал, нийгэмшүүлэх тоглоом зэргийг гүйцэтгэх явцад зарим оролцогч залхуурах, зарим нь хэт давамгай оролцох байдлыг гаргаж болох юм. Иймд сургалтад орохоос залхууран хойргошиж буй нэгнийг хэрхэн өдөөх, хэт эрч хүчтэй байгаа оролцогчийн тэнцвэрт байдлыг хэрхэн хангах вэ гэдэгт дасгалжуулагч, нийгмийн ажилтнууд мэдрэмжтэй хандах шаардлагатай. Нийгэмшүүлэх цирк сургалтын орчин нь сэтгэлзүйн хувьд стресст өртөх, стресс үүсгэх нөлөөллийг үүсгэх ёсгүй.

СЭДЭВ 2.

СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ

Сургалтыг амжилттай зохион байгуулах нэг үндсэн нөхцөл нь бэлтгэлийг сайтар хангах явдал юм. Бэлтгэл ажлын хүрээнд дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хамтран:

- Сургалтын хэрэгцээг үнэлнэ. Үүнд: сургалтын оролцогч хэн бэ? Тэдний хэрэгцээ, онцлог, үнэт зүйл, нийгмийн ур чадвар, хувь хүний чадвар ямар байна? Эдгээрт нөлөөлөх хувь хүний болон нийгмийн ямар асуудлууд байна вэ? бүлгийн бүтэц, хөгжлийн түвшин, харилцан холбоо хамаарал, бүлгийн уур амьсгал ямар байна? гэдгийг тодорхойлно.
- Төлөвлөсөн сургалтын зорилго, зорилтоо тодорхойлно.
- Хөтөлбөрийг оролцогчдын онцлогт тохируулан боловсруулна.
- Аюулгүй байдлыг хэрхэн хангах төлөвлөгөөг боловсруулна.

- Сургалтад хэрэглэх техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг шалган бэлтгэнэ.
- Дасгалжуулагч, нийгмийн ажилтан өөрсдийн хувийн хандлага, бүтээлч байдал, ур чадвар, харилцааны чадвар, сонирхол, суралцагчдыг сэдэлжүүлэх чадвар зэргээ ярилцан сургалтыг эхлүүлэхэд өөрсдөө бэлэн байна уу? гэдгээ урьдчилан тодорхойлох нь сургалтын агуулгыг чанартай төлөвлөн хэрэгжүүлэхэд нөлөөлдөг.

Сургалтын хэрэгцээг үнэлэх. Энэ нь бэлтгэл ажлын хүрээнд зайлшгүй хийх алхам бөгөөд сургалтыг амжилттай хэрэгжүүлэх үндэс болдог. Үүнд:

- Сургалт зохион байгуулахаар сонгосон бүлгийн онцлог хэрэгцээ чухам юу вэ?
- Тэдэнд тулгамдсан ямар нийтлэг асуудал байна?
- Оролцогчдын чадвар, чадамж ямар байгааг таних үндэс болно.

Нийгэмшүүлэх цирк сургалтын хэрэгцээг үнэлэхэд дараах аргуудыг ашиглаж болох юм.

- 1. Ярилцлага хийх:** Нийгэмшүүлэх циркийн сургалтад оролцох хүүхэд залуустай сургалтын өмнө урьдчилан ярилцлага хийснээр тухайн бүлгийн онцлог, тэд сургалтаас юуг хүсэн хүлээж байна гэх зэргээр илүү мэдээлэлтэй болох төдийгүй тэдэнтэй дотносох боломжийг дасгалжуулагч болон нийгмийн ажилтанд бий болгодог.
- 2. Ажиглах:** Сургалтыг зохион байгуулахаар сонгосон бүлгийн үйл ажиллагааг хөндлөнгөөс ажигласнаар хүүхдүүдийн чадвар, хоорондын харилцаа, багийн уур амьсгал, тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлыг ойлгох гэх мэтээр хэрэгцээг тодорхойлох боломжтой.

Иймд дасгалжуулагч болон нийгмийн ажилтнууд, бусад хамтран ажиллагч нар хамтдаа сургалтын оролцогчид хэн бэ? Тэд ямар онцлогтой вэ? Тэдэнд тохирсон сургалтын агуулга ямар байх вэ гэдэгт анхааран сургалтыг төлөвлөнө. Сургалтын агуулга нь оролцогч бүрт үр ашигтай, зорилгодоо хүрэхэд нь тусалдаг байхад чиглэгдэх учиртай. Тухайн хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, хөгжлөөс шалтгаалан циркийн тодорхой техник харилцан адилгүй нөлөөлдөг байна.

Хүснэгт 7

Насны бүлэг	Чадвар		
	Циркийн урлагийн чадвар	Хувь хүний хөгжил	Бие хүний хөгжил (нийгэмшил)
6-9 нас	<ul style="list-style-type: none"> - Алчуур, бөмбөгөөр жонглёрдох (нэг, хоёр, гурав ба түүнээс дээш тооны хэрэгсэл) - Гурван хүний оролцоотой пирамид хийх - Дээсээр наадах (1-3 оролцогч зэрэг дээсэнд үсрэх) - Алиалах 	<ul style="list-style-type: none"> - Хөдөлгөөний эвсэл сайжрах, - Нүдний хараа, хурд сайжрах, нэмэгдэх, - Орон зайн баримжаа сайжрах, - Анхаарал төвлөрөх, - Зорилготой болох - Тууштай байх - Урам зориг нэмэгдэх - Хошин шогийн мэдрэмж сайжрах, - Өөрийгөө илэрхийлэх - Өөртөө итгэх - Үүрэг хариуцлагын мэдрэмж дээшлэх - Ариун цэвэр сахих - Болзошгүй аюул ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах, 	<ul style="list-style-type: none"> - Найзлан нөхөрлөх - Ээнэгшин дасах, - Багаар ажиллах, - Бие биеэ хүндлэх, мэдрэх, ойлгон дэмжих,
10-14 нас	<ul style="list-style-type: none"> - Цэцэгт саваа, таваг, цагирагаар жонглёрдох, (нэг, хоёр, гурав ба түүнээс дээш тооны хэрэгсэл ашиглах) - 3-10 хүртэлх хүний оролцоотой пирамид хийх, - Дээсээр наадах (давхар дээсдэх, дээсэн дотор үсрэх, өнхрөх) - Дан хэрчим (катюшка) дээр тэнцвэр олох - Алиалах 	<ul style="list-style-type: none"> - Хараа, хурд сайжрах - Зорилготой болох, - Тэвчээр хатуужилтай болох, - Анхаарал төвлөрөх чадвар дээшлэх, - Нарийн мэдрэмж хөгжих, - Хошин шогийн мэдрэмж сайжрах Өөрөөрөө бахархах, - Өөртөө итгэх, - Өөрийгөө илтгэн харуулах - Үүрэг хариуцлагын мэдрэмж дээшлэх, - Ариун цэвэр сахих, - Болзошгүй аюул ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах, 	<ul style="list-style-type: none"> - Найзлан нөхөрлөх - Ээнэгшин дасах, - Багаар ажиллах, - Бие биеэ хүндлэх, мэдрэх, ойлгон дэмжих,

<p>15-18 нас</p>	<ul style="list-style-type: none"> - Дамар, буловоор жонглёрдох (нэг, хоёр, гурав ба түүнээс дээш тооны хэрэгсэл ашиглах) - 3-15 хүртэлх хүний оролцоотой пирамид хийх, - Дээсээр наадах (1-2 давхар үүсгэн үсрэх, мэлхий үсрэх, сунилттай үсрэх) - 2-3 давхар хэрчим дээр тэнцэх, - 2-3 давхар хэрчим дээр тэнцэн жонглёрдох - Дан дугуйн (моноцикл) дээр тэнцэх, - Дан дугуйн дээр тэнцэн жонглёрдох - Модон хөлөн дээр тэнцвэр олох - Алиалах 	<ul style="list-style-type: none"> - Анхаарлын төвлөрөлт, хуваарилалт сайжрах, - Өөртөө итгэх, - Хошин шогийн мэдрэмж сайжрах - Ариун цэвэр сахих - Тэвчээртэй, тууштай байх - Аливаа зүйлд хянуур, болгоомжтой хандах - Өөрийгөө илтгэн харуулах - Үүрэг хариуцлагын мэдрэмж дээшлэх Асуудал, бэрхшээлийг даван туулах - Болзошгүй аюул ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах, 	<ul style="list-style-type: none"> - Бие биеэ хүндлэх, мэдрэх, ойлгох, - Найзлан нөхөрлөх - Ээнэгшин дасах, - Багаар ажиллах
------------------	---	---	--

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд сургалтад оролцогчдын онцлогт тохируулан агуулгыг төлөвлөхдөө анхаарах зүйл нь:

Хичээлийн агуулгын хувьд:

- Циркийн ур чадварыг эзэмшүүлэхдээ бүлэг бүрт ялгаатай зүйлийг заах уу? эсвэл бүгдэд ижил зүйл заах уу? гэдгийг урьдчилан сайтар төлөвлөсөн байна. Үүнд:

Сургалтад оролцогчдын нас, хөгжлийн онцлог, чадвар, сонирхлоос шалтгаалан зарим хүүхдүүдэд жонглёрын төрлийг заахдаа заримд нь дамар, заримд нь алчуур, бөмбөгөөр хэрхэн жонглёрдохыг зааж байхад нөгөө нэг хэсэгт нь тэнцвэрийн төрөл тухайлбал катюшка дээр тэнцэх, нэг дугуйт дээр тэнцэх, өөр хэсэгт нь сунгалтын дасгал гэх мэтээр бүлэг бүрт ялгаатай төрөл техникүүдийг заана.

Харин сургалтад оролцогчдын нас, хөгжлийн онцлог, чадвар, сонирхол зэргийг харгалзахгүйгээр бүгд оролцон хийж болох бие халаалтын дасгал, анхаарал төвлөрүүлэх дасгал, орон зайн баримжаа олгох, нийгэмшүүлэх дасгал, тоглоом гэх зэрэг дасгал техникууд байж болох юм.

Сургалтад циркийн хэрэгслийг бэлтгэх:

Циркийн хэрэгсэл бэлтгэх нь сургалтын зорилго, дасгалжуулагч багшийн сонголт, төсөв санхүү гэх мэт зүйлсээс шууд хамааралтай. Гэвч шалны зөөлөвч матрас, жонглёрын төрөл бүрийн хэрэгсэл, анхны тусламжийн цүнх зэргийн нэн түрүүнд бэлтгэнэ. Сургалтын үед оролцогчид өөрсдийн гараар зарим хэрэгслийг урлаж болно. Сургалтын өмнө бүх хэрэгслийг сайтар шалгах хэрэгтэй бөгөөд хамгийн түрүүнд аюулгүй байх нь чухал. Оролцогчдыг сургалтын эхний өдрөөс л үндсэн хэрэгслүүдээр хангасан байх хэрэгтэй.

Дараах материалын жагсаалтыг 15 орчим хүүхэдтэй бүлгээр тооцоолсон:

1. Шалны зөөлөвч матрас
2. Бөмбөг 30 ширхэг (төрөл ба тоо хэмжээний хувьд олон байх)
3. Дамар 6-8 ширхэг
4. Жонглёрын саваа 6 ширхэг (зууван ба цэцгэн)
5. Анхны тусламжийн цүнх (халдваргүйжүүлэлтийн бодис, бигнүүр, боолтын материал, хүйтэн жин гэх мэт)

Оролцогчдын хүсэл сонирхол, төсвөөс шалтгаалан дараах зүйлсийг нэмж болно:

Жонглёрын хэрэгсэл:

- Булов буюу муна 6-12 ширхэг
- Цагираг 6-12 ширхэг
- Таваг 3-6 ширхэг
- Жонглёрын алчуур 6-12 ширхэг

Туслах хэрэгсэл

- Дээс тоглох олс – 3 - 4 ширхэг (урт, богино)
- Катюшка – 1-2 ширхэг
- Модон хөл өвдөгний хамгаалалт тус бүр 2- 4 хос
- Моносикл буюу нэг дугуйт -2 ширхэг
- Багаж хэрэгслийн хайрцаг – 1 ширхэг.

Бусад:

Оролцогчдыг бүртгэх бүртгэлийн хуудас, үнэлгээний асуулга зэргийг урьдчилан бэлтгэн хэвлэсэн байна. Түүнчлэн дасгал тоглоомын заавар, сургалтад хэрэглэгдэх бичиг хэргийн материал дэвтэр үзэг, дэлгэц цаас, цаасны цавуу, хайч зэргийг урьдчилан бэлтгэнэ.

Сургалтын хөтөлбөр боловсруулах.

Нийгэмшүүлэх цирк сургалт нь ихэвчлэн нийт 1-15 долоо хоног үргэлжлэх бөгөөд дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 8

	Бие махбодын хөгжлийг дэмжих	Нийгэмшлийг дэмжих
БЛОК 1: Эхний 1-4 долоо хоног	<p>Циркийн үндсэн техникүүдийг танилцуулна.</p> <p>Дөрвөн долоо хоногийн туршид үргэлжлэх сургалт нь оролцогчдод циркийн үндсэн техникүүдийг танилцуулах зорилготой. Сургалтын явц дахь үйл ажиллагаа, дасгал техникүүд нь оролцогчдыг шинэ сорилт бэрхшээлтэй учруулах бөгөөд дасгалжуулагчид энэ тал дээр мэдрэмжтэй байх шаардлагатай. Дасгалжуулагчид эхний уулзалтуудаар оролцогчдын бие махбодын чадварыг үнэлэх боломжтой болно</p>	<p>Суралцагчдыг бүлэгт дасан зохицоход дэмжлэг үзүүлэх бүлэг бүрдүүлэхэд анхаарна</p> <p>Оролцогчдыг сургалтад урьж оролцуулан нэгэн бүлэг үүсгэж тэднийг бие биедээ харилцан дэмжлэг үзүүлэхэд тусална. Дасгалжуулагч, нийгмийн ажилтнууд эхний уулзалтуудаар бүлэг, түүний бүтэц, хэрэгцээг үнэлэх боломжийг олгодог. Эхний долоо хоногуудад оролцогчидтой хамтран сургалтын явцад баримтлах дүрмийг хэлэлцэн батална.</p>
БЛОК 2: 5 – 10 дахь долоо хоног	<p>Циркийн илүү нарийн төвөгтэй техникүүдийг зааж сургана.</p> <p>Сургалтын хоёр дахь хэсэг нь 6 долоо хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд оролцогчид циркийн дасгал техникүүдээс илүү ихийг сурталчлан заах зорилготой. Дасгалжуулагчид төрөл бүрийн арга барилыг ашиглан дасгал техникийг гүнзгийрүүлж эхэлснээр оролцогчид бие биедээ өмнөхөөсөө илүү их итгэх суурийг тавьдаг. Жишээ нь: Циркийн пирамид овоолго хийх Дасгалжуулагчид бүтээлч дасгал, театрын аргыг ашиглахад илүү анхаарах хэрэгтэй.</p>	<p>Бүлгийн нэгдмэл байдлыг дэмжин хөгжүүлнэ.</p> <p>Энэ хоёр дахь блок нь бүлгийн эв нэгдэл, нэгдмэл байдлыг дэмжих дасгал, тоглоомыг түлхүү хэрэглэнэ. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд нийгмийн ажилтан, дасгалжуулагчид аль болох оролцогчдыг хоорондоо харилцах, бие биеэ дэмжих, итгэл үнэмшил бий болгох, бие биеэ ойлгон дэмжихэд чиглэсэн дасгал, тоглоомыг идэвхжүүлнэ.</p>

БЛОК 3: 11 - 13 дахь долоо хоног	Циркийн тодорхой нэг техникт төвлөрөх	Бүлгийн үйл явцыг эрчимжүүлнэ
	Энэ хугацаанд дасгалжуулагчид оролцогчдыг циркийн үзүүлэх тоглолтод бэлтгэхэд чиглэнэ. Дасгалжуулагчид үзүүлбэрийн бүтэц, дараалал, цаг, хөтөлбөр боловсруулна	Энэ хугацаанд оролцогч бүрийг циркийн үзүүлэх тоглолтод хувь нэмрээ оруулах чадварыг хөгжүүлнэ. Үзүүлэх тоглолтын бүтэц хөтөлбөрийг гаргахад оролцогчид дасгалжуулагч багш нартай хамтран ажиллах бөгөөд оролцогч бүрийн оролцоог хангахад анхаарна. Энэ үед нийгмийн ажилтан, дасгалжуулагчид оролцогчдын шийдвэр гаргах, сонголт хийх, зөрчлийг зохицуулах ур чадварыг хөгжүүлэхэд сургалтын үйл явцыг чиглүүлнэ.
БЛОК 4: 14 дэх долоо хоног	Сургалтын төгсгөл болон үзүүлэх тоглолтод бэлтгэх	Бүлгийн эв нэгдлийг бататгах
	Нэг долоо хоног үргэлжлэх сургалт нь сургалтын төгсгөл болон үзүүлэх тоглолт гэсэн үндсэн хоёр хэсгээс бүтнэ.	Бүлгийн гишүүдийн бие биедээ итгэх итгэлийг бэхжүүлэх, дэмжин туслах боломжийг бүрдүүлэх, үүрэг хариуцлагын мэдрэмжийг хөгжүүлэх, зоригжуулан дэмжихэд сургалтыг чиглүүлнэ.
БЛОК 5: 15 дахь долоо хоног	Сурч мэдсэн зүйлээ эргэн дүгнэх	Бүлгийн хөгжлийг дүгнэх
	Оролцогчид сургалтын туршид юу сурсан, ямар чадваруудыг эзэмшсэнээ дүгнэн хэлэлцэх хэсэг юм. Дасгалжуулагчид үзүүлэх тоглолтын бичлэг үзүүлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх гэх мэт аргуудыг ашиглан оролцогчдыг сурч мэдсэн зүйлээ үнэлэх, өөрийгөө дүгнэх ирээдүйн зорилгоо тодорхойлоход нь туслан чиглүүлнэ.	Сүүлчийн блок нь хувь хүн, бүлгийн гишүүд сургалтын туршид хэрхэн оролцож хөгжсөн, ямар туршлага хуримтлуулсан, юуг сурч мэдсэн зэргийг хэлэлцэн дүгнэлт хийхэд чиглэнэ. Мөн энэ хэлэлцүүлгээр бүлгийн гишүүдтэй дараагийн сургалтын талаар, цаашдын зорилгынх нь талаар мэдээллийг хуваалцахад голлон анхаарна.

Нийгэмшүүлэх цирк сургалтын хөтөлбөр боловсруулах аргачлал

Сургалтын ерөнхий төлөвлөлтийг хийсний дараагаар хичээлийн хөтөлбөрийг нарийвчлан боловсруулах хэрэгцээ гарна.

Жишээ: Та бүхэнд долоо хоногт 2-3 удаа 2 цагаар зохион байгуулагдах 15 долоо хоногийн сургалтын нэгдсэн хөтөлбөр загварыг танилцуулж байна. Орон нутгийн онцлог, оролцогчдын хэрэгцээ, онцлогт тохируулан өөрчлөн боловсруулах боломжтой.

Хүснэгт 9 Загвар:

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР		
Сургалтын ерөнхий зорилго: Жишээ нь: <ul style="list-style-type: none"> • Бүлэг бүрдүүлэх • Оролцогч ба нийт бүлгийн хоорондын харилцааг сайжруулах • Охид хөвгүүдийн хоорондын харилцааг сайжруулах • Оролцогчид өөрийн бие махбодоо мэдрэх, хянахад дэмжлэг үзүүлэх 		
Долоо хоног	Бие махбодын хөгжлийг дэмжих	Нийгэмшлийг дэмжих
БЛОК 1: Циркийн техникүүдийг танилцуулах (4 долоо хоног)		БЛОК 1: Бүлэг үүсгэх (4 долоо хоног)
1	Бүлэг бүрдүүлэхэд чиглэсэн циркийн дасгал, техникүүдийг хэрэглэнэ. <ul style="list-style-type: none"> • Оролцогчдын бие махбодын чадварыг үнэлнэ. • Оролцогчдод сорилт, бэрхшээл бүхий үйл ажиллагааг ашигла. Оролцогчдыг бие махбодын боломжийг танин мэдэх энэ асуудалд мэдрэмжтэй ханд 	<ul style="list-style-type: none"> • Оролцогчдыг сургалтад урин, харилцаа холбоо тогтоох, бие биеэ харилцан дэмжихэд туслана. • Бүлгийн бүтэц, хэрэгцээг үнэлэн. • Сургалтын явцад баримтлах дүрмийг хэлэлцэн батална.
2		
3		
4		
БЛОК 2: Циркийн илүү нарийн төвөгтэй техникүүдийг зааж сургах (6 долоо хоног)		БЛОК 2: Бүлгийн нэгдмэл байдлыг бий болгох. (6 долоо хоног)
5	Оролцогчдод циркийн техник арга барилыг зааж сургах, бүлгийн хөгжлийг дэмжих <ul style="list-style-type: none"> • Дасгал, техникүүдийг гүнзгийрүүлэх • Итгэл бий болгох, дэмжихэд чиглэсэн техник, дасгал ашиглах явдлыг эрчимжүүлэх • Бүтээлч байдлыг хөгжүүлэх, театрын аргыг ашиглах 	<ul style="list-style-type: none"> • Хувь хүний болон нийгмийн чадварыг хөгжүүлэх (жишээ нь: итгэл үнэмшил бий болгох) • Бүлгийн нөөцийг ашиглан нийгмийн дэмжлэг үзүүлэхэд сургах
6		
7		
8		
9		
10		
БЛОК 3: Циркийн тодорхой техникт төвлөрүүлэх (3 долоо хоног)		БЛОК 3: Бүлгийн үйл явцыг эрчимжүүлэх (3 долоо хоног)

11	<ul style="list-style-type: none"> Дасгал техникийн гүйцэтгэлийг чанаржуулан чадваржуулах Сургалтын туршид сурсан дасгал, техникүүдийг сэргээн бататгах 	<ul style="list-style-type: none"> Бүлгийн үйл ажиллагааг дэмжин хувь нэмэр оруулах чадвар, шийдвэр гаргах чадварыг дэмжин хөгжүүлэх.
12		
13		
14	БЛОК 4: сургалтын төгсгөл, үзүүлэх тоглолт хийх	
БЛОК 5: Сургалтын үнэлгээ		
15	<ul style="list-style-type: none"> Сурсан зүйлээ эргэн дүгнэх Гүйцэтгэлийг эргэн үнэлэх 	<ul style="list-style-type: none"> Хувийн болон бүлгийн ахиц дэвшлийг үнэлнэ. Ирээдүйн зорилгын талаар хэлэлцэнэ.

Сургалтын энэхүү ерөнхий төлөвлөлтөд үндэслэн сургалтын нарийвчилсан төлөвлөгөөг дасгалжуулагч, нийгмийн ажилтнууд хамтран боловсруулна.

Загвар.

Сургалтын нарийвчилсан төлөвлөгөө					
Сургалтын дугаар #2		Үргэлжлэх хугацаа: 3 цаг		Оролцогчдын тоо: Нийт: 21	
Дасгалжуулагч багшийн нэр:		Нийгмийн ажилтны нэр:		Бусад:	
Сургалтын зорилго: Оролцогчдын талаарх олон нийтийн ойлголт болон олон нийтийн талаарх оролцогчийн ойлголтыг өөрчлөх					
Сургалтын техник ур чадварыг дэмжих			Суралцагчдын нийгэмшлийг дэмжих		
<ul style="list-style-type: none"> Бие халалтын дасгалыг хийж хэвшүүлэх Циркийн пирамид, жонглёрын төрлүүдийг судлах. 			<ul style="list-style-type: none"> Бүлгийн гишүүдийн дунд шинэ харилцаа холбоо үүсгэх. (итгэлцлийн тоглоомууд тоглох) Хөгжилтэй орчин бүрдүүлэх, амжилтыг хөгжүүлэх замаар бүлгийг сэдэлжүүлэх 		
ХУВААРЬ					
Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах хүн	Шаардагдах материал	Үйл ажиллагаа биелсэн эсэх	
				Тийм	Үгүй
10 мин	Оролцогчидтой мэндчилэх	бүгд	Сэтгэл санааг бэлтгэх	√	
5 мин	Сургалтын агуулгыг танилцуулах	Н\А		√	
15 мин	Тоглоом: Дээшээ үсэр (тэднийг урамшуулан дэмжих нэр ашиглах)	Д\Б	шохой	√	

15 мин	Нийгэмшүүлэх тоглоом тоглох	Д\Б		√	
15 мин	Бие халаалтын дасгал	Д\Б	Зөөлөвч, матрасс	√	
20 мин	Багаар ажиллах дасгал, тоглоом	Н\А		√	
10 мин	Завсарлага	Бүгд	Цай, ус	√	
45 мин	Циркийн дасгал техникт суралцах: Жонглёр	Д\Б	Жонглёрын бөмбөг. Н\А цагийг хянана	√	
25 мин	Циркийн овоолго хийх дасгал.	Д\Б	Зөөлөвч матрасс, хийх пирамидын зураг		√
5 мин	Хэрэгслүүдээ хураах	Бүгд		√	
10 мин	Дүгнэлт ярилцлага:	Н\А		√	
5 мин	Хаалтын тойрог.	Д\Б	Урт олс	√	
Сургалтын үйл явцыг дүгнэх					
Ажиглалт, санал: Дасгалжуулагч, нийгмийн ажилтан хамтран тухайн сургалтын үйл явцыг дүгнэн ярилцана. Өөр өөрийн ажигласан зүйлс, амжилттай хийгдсэн алхмууд, бэрхшээл зэргийг ярилцан дараагийн хичээлээр аль хэсэгт арай түлхүү цаг зарцуулах, аль оролцогчийг илүү ажиглах зэргээ ярилцан дараагийн сургалтын зорилгыг дэвшүүлнэ.					
Дараагийн сургалтын зорилго:					

Сургалтын хөтөлбөр, хичээлийн төлөвлөгөөг боловсруулахдаа

Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнууд та бүхэнд сургалтын хөтөлбөр, хичээлийн нарийвчилсан төлөвлөгөөг хэрхэн боловсруулах талаар загвар жишээгээр танилцууллаа. Эдгээр нь зөвхөн жишээ бөгөөд та бүхэн өөр өөрийн зорилтот бүлэг, орон нутгийн онцлогт тохируулан хувирган боловсруулах боломжтой. Гэхдээ циркийн сургалтын бүтэц, элементүүдийг алдагдуулахгүй байхыг анхаарна уу?

Циркийн дасгал техникт сургах болон нийгэмшилтийг дэмжих үйл явц нь олон удаагийн уйгагүй оролдлого, хичээл зүтгэл шаарддаг тул ээлжит сургалтын төлөвлөгөө нь ерөнхийдөө ижил бүтэцтэй байдаг. Энэ бүтцийг хичээлийн төлөвлөлтийн загварт заавал тусгана. Үүнд:

1. Тойргийн журам;
2. Бие халаалтын дасгал хийх;
3. Нийгэмшүүлэх тоглоом тоглох;
4. Циркийн дасгал техникт суралцах;

5. Тайвшруулах дасгал;
6. Сургалтын дүгнэлт/ хаалтын ярилцлага хийх;

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудад бодит нөхцөл байдалд хүүхдүүдтэй, ажиллах ажлын үе шат бүрийг нарийвчлан хэрэглэгдэх аргыг танилцуулъя.

СЭДЭВ 3.

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

> Хичээл төлөвлөлтийг хэрэгжүүлэх үе шат

Сургалтын бэлтгэл

Сургалтын явцад бие бялдрыг хөгжүүлэх болон жүжигчилсэн тоглолт, бүлгээр тоглох тоглоомын зорилтыг урьдчилан тодорхойлсон байх хэрэгтэй. Бүлгээр тоглох тоглоомыг сонгохдоо хүүхдэд төрөл бүрийн ур чадвар, мэдрэмжийг төрүүлэхүйц байхад анхаарна.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр сургалтын үеэр явагдах үйл ажиллагаа тус бүрт ямар үүрэгтэй оролцох нь тодорхой байх ёстой. Сургалтыг удиран явуулж байгаа эсвэл туслах үүрэгтэйгээр ажиллаж байгаагаас үл хамааран оролцогч бүрийн оролцоог дэмжин идэвхжүүлэхэд анхаарал хандуулна.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр сургалт эхлэхээс 30 минутын өмнө уулзан тухайн өдрийн сургалтын хөтөлбөрийг дахин хэлэлцэж тухайн өдрийн сургалтын талаар ярилцан сургалтад бэлтгэнэ.

Оролцогчдыг сургалтад угтан авч мэндчилэх

Зорилт: Оролцогчдод тэднийг хүсэн хүлээж байсан шүү гэсэн сэтгэгдэл төрүүлэх. Ганцаараа болон бүлгээрээ халуун дотноор хүлээн авч, мэндчилэх хэвшил бий болгох. Бүлгээрээ ажиллаж байгаа үед ч хүүхэд бүрт намайг энд хүсэн хүлээж байсан юм байна, намайг сонирхож байна, намайг энэ байгаагаар маань хүлээн авч байна гэсэн сэтгэгдэл төрөхөөр хандах, харьцах хэрэгтэй.

Сургалтын энэ хэсэгт оролцогчдыг тойргоор зогсоон тухайн өдрийн сургалтын зорилго, хөтөлбөрийн талаар товч танилцуулан аюулгүй байдлыг хэрхэн хангах зааварчилгаа өгнө. Дасгалжуулагч багшийн дохиог хүлээн авах, дасгал, тоглоомын заавартай танилцах, санал дэвшүүлэх, бусдыг сонсох, хүндэтгэх зэрэгт тойргоор ажиллах журмыг танилцуулан хэвшил болгоно. Тойрог бол хүүхдүүдийн хувьд тоглоомын аргаар сурсан дасгал техникээ хэрэглэх хамгийн сайн арга юм.

> **Бие халаалтын дасгал:**

Зорилт:

Оролцогчдын хувьд: Тодорхой хөдөлгөөний эвсэл сурах, өөрийн бие бялдарын боломжийг судлах.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд: Оролцогчдын биеийн хөдөлгөөн, бие бялдарын нөөц, чадварыг ажиглана. Оролцогчидтой холбоо харилцаа тогтооно.

Өөрөө өөрийнхөө бие ялдартай дахин холбоо тогтоон мэдрэх нь зарим үед тийм ч амар байдаггүй. Ялангуяа эмзэг зовуурьтай дурсамжийн дараа бүр ч хэцүү байдаг.

Бие халаах нүүр хагарах дасгал нь бидэнд хүүхдийн биеийн хөдөлгөөнийг уншиж мэдрэх, тэдний сэтгэл санааны болон оюун ухааны байдлын талаар ойлголт авах, тэдний амьдрал болон бусад хүмүүст хандах хандлагын талаар ерөнхий төсөөлөлтэй болоход чухал ач холбогдолтой. Түүнчлэн хүүхдүүдтэй хүрч харьцах, тэдний хөдөлгөөнийг засаж өгөх, ойр дотно харилцаа холбоо тогтоож өгөх боломжийг олгодог. Оролцогчдыг бие махбодын хувьд болон сэтгэлзүйн хувьд сургалтад бэлтгэх, найрсаг таатай орчин бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Бие халаалтын төрөл бүрийн дасгалууд нь хошигнох мэдрэмж, бусдыг сонсож хүлээн авах, хүндлэх, даруу байх, дасгал сургуулилыг шаргуу хийх нь бүлгийн таатай уур амьсгал бүрдэх үндэс суурь болж өгдөг.

> **Сургалтын хэсэг:**

Зорилт:

Оролцогчдын хувьд: Эрсдэлийг тооцох, өөрийн бие бялдрыг хөгжүүлэх.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд: Оролцогчдын биеийн

хөдөлгөөнийг үргэлжлүүлэн танин мэдэх, хувь хүний ур чадвар болон сул талыг олж илрүүлэн засах, өөртөө болон бусдад анхаарал халамж тавих хандлагыг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах.

Бүлгийн доторх хүүхдүүдийн чадварын түвшин харилцан адилгүй байдаг, тэд аз турших, эрсдэлтэй алхам хийх, сонирхолтой байдаг тул сургалт, сургах үйл явцын ач холбогдол, эрсдэлтэй алхам хийхгүй байхын ач холбогдлыг сайтар таниулах хэрэгтэй.

Циркийн дасгал техникт суралцах: Циркийн дасгал техникүүд нь цирк сургалтын үндсэн хэсэг болох боловч мөн харилцааны эерэг нөхцөлийг бүрдүүлдэг. Оролцогчдын ур чадвар, хөгжлийг дэмжээд зогсохгүй дасгалжуулагчийн мэдрэмж, сургалтын эв дүйнээс шалтгаалан тухайн дасгалыг олон хувилбараар баяжуулан багийн хөгжлийг дэмжих боломжтой.

> Акробат болон тэнцвэр:

Зорилт:

Оролцогчдын хувьд: Тогтсон хязгаарыг давах, харилцан тусалбал эрсдэл аюулгүй байж болно гэдгийг ойлгох, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэх, бие бялдрын чадварыг хөгжүүлэх, зан аашаа зохицуулах чадварыг хөгжүүлэх.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд: Сургах арга барил, чадварыг хөгжүүлэх, итгэл найдвар өгөх

Бид хөгжил дэвшил гаргах тусам бэрхшээл ихэсдэг, амжилт бүтээл бүхэн өөрийгөө хүндлэх, өөртөө итгэх итгэл зэргийг хөгжүүлдэг. Үүнтэй зэрэгцэн бид бие биедээ туслах, улмаар бие биедээ итгэхийг сурдаг. Бие биедээ тусалж байгаага мэдэрч, түүндээ сэтгэл хангалуун үлдэх байдлаар бэрхшээлийг сөрөн тэмцэх чанар тэжээгддэг.

> Жонглёр

Зорилт:

Оролцогчдын хувьд: Гар, нүдний баримжааг хөгжүүлэх, өөрсдийн хэмнэлийг мэдрэх, амжилт, бүтээлийг мэдрэх

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд: Чадварыг хөгжүүлэх

Төрөл бүрийн арга техникийг ашиглан ажилласнаар бид бүх оролцогчид амжилт гаргах боломж олгодог. Жонглёрын үндэс нь хэмнэл юм. Хүн бүрийн хэмнэлийг зохицуулан уялдуулах нь аливаа ганцаарчилсан болон бүлгийн хэмнэл, акробатын хөдөлгөөнд нэн чухал байдаг. Жонглёр нь хэмнэлийг умирдах, хэмнэлийг мэдрэхэд тусалдаг.

> Нийгэмшүүлэх тоглоом

Зорилт:

Оролцогчдын хувьд: Дарамт, стрессээ барих, багасгах, бүтээлч байдлыг хөгжүүлэх, харилцан ажиллах, итгэлцлийн харилцааг хөгжүүлэх, жүжигчний орон зайтай танилцах

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд: Аливаад харьяалагдах, хамаарагдах мэдрэмжийг хөгжүүлэх, хүүхдүүдийн хоорондох харилцаа холбоо, уур амьсгалыг ажиглах. (Сонгож авсан тоглоомоос шалтгаалан зорилт өөрчлөгдөнө)

Өөр өөр зорилт бүхий өөрөө өөрийгөө, бусдыг, цаг хугацааг болон жүжиглэн тоглох орон зайг мэдрэх чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн олон төрлийн тоглоомыг сонгон авч тоглуулах нь чухал юм. Эдгээр тоглоомыг зөвхөн цирк, урлагийн ач холбогдлыг харгалзан үзээд зогсохгүй мөн бэрхшээлийг сөрөн тэмцэх чанарыг хөгжүүлэх байдлыг нь харгалзан үзэх хэрэгтэй. Мөн Төрөл бүрийн сэдвийг агуулсан тоглоом тоглох нь оролцогчдыг өөр хоорондоо нэгдэн нягтрах, үерхэж нөхөрлөхөд нь төдийгүй хамт олонч, нийтэч болж төлөвшихөд нь тустай.

> Дүр бүтээх

Зорилт:

Оролцогчдын хувьд: Бие бялдар, биеэр илэрхийлэх боломжийн талаар ойлголтой болно. Өөр өөр хэмнэлттэй танилцана. Амьсгал авах гаргахыг ухамсартайгаар мэдэрч гүйцэтгэх, сэтгэл хөдлөлийн ертөнцийг танин мэдэх, хамгаалагдсан орчинд оршин тогтнох өөр арга замыг хайх, бүтээлч байдлыг хөгжүүлэх, цаг хугацаа, орон зайг мэдрэх.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд: Жүжиглэлээр дамжуулан боломж бололцоог өргөжүүлэх.

Дүр бүтээх нь бие бялдар, сэтгэл хөдлөл, үйл хөдлөлд орох усад арга хэлбэрийг мэдрэх боломж олгодгоороо тун ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Энэ нь өөрсдийнхөө тухай төсөөллийг орхин дотоод сэтгэлтэйгээ тулж уулзахад хүргэдэг дасгал юм.

> Тайвшруулах дасгал

Оролцогчдын хувьд: Хийж дуусгасан дасгалаа өөрийн болгох, бие бялдраа мэдрэх

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд: Амрах явцад учрах бэрхшээл саадыг тодорхойлох, эерэг таамаглалыг бий болгох

Тодорхой зааврын дагуу амрах үйл ажиллагаа нь оролцогчдод бие бялдрын урд нь төдийлөн мэдэрч байгаагүй тогтоц байдлыг мэдрэх боломж олгоно. Сургалтын туршид идэвхтэй байсан оролцогчдыг тайвшруулах дасгал хийлгэснээр тэдэнд амрах боломжийг олгодог. Дасгалаар дамжуулан тэдэнд өөрийн бие махбодыг илүү сайн мэдрэх, бусадтай ойр байх, бусдыг мэдрэх боломжийг олгодог.

Оролцогчдоос сургалтын хамгийн хөгжилтэй, уялдаа зохицолтой байсан мөчийг эргэн дурсахыг, түүнийгээ ойн дунд урсаж буй цэнгэг горхи гэх мэт өөр зүйлээр дүрслэн бодохыг хүснэ. Тэд юуг дүрслэн бодохоо өөрсдөө шийдэх бөгөөд дараа нь тэд хэрэгтэй үедээ түүнийг сэргээн санаж байхыг санал болгоно. Яваандаа энэ нь бүтээх үйл явцад тус дэм болж өгдөг.

> Сургалтын дүгнэлт/хаалт

Зорилт

Оролцогчдын хувьд: Сургалтын явцад сурсан мэдсэнээ илэрхийлэх, өөрсдийн дүгнэлтээ танилцуулах.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд: сонсох, ажиглалтаа үгээр илэрхийлэх, урам зориг өгөх, оролцогч бүхний амжилт, анхаарвал зохих талыг нэгтгэн дүгнэх.

Өөрчлөн сайжруулах, өөрчлөлтийн үйл явцыг дэмжих үүднээс сургалтын дараах үйл ажиллагааг санал болгох.

Энэ бол тухайн өдрийн сургалтын талаарх оролцогчдын болон дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын санал сэтгэгдэл туршлагыг хуваалцах чухал цаг мөч юм. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудын хувьд энэ нь нийт бүлэгт болон хувь хүмүүст талархсан сэтгэгдлээ илэрхийлэх, сургалтын оргил үеийг тодотгон дурсах, хүн болгоны амжилт болон гаргасан ахиц, дэвшлийг онцлон тэмдэглэхэд тохирсон мөч юм.

Сургалтад оролцогчдоос нэг нэгээр нь тэдний хувьд юу хамгийн чухал байсан талаар асууж, тэднийг зүгээр санал сэтгэгдэл болон дотроо юу мэдэрснээ илэрхийлж сурахад нь тус дөхөм болно. Мөн тэд багийн ажиллагааны өсөлтийг хэрхэн дүгнэж байгаа талаар мэдээлэл авах боломжтой. Түүнчлэн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтны өөрийн ажилд хэрэгцээт мэдээллийг тэднээс олж авдаг.

СЭДЭВ 4.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК СУРГАЛТЫГ ЗААХ АРГАЗҮЙН ЗӨВЛӨМЖ

Суралцагчдыг байнга сэдэлжүүл

1. **Сургалтын аюулгүй орчныг бүрдүүлэх:** Энэ нь чөлөөтэй байх, хүмүүсийн дунд өөрөөрөө байх хамгийн эхний нөхцөл юм. Суралцагчид бие махбодь болон сэтгэл санааны хувьд гэмтэхээс айхгүй байх, гэмтэхгүй байх тийм орчин бүрдүүлнэ. Ойр дотно, нээлттэй уур амьсгал бүрдүүлэх зорилгоор сургагч багш нар бүлгийн хөгжилд анхаарна.
2. **Оролцогчдын суралцах хэлбэр, сонирхлыг харгалзах:** Хичээлийн агуулга суралцагчдын өмнөх мэдлэг болон тэдний суралцах хэлбэр, хэрэгцээнд тохирсон байна. Дасгалжуулагч багш нар суралцагчдын ялгааг хүлээн зөвшөөрөх ёстой. Учир нь оролцогч бүр өөрийн гэсэн сурах арга барил, сонирхолтой байдаг. Тиймээс дасгалжуулагч багш заан сургах олон төрлийн стратегийг хэрэглэх ёстой. Түүнчлэн хувь оролцогч, түүний хэрэгцээг мөн анхаарч байвал зохино.
3. **Шийдвэр гаргахад оролцогчдыг оролцуулах:** Тэд сурч буй зүйлийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлагаа мэдвэл эсвэл хичээлээ хэрэгцээ,

сонирхолдоо нийцүүлэн өөрчлөх боломж тэдэнд нээлттэй байвал тэдний суралцах сэдэл байнгын идэвхтэй байна. Мөн тэд тасралтгүй үргэлжлүүлэн суралцахыг хүснэ. Сэдэл гэдэг нь оролцогчийн өөрийнхөө төлөө тавьсан зорилготой нягт холбоотой зүйл юм. Тиймээс дасгалжуулагч багш нар эргэцүүлэн дүгнэх, үнэлэх, зөвлөгөө өгөх, хэлэлцэх тодорхой цаг гаргаж байх хэрэгтэй. Мөн аливаа өөрчлөлтөд уян хатан, нээлттэй байх нь зүйтэй.

Заан сургах үйл ажиллагааг дэмжих: Эерэг, дэмжсэн хэлбэрийн хариу үйлдлийг багшаас үзүүлнэ. Амжилтыг сайшааж, сурсан зүйл болон хувь оролцогчийн зан чанарт гарсан эерэг өөрчлөлтийг бүлгийн дотор хэлэлцэж байвал зохино.

Суралцагчдыг сэдэлжүүлэх аргууд

- Оролцогчдын ур чадварын одоогийн түвшин болон түүний ахицыг урамшуулах
- Зааж сургаж буй зүйлдээ нягт нямбай, хичээнгүй хандах
- Зорилгоо байнга давтах
- Ялгаатай аргаар ажиллах
- Эерэг, дэмжсэн хариу үйлдэл үзүүлэх
- Оролцогч бүрийн хувьд сонирхолтой дасгалуудыг тогтоох
- Хүнд төвөгтэй дасгалуудыг хэрэглэх
- Суралцагчдад өөрсдийн ахиц амжилтаа мэдэхэд нь туслахын тулд үнэлгээний ялгаатай арга хэрэгслүүдийг хэрэглэх

Сургалтын хурдыг тохируулах

Сургалтад оролцогч бүрийн аливаа зүйлийг сурах, хүлээн авах хурд харилцан адилгүй байдаг. Сургалтыг оролцогчдод тохиромжтой хэлбэрээр явуулахын тулд тэднийг ядрах эсвэл сонирхол буурах үеэр нь хийлгэх ямар нэгэн сонирхолтой зүйлийг төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл тоглоом, дасгал, бүтээлч үйл ажиллагааны нөөцтэй байх хэрэгтэй.

Дасгалжуулагч багш нар дасгал хөдөлгөөн, тоглоомыг хэрхэн хийхийг оролцогчдод тайлбарлах зааварчилгаа нь:

- Бодитой байх
- Товч бөгөөд тодорхой байх
- Бүрэн гүйцэд байх
- Ойлгомжтой байх
- Итгэл, хүндлэл төрүүлэхүйц байх шаардлагатай.

НОМ ЗҮЙ

- Лафортун.М, 2001, Циркийн дасгалжуулагч, түншүүдэд зориулсан гарын авлага
- Лавуа. К, Массе. И. 2012, Оролцогчдод зориулсан гарын авлага. Нэгдүгээр хэсэг
- Лавуа. К, Массе. И. 2012, Оролцогчдод зориулсан гарын авлага. Хоёрдугаар хэсэг
- Морели. Д, Лафортун.Т. 2001, "Галт шувуу" Нийгэмшүүлэх циркийн сургагч багш нарт зориулсан сургалтын хөтөлбөр
- Фортан. А, Коран. М. А., Левеск. М. 2001, Дасгалын ном: Сургалтын гарын авлага
- О. Мягмар, Т. Цэндсүрэн, М. Нямдорж, Я. Нарангэрэл "Нийгмийн ажлын практик аргууд" Улаанбаатар. 2002 он
- Д. Эрдэнэчулуун 2012, "Хүүхдийг судлах аргазүй" Хоёр дугаар дэвтэр
- С. Энхтуяа, Хүүхэд хамгааллын үндэс. Улаанбаатар 2009 он
- Michel Lafortune and Annie Bouchard, 2011, Community worker's guide, When Circus Lessons Become Life Lessons.
- Hikka Hyttinen, Sofia-Charlotta Kakko, Piia Karkkola, Riikka Astrand, 2011, Social circus- a guide to good practices,
- Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа. УБ 2014, Нийслэлийн Хүүхэд гэр бүл, хөгжлийн газар, Mongolian marketing consulting group
- Хүүхдийг Ивээх Сан, УБ 2015, Хүүхдийн төлөө 20 жил-20 дэвшилт санаачлага